

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас:51-260512 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас:51-260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn Ахлах аудитор: О.Баярмаа Утас: 51-261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn Ахлах аудитор: П.Батцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: battsetsegp@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхжин Утас: 51-261740 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51- 261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: С.Алтанхуяг Утас: 51- 261740 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхбулган Утас: 51- 261740 Цахим хаяг: munkhbuganch@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 51- 261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn Аудитор: П.Ариунзаяа Утас: 51- 261740 Цахим хаяг: ariunzayap@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшсүрэн Утас: 51- 261740 Цахим хаяг: tegshsurenb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	8
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	8
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	9
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	16
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	16
3.6 Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл	18
3.6.1 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл	18
3.6.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.5.1 Завсрын аудитын талаар	25
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	28
5.1 Төлбөрийн акт	28
5.2 Албан шаардлага	28
5.3 Зөвлөмж	49
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	55
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	55
6.2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	76

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗЗА	Авто замын засвар арчлалт
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДТС	Дулаан түгээх сүлжээ
ЗСБНХОУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улс
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НЭҮХАА	Нэг эх үүсвэрээр худалдан авах арга
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ-ЫН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Г.ЁНДОН
ТАНАА

2026.03.16 № 638
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй **262,898.7** сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 223,160.1 сая төгрөгөөр давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Эрдэнэс Монгол ХХК-тай менежментийн гэрээ байгуулж менежментийн үйлчилгээний төлбөрт 20,000.0 сая төгрөг төлсөн боловч дээд газрын шийдвэрээр бизнес төлөвлөгөөнд тусгуулах замаар нэгдлийн харьяа охин компаниудын алдагдлыг нөхөх, хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 13,575.2 сая төгрөгийг санхүүлсэн байгаа нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, эдийн засгийн өрсөлдөөний зарчмаар ажиллах нөхцөлийг бууруулах нөхцөл үүссэн;
- Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээгээр зөвшөөрөгдөөгүй, чиг үүрэгт заагдаагүй бүтцийн 7 нэгж, түүнд харьяалах 791 албан хаагчийг бүтцэд баталж, тайлант онд 16,566.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн;
- Санхүүгийн тайланд 110,677.6 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал/тооцооны үлдэгдэл байгаагаас 48.8 хувь буюу 53,970.3 сая төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга үүссэн байна. Үүнээс 2004-2021 оны хооронд 98 бэлтгэн

нийлүүлэгчийн гэрээт ажлын урьдчилгаанд төлсөн 21,142.7 сая төгрөгийн ажлын гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаас 94 бэлтгэн нийлүүлэгчийн 20,256.3 сая төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга үүссэн бөгөөд авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй;

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын данс бүртгэлд тусгаагүй эзэмших, ашиглах эрхтэй газар, орон сууцтай холбоотой нийт 27,112.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн;
- Нэг эх үүсвэрээс худалдан авалт хийхдээ албан ёсны эрхийг төлөөлж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулсан туршлага, тендер шалгаруулалтад оролцсон, гүйцэтгэсэн ажлын үр дүн, эрхээ хязгаарлуулсан эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан эсвэл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд эсэхийг магадалж, цаашид нийлүүлэгчээс шалтгаалсан үйлдвэрт учирч болзошгүй эрсдэлийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээг үйл ажиллагаанд ашиглах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. Нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар Беллинк ХХК-тай "Хүнд даацын өөрөө буулгагч автомашины сэлбэг"-ийг 22,944.8 сая төгрөгөөр худалдан авах гэрээг он дуустал сунгасан боловч, жилийн эцсийн байдлаар бараа материалыг дутуу нийлүүлсэн, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй;
- Үйлдвэрийн газрын бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний 1.3-т заасны дагуу +/- 5 хувийн тоо хэмжээний хэлбэлзэлтэй уялдуулан гэрээний үнийн дүнг нийт 2,551.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Дээр дурдсан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34, 25.10, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.1.3, 15 дугаар зүйлийн 15.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 16 дугаар зүйлийн 16.1-ын 1 дэх хэсэг, 20 дугаар зүйл, 20.7, 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8, Засгийн газрын 2025 оны "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 154 дүгээр тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16, Хүлээн зөвшөөрөлт 7, 7(а), (б), Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 7 дугаар зүйлийн 7.1, 7.1.9, 36 дугаар зүйлийн 36.1, 36.1.3, 36.1.4, 39 дүгээр зүйлийн 39.2, 39.3, 39.3.1, 39.3.8, 40 дугаар зүйлийн 40.1.2 заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 96 дугаар тогтоолоор Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон бизнес төлөвлөгөөг баталсан бөгөөд 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 93 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу гүйцэтгэлийг ханган ажилласан ба үйлдвэрийн газрын 2025 онд хэрэгжүүлсэн дараах ажлуудыг онцолж байна. Үүнд:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2025 онд 47.9 сая тонн хүдэр олборлож, 39.9 сая тонн хүдэр боловсруулан 582.5 мянган тонн зэс, 5.5 мянган тонн молибидены баяжмал үйлдвэрлэж 47 жилийн түүхэн дэх хамгийн өндөр буюу 4,890,490.1 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан ба улс орон нутгийн төсөвт 2,309,351.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн;
- Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн зэс молибидены ордын талбай хил заагийн хүрээнд багтаж байгаа Оюут болон бусад хэсгүүдэд эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөцийг тогтоож, ашиглалтад бэлтгэх"-ээр тусгасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын нутагт байрлах Оюут ордын нарийвчилсан хайгуулыг дуусгаж 0.32

хувийн зэсийн агуулгатай 383.5 сая тонн хүдэрт 1.2 сая тонн зэсийн геологийн нөөцийг “бодитой” (В) зэрэглэлийн түвшинд хүртэл судалсан ба тайлант онд 2,903.5 сая төгрөг зарцуулсан;

- Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 42, Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 117, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 744 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани “Эрдэнэт медиал эмнэлэг” ХХК төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийг Хойд бүсийн хавдар судлалын дэд төв болгон өөрчлөн байгуулсантай холбоотойгоор 46,769.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг данснаас хасч Хавдар судлалын үндэсний төвд шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан ажлууд хугацаандаа хэрэгжээгүй, төслүүдийг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн зэргээс шалтгаалж төслийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй болсон, улсын хэмжээнд хэрэгжих томоохон төслүүд гацсан, үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, орлого нэмэгдүүлэх зэрэг цаг хугацааны боломж алдагдсан байна. Үүнд:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Орхон аймгийн иргэдийн төлөөлөгчдын хурал Зэс эрдэнийн хувь ХХК-ийн хооронд 2015 онд байгуулсан гэрээний дагуу исэлдсэн хүдрээс катодын зэс боловсруулах үйлдвэрийг 3 жилийн хугацаанд байгуулахаар заасан боловч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй тул “Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл /2021-2022 он/-ийг шууд хөрөнгө оруулалтаар 167,371.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хэрэгжүүлэхээр тогтоолд баталсан. “Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг Майнинг шорт лонг тэрм ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээлсэн боловч ажлын гүйцэтгэл хангалтгүй, үйлдвэр ашиглах боломжгүй нөхцөл үүссэн, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн “Үүсмэл ордын талаар авах зарим арга хэмжээний тухай” 210 дугаар тогтоолоор “Эрдэнэтийн овоо” ордыг ашиглаж байгаа хувийн хэвшлийн хуулийн этгээд /Ачит Ихт ХХК-тай тус үүсмэл ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоосны дагуу түүхий эдээр хангах үйл ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-д даалгасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн төслийг хэрэгжүүлэх шаардлагагүй болсон;
- Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах төсөл /2020-2025 он/-ийн 1,495,194.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг хэрэгжүүлэхээр 2020 онд ЗВТЕС Aufberetungssysteme GmbH-тай түлхүүр гардуулах нөхцөлөөр 40.7 сая ам.доллар буюу 114,352.4 сая төгрөгийн (ханш: 2,809.64 төгрөг) төсөвт өртөгтэй ажлыг 18 сарын хугацаанд гүйцэтгэж 2023 онд хүлээлгэж өгөхөөр гэрээ байгуулсан боловч тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл

удааширсан, тээвэрлэлтэд хүндрэл гарсан шалтгаанаар 2023 онд гэрээний үнийн дүнгийн 55.6 хувийн санхүүжилт 29.3 сая ам.долларын санхүүжилтийг олгосны дараа гэрээний хугацааг 2026 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 44 сараар сунгаж, мөн үнийн дүн 12.0 сая ам.доллараар буюу 33,657.7 сая төгрөгөөр (ханш: 2,809.64 төгрөг) нэмэгдсэн, тайлант онд 23,307.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон, ажлын гүйцэтгэл 87.1 хувьтай;

- Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл /2021-2025 он/-ийг 1,628,400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хэрэгжүүлэх ажил хугацаандаа хэрэгжээгүй Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Бүтээн байгуулалтын төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 185 дугаар тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэр дэх “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хариуцан хэрэгжүүлэх “Зэс боловсруулах цогцолбор” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн хувьцаа эзэмших эрхийг Эрдэнэт үйлдвэр хэрэгжүүлэхээр тусгасан байсныг Засгийн газрын 2025 оны 185 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулахаар баталж, Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгжийн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих чиг үүрэг, орон тоо, дэд бүтцийг холбогдох баримт бичгийн хамт “Зэс боловсруулах цогцолбор” ХХК-д шилжүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д даалгасан. Төслийн техник эдийн засгийн үндэслэлийг батлуулж, хэрэгжиж эхэлж байгаа бөгөөд тайлант онд тус компанийн ажилтны цалин хөлс, тогтмол зардалд 2,139.8 сая төгрөгийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ олгосон байна.

Мөн тайлант онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дэргэдэх нийгмийн цехүүд 12,580.8 сая төгрөгийн орлого олж, 70,245.1 сая төгрөгийн зардалтай ажилласан байна. Иймд тогтвортой үйл ажиллагааг хангах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, байгалийн хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай ашиглах бодлогын хүрээнд нийгмийн цехүүдийн үйлдвэрээс авах татаасыг үе шаттай бууруулах, бие даан өөрийн орлогоор бүрэн санхүүжих, өөрсдийн онцлогт тохирсон үйл ажиллагаа явуулах асуудлыг бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Мөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын худалдан авах ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах, хүний хүчин зүйлээс үүдэлтэй алдааг бууруулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зорилгоор хиймэл оюун ухаанд суурилсан тендерийн үнэлгээний TENDerval, байгууллагын нөөц төлөвлөлтийн ERP цахим систем, хүний нөөцийн одоо ERP системүүдийг хөгжүүлж 2025 оноос эхлэн байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн бөгөөд аудитын явцад дээрх системүүдийг ашиглан худалдан авах ажиллагааны төлөвлөлт, процессын гүйцэтгэлийг шалгасан болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	36,799,102,651.29	91,886,251,090.34
1.1.2	Дансны авлага	11,528,402,557.57	26,995,129,520.41
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,266,965,651.47	177,792,485,020.60
1.1.4	Бусад авлага	5,050,207,981.11	5,637,836,103.02
1.1.6	Бараа материал	605,359,487,916.23	648,410,992,150.78
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	55,374,066,665.55	56,707,313,808.65
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	527,527,625.14	527,527,625.14
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	716,905,761,048.36	1,007,957,535,318.94
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,923,619,694,058.16	3,487,961,460,208.77
1.2.2	Биет бус хөрөнгө	2,481,453,520,095.30	2,479,143,604,861.40
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	60,746,826,142.65	15,235,194,209.26
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	76,252,598,868.12	90,068,188,960.22
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	112,721,091,075.41	88,788,423,334.41
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	1,287,860,000.09	1,287,860,000.09
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	298,162,535,497.15	243,898,654,027.72
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,954,244,125,736.88	6,406,383,385,601.87
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,671,149,886,785.24	7,414,340,920,920.81
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	177,997,053,720.12	167,601,993,527.10
2.1.1.2	Цалингийн өглөг	38,406,409,691.90	33,690,814,668.58
2.1.1.3	Татварын өр	106,241,265,052.33	600,871,628.20
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	162,713,874.85
2.1.1.5	Богино хугацаат зээл	342,031,799,863.14	88,916,500,000.00
2.1.1.6	Хүүний өглөг	581,318,789.56	21,632,281.89
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	167,981,050,813.48	205,143,446,199.96
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	57,061,878,802.00	43,366,500,652.63
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	45,396,307,419.71	110,912,660,090.80
2.1.1	Богино хугацаат өр төлбөрийн дүн	935,697,084,152.24	650,417,132,924.01
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	257,888,721,307.33	355,413,859,711.95
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	59,175,515,162.00	54,742,010,133.43
2.1.2	Урт хугацаат өр төлбөрийн дүн	317,064,236,469.33	410,155,869,845.38
2.1	Өр төлбөрийн нийт дүн	1,252,761,320,621.57	1,060,573,002,769.39
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: а) Төрийн	2,658,321,900.00	2,658,321,900.00
2.3.2	б) Хувийн	-	-
	Хувьцаат капиталын дүн	2,658,321,900.00	2,658,321,900.00
2.3.4	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.5	Дахин үнэлгээний нөөц	477,667,116,719.90	985,433,496,818.22
2.3.6	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	2,475,166,939,337.00	2,475,166,939,337.00
2.3.7	Хуримтлагдсан ашиг	2,462,896,188,206.77	2,890,509,160,096.20
2.3	Эзэмшигчдийн өмчийн дүн	5,418,388,566,163.67	6,353,767,918,151.42
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,671,149,886,785.24	7,414,340,920,920.81

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	3,941,783,553,885.15	4,854,800,678,960.68
2	Борлуулалтын өртөг	1,698,462,071,777.78	1,851,933,430,953.06
	Нийт ашиг (алдагдал)	2,243,321,482,107.37	3,002,867,248,007.62
3	Түрээсийн орлого	113,739,098.22	99,097,225.28
4	Хүүний орлого	4,189,134,595.33	4,749,067,364.75
5	Ногдол ашгийн орлого	5,466,200,375.01	-
6	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
7	Бусад орлого	22,302,994,842.81	25,444,147,246.31
8	Борлуулалтын зардал	905,872,220,840.34	1,078,909,472,391.75
9	Ерөнхий ба удирдлагын зардал	233,682,090,262.55	283,800,759,150.48
10	Санхүүгийн зардал	29,399,811,559.61	29,080,147,294.00
11	Бусад зардал	263,535,573,210.85	443,768,976,961.23
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	(19,254,967,430.77)	(32,012,104,614.70)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гарз	-	(6,634,552,583.13)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз гарз	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз гарз	-	-
17	Бусад ашиг алдагдал	771,732,474.62	6,676,704,382.99
	Татвар төлөхийн өмнөх ашиг	824,420,620,189.24	1,165,630,251,231.66
18	Орлогын татварын зардал	245,892,151,307.78	408,909,422,945.00
	Татварын дараах ашиг (алдагдал)	578,528,468,881.46	756,720,828,286.65
19	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		
20	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	578,528,468,881.46	756,720,828,286.65
21	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийг дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөврүүлэлтийн зөрүүний олз гарз	-	-
	Бусад олз гарз	-	-
22	Орлогын нийт дүн	578,528,468,881.46	756,720,828,286.65
23	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг алдагдал		

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,658,321,900.00	477,796,557,719.92	2,475,166,939,337.00	2,238,977,477,687.31	5,194,599,296,644.23
Залруулсан үлдэгдэл	2,658,321,900.00	477,796,557,719.92	2,475,166,939,337.00	2,238,977,477,687.31	5,194,599,296,644.23
Тайлант үеийн цэвэр ашиг				578,528,468,881.46	578,528,468,881.46
Өмчид гарсан өөрчлөлт				(81,707,574,320.00)	(81,707,574,320.00)
Зарласан ногдол ашиг				273,031,625,042.00	273,031,625,042.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(129,441,000.00)		129,441,000.00	-
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,658,321,900.00	477,667,116,719.92	2,475,166,939,337.00	2,462,896,188,206.77	5,418,388,566,163.70
Залруулсан үлдэгдэл	2,658,321,900.00	477,667,116,719.92	2,475,166,939,337.00	2,462,896,188,206.77	5,418,388,566,163.70
Тайлант үеийн цэвэр ашиг				756,720,828,286.65	756,720,828,286.65
Өмчид гарсан өөрчлөлт		518,426,824,036.57		(50,504,065,894.77)	467,922,758,141.80
Зарласан ногдол ашиг				289,264,234,440.73	289,264,234,440.73
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(10,660,443,938.27)		10,660,443,938.27	-
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,658,321,900.00	985,433,496,818.22	2,475,166,939,337.00	2,890,509,160,096.20	6,353,767,918,151.42

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,710,331,287,496.05	4,827,808,715,757.16
	1.1.1. Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,629,188,840,727.33	4,743,757,804,990.87
	1.1.3. Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	40,241,600.60	1,547,310,508.00
	1.1.4. Бусад мөнгөн орлого	81,102,205,168.12	82,503,600,258.29
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,104,441,424,176.91	3,802,073,886,944.10
	1.2.1. Ажиллагчдад олгосон цалин, урамшуулал	481,038,424,680.88	486,841,664,180.32
	1.2.2. Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	117,800,000,000.00	123,700,200,000.00
	1.2.3. Бараа материал худалдан авахад төлсөн	306,300,207,773.44	345,668,293,330.57
	1.2.4. Ашиглалтын зардалд төлсөн	348,486,977,904.92	426,149,592,608.94
	1.2.5. Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	432,504,533,354.28	391,323,150,697.44
	1.2.6. Төлсөн хүү	2,719,917,979.54	20,001,920,246.17
	1.2.7. Татварын байгууллагад төлсөн	1,158,444,691,857.51	1,893,985,390,553.44
	1.2.8. Даатгалын төлбөрт төлсөн	123,195,435.94	3,981,323,871.04
	1.2.9. Бусад мөнгөн зарлага	257,023,475,190.40	110,422,351,456.18
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	605,889,863,319.14	1,025,734,828,813.06
2	Хөрөнгө оруулалтын үйл ажилгааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,295,001,425.01	7,979,164,578.08
	2.1.2. Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	4,921,112,500.03	475,800,000.00
	3.1.3. Хүлээн авсан хүүний орлого	2,452,165,687.48	2,639,579,178.08
	2.1.4. Хүлээн авсан ногдол ашиг	4,921,723,237.50	4,863,785,400.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	547,906,549,319.05	442,099,238,465.83
	2.2.1. Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	524,956,468,055.22	424,822,546,312.11
	2.2.2. Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,702,794,070.00	175,000,000.00
	2.2.3. Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн /тэзү/	18,154,025,721.14	13,970,883,039.52
	2.2.4. Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /геологи хайгуул/	2,093,261,472.69	3,130,809,114.20
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(535,611,547,894.04)	(434,120,073,887.75)
3	Санхүүгийн үйл ажилгааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	273,933,728,232.46	194,891,138,701.73
	3.1.1. Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	272,641,460,000.00	193,592,350,000.00
	3.1.2. Хүү ба урамшууллын орлого	1,292,268,232.46	1,298,788,701.73
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	355,244,891,420.00	732,339,626,155.33
	3.2.1. Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		392,666,450,112.20
	3.2.3. Төлсөн ногдол ашиг /	355,244,891,420.00	339,673,176,043.13
3.3	Санхүүгийн үйл ажилгааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(81,311,163,187.54)	(537,448,487,453.60)
4	Валютын ханшийн зөрүү	331,345,229.11	920,880,967.34
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(10,701,502,533.33)	55,087,148,439.05
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	47,500,605,184.62	36,799,102,651.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	36,799,102,651.29	91,886,251,090.34

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Үйлдвэрлэл, эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйц	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:									
1	Зэсийн баяжмал	сая.төг	3,530,539.5	3,944,108.3	4,439,897.9	909,358.4	79.5	(495,789.6)	112.6
	Молибдены баяжмал	сая.төг	345,173.1	316,206.1	345,275.2	102.1	100.0	(29,069.1)	109.2
	Бусад таваарын бүтээгдэхүүн	сая.төг	66,070.9	66,335.6	69,627.5	3,556.6	94.9	(3,291.9)	105.0
	Бусад орлого	сая.төг	32,072.1	34,821.7	35,689.4	3,617.3	89.9	(867.7)	102.5
2	Нийт орлого	сая.төг	3,973,855.6	4,361,471.8	4,890,490.1	916,634.5	81.3	(529,018.3)	112.1
3	Нийт зардал	сая.төг	3,149,435.0	3,534,484.6	3,724,859.9	575,424.9	84.6	(190,375.3)	105.4
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	1,698,462.1	1,891,851.7	1,851,933.4	153,471.3	91.7	39,918.3	97.9
	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	сая.төг	837,716.7	882,234.3	1,007,747.7	170,031.0	83.1	(125,513.4)	114.2
	Борлуулалт маркетингийн зардал	сая.төг	68,155.5	78,924.5	71,161.7	3,006.2	95.8	7,762.8	90.2
	Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	233,682.1	300,198.9	283,800.7	50,118.6	82.3	16,398.2	94.5
	Үйл ажиллагааны бус нийгмийн шинжтэй болон бусад зардал	сая.төг	311,418.6	381,275.2	510,216.4	198,797.8	61.0	(128,941.2)	133.8
4	Татварын өмнөх ашиг	сая.төг	824,420.6	826,987.2	1,165,630.2	341,209.6	70.7	(338,643.0)	140.9
5	Цэвэр ашиг	сая.төг	578,528.5	557,614.3	756,720.8	178,192.3	76.5	(199,106.5)	135.7
6	Төсвийн төлбөрт нийт дүн	сая.төг	1,548,964.8	1,473,658.6	2,020,086.7	471,121.9	76.7	(546,428.1)	137.1
7	Төрийн өмчийн ногдол ашиг	сая.төг	273,031.6	289,264.2	289,264.2	16,232.6	94.4	-	100.0
8	Нийт ажиллагчдын тоо	хүн	6,910	7,196	6,687	(223)	103.3	509	92.9
9	Нийт цалингийн сан	сая.төг	492,617.0	520,245.7	512,215.0	19,598.0	96.2	8,030.7	98.5
13	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мөнгө	72.00	72.88	66.22	(5.78)	108.7	6.7	90.9
14	Хөрөнгө оруулалт	сая.төг	627,772.2	1,023,855.2	525,912.3	(101,859.9)	119.4	497,942.9	51.4
15	Нийт авлага	сая.төг	101,369.6		293,010.4	191,640.8	34.6		
	Үүнээс: НАХасагдуулга	сая.төг	(82,524.0)		(82,584.9)	(60.9)	99.9		
	Нийт өглөг	сая.төг	1,252,761.3		1,060,573.0	(192,188.3)	118.1		
16	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	935,697.1		650,417.1	(285,280.0)	143.9		
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	317,064.2		410,155.9	93,091.7	77.3		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь зорилгоо "нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт үзэл баримтлалыг эрхэмлэж, ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээгээ хангах боломжийг хязгаарлахгүйгээр оролцогч талуудын, ялангуяа бүс нутгийн оршин суугч иргэдийн эрхийг дээдэлсэн, байгаль орчин, хүн амьтны бие махбодод хор хохиролгүй, мэдлэг, туршлагад тулгуурласан, хууль ёсонд нийцсэн, ил тод үйл ажиллагаа явуулж, хөгжлийн үр шимийг хүн бүхэнд хүргэхэд оршино" гэж тодорхойлсон байна.

Эрдэнэтийн-Овооны зэс, молибдены ордыг ашиглах талаар БНМАУ болон ЗСБНХОУ-ын Засгийн газартай байгуулсан түүхэн хэлэлцээрийг 1973 оны 02 дугаар сарын 20-ны өдөр байгуулж байжээ.

Монгол-Зөвлөлтийн хамтарсан уул уурхайн баяжуулах Эрдэнэт үйлдвэр БНМАУ болон ЗСБНХУ-ын Засгийн газартай 1973 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хэлэлцээрийн дагуу анх 50:50 хувийн эзэмшилтэйгээр байгуулагдаж, 1991 оны хэлэлцээрээр 51:49 хувийн эзэмшилтэй хамтарсан үйлдвэр, 2003 оны хэлэлцээрээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллаж байгаад 2016 оны 6 дугаар сард Оросын Холбооны Улсын Ростех корпорац өөрийн эзэмшлийн 49.0 хувийг худалдсанаар Засгийн газар 51.0 хувийг, Монголиан коппер корпорейшн ХХК 49.0 хувийг эзэмшиж байжээ.

Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 102 дугаар тогтоолоор Эрдэнэт үйлдвэрийг Төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг баталсан бөгөөд 2022 оны 427 дугаар тогтоолоор дүрэмд өөрчлөлт оруулан Эрдэнэс Монгол ХХК-ийн нэгдлийн харьяа компани болсон байна.

Дүрэмд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар тодорхойлжээ. Тухайлбал:

- Хүдэр олборлох, боловсруулах, баяжмал үйлдвэрлэх;
- Хүдэр болон баяжмалаас металлургийн аргаар эцсийн бүтээгдэхүүн гаргаж авах;
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геологи, хайгуулын ажил явуулах, ашигт малтмалын орд газрыг эзэмших, ашиглах;
- Дулаан, цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх;
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулах;
- Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техникийн шинэчлэл хийх, металлургийн болон химийн үйлдвэрлэл эрхлэх, хөгжүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлэх;
- Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа.

Хууль тогтоомжоор хориглоогүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бизнесийн үйл ажиллагаа эрхэлж болно гэж заасан байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай, өмчийг 100.0 хувь төр эзэмшдэг, одоогоор Эрдэнэс Монгол ХХК-ийн нэгдлийн харьяанд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулиудыг мөрдөж ажилласан, дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болгосонд тооцох тухай;
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

- Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль.

Мөн тайлант онд Улсын Их Хурал, Засгийн газар болон дээд газруудаас гаргасан дараах шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Засгийн газрын 109, 132, 229, 94, 135, 191, 204, 210, 279, 28, 285, 42, 117 дугаар тогтоол, 01, 09, 3, 13, 16, 11, 4, 14, 16, 17, 18, 107, 30, 27 дугаар хуралдааны тэмдэглэл;
- Ерөнхий сайдын 10, 09, 38, 45, 34, 57, 60, 100 дугаар захирамж, 02, 04, 05 дугаар албан даалгавар;
- Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ын 01, 09, 95, 96, 27, 02, 59, 70, 86, 87, 93, 94, 95, 105, 99, 100, 101 дүгээр тогтоол, Ерөнхий захирлын А/57, А/138 дугаар тушаал;
- ТӨБЗГ-ын 87, 477, 494, 618, 744, 745;
- Эрчим хүчний зохицуулах хорооны 58 дугаар тогтоол.

Ерөнхий захирлын тайланд онд баталсан дараах журмуудыг мөрдөн ажилласан байна. Үүнд:

- Үнэлгээний хорооны зөвлөмжид захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх журам;
- Ногоон хөгжлийн төслийн нэгжийн үйл ажиллагааны журам;
- Цалин хөлс, олговрын тухай журам;
- Ажилтнуудыг ажлын үр дүнгээр урамшуулах, шагнах тухай журам;
- Ажилтанд ур чадварын нэмэгдэл олгох тухай журам;
- Бүтцийн нэгжүүдийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо бүрдүүлэх журам;
- Төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, сургуулийн дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн шаардлага, стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төслийг санхүүжүүлэх, төлбөр тооцоо гүйцэтгэх түр журам;
- Засгийн газрын 2025 оны 191 дүгээр тогтоолын дагуу төлбөр тооцоо гүйцэтгэх түр журам
- Энэрэл ирээдүй сангийн үйл ажиллагааны журам;
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захиргаа, ҮЭ-ийн холбооны хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний нэмэлт өөрчлөлт;
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захиргаа, ҮЭ-ийн холбооны хооронд байгуулсан 2026-2027 онд хэрэгжүүлэх хамтын гэрээ;
- Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын гэрээ байгуулах, бүртгэх, албан хэрэгцээнд ашиглах, дүгнэх журам.

Төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзсэн.

Дотоод хяналт, мониторингийн хэлтэс төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд дотоод хяналт, шалгалт, шинжилгээ-үнэлгээ /мониторинг/ хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зөвлөмж боловсруулж, үнэн, бодит мэдээллээр удирдлагыг хангах зорилгын хүрээнд ажилладаг.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2025 оны “Зарим бүтцийн нэгжийн бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” А/15 дугаар тушаалаар Дотоод хяналт, мониторингийн хэлтсийг Стандарт, эрсдэлийн нэгдсэн удирдлагын алба, Хяналт шалгалт, мониторингийн албатай болгон бүтэц, орон тоог шинэчлэн баталж, А/126 дугаар тушаалаар “Дотоод хяналт, мониторингийн хэлтсийн үйл ажиллагааны журам”, А/384 дүгээр тушаалаар “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хяналт шалгалт зохион байгуулах журам”, Дотоод хяналт шалгалтын стандарт”, А/86 дугаар тушаалаар “Стандарт, чанар, итгэмжлэлийн төлөвлөгөө болон дотоод аудитын хөтөлбөр батлах тухай” -ыг тус тус баталсан байна.

Тайлант онд Дотоод хяналт, мониторингийн хэлтэс нь эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, үйлдвэрийн газрын хэмжээнд олон улсын менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх,

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, дотоод хяналтын эрх зүйн орчин, үйл ажиллагааг боловсронгуй болгож тогтолцоог сайжруулах, үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулахад бодит хувь нэмэр оруулах, хяналт шалгалт, стандарт, эрсдэлийн нэгдсэн удирдлагын үйл ажиллагааг сурталчлах, ажилтнуудыг мэргэшүүлэх, чадавхжуулах зорилтуудыг дэвшүүлж, нийт 31 ажил, арга хэмжээг үйлдвэрийн газрын бүх бүтцийн нэгжүүдийг хамруулан хамтран зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнан ажилласан байна.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлуудаас дурдвал:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2020-2023 оны хөрөнгө оруулалтын захиалга, худалдан авалт, бараа, ажил, үйлчилгээний худалдан авах гэрээний хэрэгжилт, гэрээний төлбөр тооцоо, үүссэн өр, авлагын байдалд хийсэн хяналт шалгалтын ажил;
- Үйлдвэрийн газрын 2025 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогод түүвэрчилсэн хяналтын тооллого хийж гүйцэтгэсэн;
- Үйлдвэрийн газрын 2025 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын ажил;
- Үйлдвэрийн газрыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хяналт, шалгалт зэрэг Ерөнхий захирлаас өгсөн үүрэг даалгавар, албан бичгийн дагуу санал, дүгнэлт гаргах 21 асуудалд хяналт, шалгалтын ажлыг гүйцэтгэж, тайлагнасан байна.

Аудитаар ерөнхий захирлын “Хяналт шалгалт хийх тухай” А/326, А/723, А/507, А/517 тушаалуудаар баталсан Эрдэнэт, үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн шалгалт, Үйлдвэрийн газрын 2031 он хүртэл хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт хийсэн шалгалт, үйлдвэрийн газрын 2025 оны эд хөрөнгийн тооллого, 2024 оны худалдан авах ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын ажлуудтай холбоотой хэрэгжүүлсэн ажлын тайлантай танилцсан.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ерөнхий захирлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/807 дугаар тушаалаар баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллахаар боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн, үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 743,191.0 сая төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	36,799,102.6	91,886,251.1	55,087,148.5
Авлага	18,845,576.2	210,425,450.6	191,579,874.4

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Бараа материал	605,359,487.9	648,410,992.2	43,051,504.3
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	55,374,066.7	56,707,313.8	1,333,247.1
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	527,527.6	527,527.6	-
Үндсэн хөрөнгө	2,923,619,694.0	3,487,961,460.2	564,341,766.2
Биет бус хөрөнгө	2,481,453,520.1	2,479,143,604.9	(2,309,915.2)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	60,746,826.1	15,235,194.2	(45,511,631.9)
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	76,252,598.9	90,068,189.0	13,815,590.1
Хойшлогдсон татварын хөрөнгө	112,721,091.1	88,788,423.3	(23,932,667.8)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	1,287,860.0	1,287,860.0	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	298,162,535.5	243,898,654.0	(54,263,881.5)
Нийт хөрөнгө	6,671,149,886.7	7,414,340,920.9	743,191,034.2
Богино хугацаат өр төлбөр	935,697,084.1	650,417,132.9	(285,279,951.2)
Урт хугацаат өр төлбөр	317,064,236.5	410,155,869.9	93,091,633.4
Өмч: Төрийн	2,658,321.9	2,658,321.9	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	477,667,116.7	985,433,496.8	507,766,380.1
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	2,475,166,939.3	2,475,166,939.3	-
Хуримтлагдсан ашиг	2,462,896,188.2	2,890,509,160.1	427,612,971.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,671,149,886.7	7,414,340,920.9	743,191,034.2

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт, хайгуул ба үнэлгээний хөрөнгө, хойшлогдсон татварын хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөр, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хуримтлагдсан ашиг данснуудад материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 91,886.2 сая төгрөг болж, 55,087.1 сая төгрөгөөр өссөн нь арилжааны банк дах ам.долларын 3 харилцах дансны үлдэгдэл 21,170.2 сая төгрөг, төгрөгийн 5 харилцах дансны үлдэгдэл 32,666.8 сая төгрөг, банкин дах хугацаатай хадгаламж 7,276.0 сая төгрөг, касс дахь бэлэн мөнгө 19.7 сая төгрөг, замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 210,425.4 сая төгрөг болж, 191,579.9 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал,

- Татвар, НДШ-ийн авлага 177,792.5 сая төгрөг болж 175,525.5 сая төгрөгөөр өссөн нь төсөвт төлөх татварыг бүрэн төвлөрүүлэх, 2026 оны татварын ноогдлыг урьдчилж төлөх чиглэлийг холбогдох төрийн байгууллагуудаас ирүүлсний дагуу татварыг урьдчилж төлснөөс шалтгаалсан;
- Дансны авлага 26,995.1 сая төгрөг болж, 15,466.7 сая төгрөгөөр өссөн нь худалдан авагч тал экспортолсон бүтээгдэхүүний 3 худалдан авагчаас авах авлага 10,566.5 сая төгрөг /Үүнд: Кинг Файн, Стардаст инвестмент трейд, Миллифорд/, 3 аж ахуйн нэгжтэй холбоотой дотоод борлуулалтын авлага 7,625.9 сая төгрөгөөр /Дулааны цахилгаан станц, Эрдэнэт ус, Диспетчерийн үндэсний төв/ нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Хугацаа хэтэрсэн авлага 14,929.2 сая төгрөг болж өмнөх оноос 9,794.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Өргөө хаан констракшн ХХК-аас “Уурхайчин-2” 600 айлын орон сууцны хороолол барих ажлын хууль, хяналтын байгууллагад шилжсэн 9,766.3 сая төгрөгийн авлагыг бүртгэснээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 648,411.0 сая төгрөг болж, 43,051.5 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал,

- Тайлант оны худалдан авсан 1,983,910.3 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 1,940,858.8 сая төгрөгийн бараа материалыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зарцуулсан;
- Түүхий эд материал 48,335.6 сая төгрөгөөр өссөн нь үйлдвэрлэлийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах үндсэн технологийн материал 42,000.7 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 11,503.9 сая төгрөгөөр нэмэгдсэн;

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

- Дуусаагүй үйлдвэрлэл 5,301.4 сая төгрөгөөр өссөн нь зэсийн болон молибдены баяжмалын дуусаагүй үйлдвэрлэлийн тоо хэмжээ оны эхэнд 174.4 тн байснаас оны эцэст 274.4 тн болж 100.0 тн-оор өссөн;
- Бэлэн бүтээгдэхүүн 13,683.8 сая төгрөгөөр өссөн нь олборлож боловсруулсан зэсийн баяжмал оны эхнээс 31,800.0 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Барааны үлдэгдэл 21,719.5 сая төгрөгөөр буурсан нь ган бөөрөнцөг Ф40, Ф80, Ф100 үлдэгдэл 25,467.6 сая төгрөгийн материалыг үйлдвэрлэлд зарцуулсантай холбоотой;
- Хангамжийн материал 2,528.1 сая төгрөгөөр буурсан нь ХАБЭА-ын хувцас, хамгаалах хэрэгсэл, батарейт импакт, радио станц зэргийг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан;
- Бусад материал 21.7 сая төгрөгөөр буурсан нь үйлдвэрлэлийн данс бүртгэлд бүртгэлтэй мал амьтдыг үйлдвэрийн хүнсэнд ашиглах болон малын хорогдол зэрэг голлон нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,487,961.5 сая төгрөг болж, 564,341.8 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хүрээнд худалдан авсан 294,973.1 сая төгрөг, дуусаагүй барилгын дансанд бүртгэлтэй 410 ширхэг хөрөнгийг ашиглалтад оруулж, үндсэн хөрөнгөд бүртгэсэн 160,129.9 сая төгрөг, их засвар, шинэчлэлийн ажилтай холбоотой 30,582.6 сая төгрөг, хандив тусламжаар хүлээн авсан 34.7 сая төгрөг, өр төлбөрт тооцон хүлээн авсан 460.0 сая төгрөг, Эргэлтийн хөрөнгө болон дараа тайлангийн данснаас машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшлыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн 1,299.7 сая төгрөг, уул уурхайн зориулалттай 467.4 сая төгрөгийн хөрөнгүүд тус тус нэмэгдсэн, ТӨБЗГ-ын 2024 оны 692 дугаар тогтоолоор нийт 1241 нэр төрлийн 45,463.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж, ТӨБЗГ-ын 2024 оны 682, 2025 оны 377, 494 дүгээр тогтоолоор нийт 66 нэр төрлийн 6,040.6 сая төгрөгийн хөрөнгийг Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК, Булган АЗЗА ТӨХК, Орхон, Сэлэнгэ, Булган аймгийн Орон нутгийн өмчийн газар, Онцгой байдлын газар, Политехник коллеж, хорих анги, ХААИС-ийн Мал эмнэлгийн сургууль зэрэг байгууллагад шилжүүлэн өгсөн, хэрэгжиж буй төсөл, барилга угсралтын ажлуудын хүрээнд тоног төхөөрөмж, эд хөрөнгийг суурилуулалт, угсралтад 3,110 нэр төрлийн 174.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дуусаагүй барилгын ангилалд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалсан байна.

Мөн тайлант онд Тэгшхэм групп үнэлгээ ХХК-тай 549.8 сая төгрөгийн гэрээ байгуулан барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй нийт 1592 нэр төрлийн 1,080,776.3 сая төгрөгийн хөрөнгүүдэд дахин үнэлгээ хийлгэн барилга байгууламжийг хөрөнгийн үнэлгээг 468,672.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл 466,180.3 сая төгрөг болж, 84,022.7 сая төгрөгөөр өсөхөд үйлдвэрлэлийн цехүүд 87,339.9 сая төгрөг, бусад ажлын дүн 37,451.9 сая төгрөг, нийгмийн цехүүд 1,960.8 сая төгрөг, нийт 126,752.6 сая төгрөгөөр нэмэгдэж, төсөл хөтөлбөрүүдийн 42,106.7 сая төгрөг, нийтлэг үйлчилгээний цехүүдийн 623.1 сая төгрөг, нийт 42,729.9 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна. Тухайлбал:

- Үйлдвэрлэлийн цехүүд дуусаагүй барилга 87,339.9 сая төгрөгөөр нэмэгдэхэд Хүдэр бэлтгэлийн I шугамыг шинэчлэх ажил 170,117.6 төгрөг, Баяжуулах үйлдвэр 101,255.1 сая төгрөг, Олон улсын стандартын шаардлага хангасан лабораторийн зориулалттай шинэ барилга барих ажил 15,127.7 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч, Хам баяжуулалтын секцийг 12 сая тн хүдэр боловсруулах хүчин чадалтай болгон шинэчлэх ажил 78,728.3 сая төгрөг, Засвар механикийн заводын цутгуурын цехийн элчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл шинэчлэлийн ажил 23,414.3 сая төгрөг, Ус хангамжийн цехийн Подъем-1, 2, цэвэрлэх байгууламжийн чиглэлийн 10.4 км технологийн замын засвар шинэчлэлийн 6,795.3 сая төгрөгийн ажлууд дуусч ашиглалтад хүлээлгэн өгснөөс голлон нөлөөлсөн;
- Бусад ажлын дүн 37,451.9 сая төгрөгөөр нэмэгдэхэд Үйлдвэр технологийн паркын цахилгаан хангамжийн систем 68,388.9 сая төгрөг, ус хангамж ариутгах татуургын системийн ажил 2,927.2 сая төгрөг, төмөр замын барилга угсралтын ажлыг 2,534.6 сая төгрөгөөр гүйцэтгэснээр өсөж, Эрдэнэт-Хялганат чиглэлийн 53.6 км авто замын өргөтгөл, засвар шинэтгэлийн 33,333.2 сая төгрөгийн ажлыг хөрөнгийн дансанд шилжүүлснээс голлон шалтгаалсан;

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

- Нийгмийн цехүүдийн дуусаагүй барилга 1,960.8 сая төгрөгөөр нэмэгдэхэд Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн хичээлийн 2 дугаар байрны их засварын 1,694.3 сая төгрөг, Сургуулийн барилга түлхүүр гардуулах нөхцөлтэй барих ажил /640 суудал/-ын 214.9 сая төгрөг, Тамирчдын байрны их засварын 51.7 сая төгрөгийн ажлууд дуусч ашиглалтад хүлээлгэн өгснөөс шалтгаалсан;
- Харин төсөл хөтөлбөрүүдийн дуусаагүй барилга 42,106.7 сая төгрөгөөр буурсан нь "Уурхайчин-2.3" орон сууцны хороолол хүртэлх дэд бүтэц барих ажлын 49,436.3 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн бол нийтлэг үйлчилгээний цехүүдийн хувьд 623.1 сая төгрөгөөр буурсан нь "11Б" хороололд шинээр баригдаж буй ус дамжуулах төвөөс хэрэглээний халуун, хүйтэн ус түгээх 1,263.4 сая төгрөгийн ажил дуусч хөрөнгийг шилжүүлсэн зэргээс тус тус шалтгаалжээ.

Дуусаагүй барилгын дансанд бүртгэлтэй 373.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий Хуурай шахах аргаар тоосго үйлдвэрлэх шугамын тоног төхөөрөмжийг РКF Mashinterstroy LTD компаниас угсралтын ажлын 60 хувийн гүйцэтгэлтэйгээр 2006 онд худалдан авсан бөгөөд түүнээс хойш угсралтын ажил хийгдээгүй, удааширсны улмаас тоног төхөөрөмж нь гадаа хадгалагдаж зэвэрч, муудан биет элэгдэлд орж ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна. Тайлант онд ТӨБЗГ-ын 2025 оны 891 дүгээр тогтоолоор тус хөрөнгийг акталж, данснаас хасах тогтоол гарсан байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалт 15,235.2 сая төгрөг болж, 45,511.6 сая төгрөгөөр буурсан ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 744 дүгээр тогтоолоор "Эрдэнэт медиал эмнэлэг"-ийн 46,769.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг Эрүүл мэндийн яамны харьяа Хавдар судлалын үндэсний төвд шилжүүлснээс шалтгаалсан байна.

Хайгуул ба үнэлгээний хөрөнгө дансны үлдэгдэл 90,068.2 сая төгрөг болж, 13,815.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 6 хайгуулын талбайд 10,856.8 сая төгрөгийн хайгуулын ажил гүйцэтгэснийг хайгуулын талбайн гадны байгууллагын судалгааны ажлын төлбөр 2,756.8 сая төгрөг, тусгай зөвшөөрөл 150.4 сая төгрөг, томилолт 42.7 сая төгрөг, бусад зардал 8.9 сая төгрөгийг уурхайн хөрөнгөөр тус тус капиталжуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгө 243,898.6 сая төгрөг болж, 54,263.9 сая төгрөгөөр буурсан нь урт хугацаат авлага 243,898.6 сая төгрөг болж 54,263.9 сая төгрөгөөр буурсан нь гэрээгээр ажил гүйцэтгэгчтэй холбоотой Beijing Shi Xi Import & Export Trading LLC-н 3,031.0 сая төгрөг, Орем трейд ХХК-ийн 89,459.8 сая төгрөг, Пэхэм ХХК-ийн 711.1 сая төгрөгийн ажлууд дуусаж гэрээ дүгнэгдсэнээс шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 650,417.1 сая төгрөг болж, 285,279.9 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Татварын өр төлбөр 600.9 сая төгрөг болж, 105,640.4 сая төгрөгөөр буурсан нь ААНОАТ-ын 55,792.8 сая төгрөг, АМНАТ-ын 48,699.1 сая төгрөг, ХХОАТ 732.6 сая төгрөг, НӨАТ-ын 796.0 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 123.0 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 17.9 сая төгрөг, усны бохирдлын төлбөр 77.0 сая төгрөгийн өр төлбөр тус тус буурснаас шалтгаалсан бол өр төлбөрийн үлдэгдэлд Булган аймагт төлөх усны нөөц ашигласны төлбөр 600.9 сая төгрөг бүртгэлтэй;
- Богино хугацаат нөөц /өр төлбөр/ 43,366.5 сая төгрөг болж, 13,695.4 сая төгрөгөөр буурсан нь орон сууцны нөөц санг 533.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, үйлдвэрийн газрын 2019 оны санхүүгийн тайлангаар татварын маргаан үүсгэсэн 14,268.6 сая төгрөгийн татварын актын төлбөрийг болзошгүй өр төлбөрийн нөөцөөр бүртгэсэн байсныг тайлант онд олон улсын аудитын компанийн өгсөн зөвлөмжөөр 2019-2022 оны татварын актын дагуу 34,155.1 сая төгрөгийн болзошгүй өр төлбөрийн нөөцөөр бүртгэсэн, үүнээс 48,423.7 сая төгрөгийн болзошгүй өр төлбөр хэрэгжснээр буурсан;
- Богино хугацаат зээлийн үлдэгдэл 253,142.5 сая төгрөгөөр буурсан нь Самсунг фирма компаниас авсан 100.0 ам.доллар буюу 68,411.8 сая төгрөгийн зээл, Капитрон банкнаас авсан 8.0 хувийн хүүтэй, 10.0 сая ам.доллар буюу 34,202.5 сая төгрөг, Голомт банкнаас авсан 9.0 хувийн хүүтэй 40.0 сая ам.доллар буюу 136,810.0 сая төгрөгийн зээлийг хааснаас шалтгаалан бол зээлийн үлдэгдэлд Хаан банкнаас авсан 8.88 хувийн хүүтэй 25.0 сая ам.доллар буюу 88,916.5 сая төгрөг бүртгэлтэй;

- Зээлийн хүүгийн өр төлбөр 21.6 сая төгрөг болж, 559.8 сая төгрөгөөр буурсан нь аж ахуйн нэгжүүдээс авсан зээлийн хүүгийн үлдэгдлийг тайлант онд төлсөнтэй холбоотой;
- Богино хугацаат өр төлбөр нэмэгдэхэд урьдчилж орсон орлогын үлдэгдэл 37,162.4 сая төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 65,516.4 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн. Үүнд: Зэсийн баяжмалын худалдан авагч 6 хуулийн этгээдээс борлуулалтын орлого 235,748.2 сая төгрөгийн урьдчилж авсан нь өмнөх оноос өссөн, мөн Эрдэнэс Монгол ХХК-ийн менежментийн гэрээний төлбөрт 75,776.3 сая төгрөг, Буганат нандин ХХК-д нарс мод нийлүүлэх, тарих, арчлах ажлын төлбөрт 2,033.4 сая төгрөг, Гэрээт цагдаа дотоодын цэрэгт төлөх 2,420.5 сая төгрөг зэргээс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөр 410,155.9 сая төгрөг болж, өмнөх оноос 93,091.6 сая төгрөгөөр өссөн нь ажиллагсдын тэтгэвэр тэтгэмжийн нөөцийг 71,611.8 сая төгрөг, уул уурхай хаагдах үеийн нөхөн сэргээлтийн нөөцийг 25,913.3 сая төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 985,433.5 сая төгрөг болж, 507,766.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 1038 барилга байгууламжийн дахин үнэлгээний өсөлт 574,679.2 сая төгрөг, 502 хөрөнгийн дахин үнэлгээний бууралтаас 106,006.1 сая төгрөг нөлөөлсөн байна.

Хуримтлагдсан ашиг 2,890.5 сая төгрөг болж, 427,613.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн цэвэр ашиг нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал нь жилийн үйлдвэрлэл, санхүүгийн болон эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2024 оны 94 дүгээр тогтоолоор Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнест төлөвлөгөөг баталж, 2025 оны 96 дугаар тогтоолоор нийт орлогыг 218,926.2 сая төгрөг, нийт зардлыг 163,966.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

Тайлант онд төрийн өмчит үйлдвэрийн газрын нийт орлогыг 4,361,471.8 сая төгрөг, зардлыг 3,534,484.6 сая төгрөг, цэвэр ашгийг 557,614.3 сая төгрөг, хөрөнгө оруулалтын арга хэмжээний зардлыг 1,023,855.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр 4,890,490.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, үйл ажиллагаанд 3,724,859.9 сая төгрөгийг зарцуулж, 756,720.8 сая төгрөгийн ашигтай ажиллаж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 525,912.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 529,018.29 сая төгрөгөөр буюу 12.1 хувиар давж биелсэн байна.

Зэс, молибдены баяжмалын борлуулалтын орлогын гүйцэтгэл 4,785,173.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 524,858.7 сая төгрөгөөр давж биелсэн нь борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдсэн, үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Тухайлбал:

- Зэсийн баяжмал борлуулалтын тоо хэмжээ төлөвлөснөөс 12.8 сая тонноор буюу 495,789.6 сая төгрөгөөр давж биелсэн;
- Зэсийн баяжмалын тонн тутамд борлуулалтын дундаж үнэ өмнөх оноос 2.1 мянган ам.доллар болж, 661,478.0 сая төгрөгөөр, молибдены баяжмал 18.4 мянган ам.доллар болж, 5,052.3 сая төгрөгөөр орлого нэмэгдсэн;
- Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах дундаж ханш 3,548.2 төгрөг буюу бизнес төлөвлөгөөнд тусгасан 3,536.75 төгрөгөөс 8.5 төгрөгөөр их байснаас шалтгаалан орлого 181,223.8 сая төгрөгөөр өссөн.

Бусад таваарын бүтээгдэхүүний орлого 69,627.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 3,291.9 сая төгрөгөөр давсан, өмнөх оноос 3,556.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Бусад орлого төлөвлөснөөс 867.7 сая төгрөг буюу 2.5 хувиар давж биелсэн нь үндсэн үйл ажиллагааны бус орлого 3,799.1 сая төгрөг, санхүүгийн орлого 1,749.1 сая төгрөгөөр давж, нийгмийн цехүүдийн орлого 4,335.6 сая төгрөг, гаднын байгууллагуудын үзүүлсэн бараа, материал, ажил үйлчилгээний орлого 165.4 сая төгрөг, өмчийн аргаар бүртгэсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын олз 128.5 сая төгрөг, түрээсийн орлого 50.9 сая төгрөгөөр дутуу биелснээс тус тус шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 3,724,859.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 190,375.3 сая төгрөг буюу 5.4 хувиар хэтэрсэн байна.

Тайлант онд олон улсын зах зээл дээрх цэвэр зэсийн үнэ төлөвлөснөөс тонн тутамд 453.2 ам.доллараар өссөн, зэс, молибдены баяжмал борлуулалтын тоо хэмжээ нэмэгдсэн, өмнөх оны ногдол зэргээс шалтгаалан АМНАТ 125,513.4 сая төгрөг, тайлант онд олон улсын аудитын байгууллагын зөвлөмжөөр 2019-2022 оны татварын актын дагуу 34,155.1 сая төгрөгийг болзошгүй өр төлбөрийн нөөцөөр бүртгэсэн, гаднын мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн үйлдвэрийн газрын барилга байгууламжийн дахин үнэлгээний үр дүнгээр үнэ цэнэ нь буурсан хөрөнгийн нөлөө 47,303.2 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 744 дүгээр тогтоолоор “Эрдэнэт медиал эмнэлэг”-ийн 46,769.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг Эрүүл мэндийн яамны харьяа Хавдар судлалын үндэсний төвд шилжүүлсэн, тэтгэвэр тэтгэмжийн нөөц санд төлөвлөснөөс 70,859.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн зэрэг зардлууд тус тус нэмэгдсэн байна.

Борлуулалтын орлого 4,854,800.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 528,150.6 сая төгрөгөөр нэмэгдсэн бол борлуулсан бүтээгдэхүүний өртөг төлөвлөснөөс 1,851,933.4 сая болж, 39,918.3 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 4,867,890.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, төлөвлөснөөс 541,249.9 сая төгрөгөөр давж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийг 33,113.3 сая төгрөгөөр бууруулсан байна.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийт зардалд 3,231,395.7 сая төгрөг зарцуулснаас АМНАТ 1,007,747.7 сая төгрөг буюу 31.2 хувь, үндсэн болон туслах материал 739,734.7 сая төгрөг буюу 22.9 хувь, үндсэн цалин, НДШ-д 528,422.3 сая төгрөг буюу 16.4 хувь, цахилгаан эрчим хүчний зардалд 421,527.0 сая төгрөг буюу 13.0 сая төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 293,310.2 сая төгрөг буюу 9.1 хувь, баяжмалын тээвэрлэлтийн зардалд 69,324.0 сая төгрөг буюу 2.1 хувь, нүүрс, мазут түлшний зардалд 35,160.3 сая төгрөг буюу 1.1 хувь, бусад зардал 136,169.5 сая төгрөг буюу 4.2 хувийг тус тус эзэлж байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 9 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 1,023,855.2 сая төгрөгийг төлөвлөж, 525,912.3 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөгөөний гүйцэтгэл 497,942.9 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь Засгийн газрын 2025 оны 94, 135 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах зорилгоор 4,866.5 сая төгрөгийн геологийн эрэл хайгуул болон 170,233.4 сая төгрөгийн 41 ажлуудыг царцааж, үндсэн хөрөнгийн 120,753.4 сая төгрөгийн 175 худалдан авалт, Барилга, байгууламжийн хяналт, төлөвлөлтийн хэлтсийн чиглэлээр гүйцэтгэх 23,763.4 сая төгрөгийн 57 ажлыг тус тус хойшлуулснаас голлон шалтгаалсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 756,720.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 199,106.5 сая төгрөгөөр илүү гүйцэтгэлтэй байгаа нь нийт орлогын төлөвлөгөө 12.1 хувиар давж биелсэнтэй холбоотой.

Тайлант онд Эрдэнэт Монгол ХХК-ийн 2025 оны “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ногдол ашгийн тухай 27 дугаар тогтоолын дагуу 2024 оны жилийн эцсийн 578,528.5 сая төгрөгийн цэвэр ашгаас Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан 50 хувьд ногдох 289,264.2 сая төгрөгийг Эрдэнэт Монгол ХХК-ийн дансанд төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь ажилтны хоол, унааны зардлын төсвийг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, албан хаагчдын хоолны зардлыг 23,339.2 сая

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

төгрөгөөр төлөвлөж, 17,723.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, ажилтнуудыг тээвэрлэх унааны зардалд 13,995.6 сая төгрөг төлөвлөж, 13,718.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй;

- Гадаад томилолтод нийт бүтцийн нэгжүүдийн ажилтнуудыг хамруулахаар төсвийг 1,584.0 сая төгрөгөөр төлөвлөж, 359.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, 1,224.6 сая төгрөгийг хэмнэсэн;
- Программ хангамжийн жагсаалтаар нийт 10,198.3 сая төгрөгийн 88 программ хангамж бүртгэлтэй байгаагаас 43 аж ахуйн нэгжээс худалдаж авсан 9,948.0 сая төгрөгийн 74, дуусаагүй барилгаас хүлээж авсан 250.2 сая төгрөгийн 14, программ бүртгэлтэй байна. Үүнээс үйл ажиллагаанд ашиглаж байгаа 9,621.5 сая төгрөгийн 71, ашиглагдахгүй байгаа тооллогоор акталж, данснаас хасах санал хүргүүлсэн 576.8 сая төгрөгийн 17 программ бүртгэлтэй;
- Үйлдвэрийн газар нь тайлант онд 5,000.0 сая төгрөгийн сургалтын зардал төлөвлөж, 2,644.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 1,169.8 сая төгрөгийн хурал зөвлөгөөний зардал төлөвлөснөөс 756.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан;
- Батлагдсан бүтцийн 7196 албан хаагчид 520,245.7 сая төгрөгийн цалингийн сан төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7.1 хувь буюу 509 орон тоо дутуу ажиллаж, 512,215.1 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна. Тайлант онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 6 ширхэг хүнд даацын өөрөө буулгагч автомашин, 1 экскаватор нэмэгдсэнтэй холбогдуулан зайлшгүй шаардлагатай 36 орон тоог үйлдвэрийн газрын нийт орон тоог нэмэгдүүлэхгүйгээр дотоод нөөц бололцоог ашиглан шийдвэрлэсэн;
- Хэвлэл мэдээллийн байгууллагатай 362.6 сая төгрөгийн гэрээ байгуулж зардал гаргасан байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд олгосон санхүүжилттэй холбоотой зөрчлийг тус тайлангийн 5 дугаар бүлэгт тусгасан.

3.6 Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

3.6.1 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн өргөтгөл, шинэчлэл, засварын чиглэлээр хийх, үндсэн хөрөнгийн худалдан авалт, техник, тоног төхөөрөмжийн их засвар, геологи, хайгуул, ТЭЗҮ боловсруулах болон өргөтгөх, шинэчлэлийн төслүүд гэсэн 9 чиглэлд нийт 1,023,855.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө		Гүйцэтгэл
		Нийт төсөвт өртөг	Тайлант онд санхүүжих дүн	
1	2	3	4	5
1	Барилга, байгууламж	2,356,915.5	454,693.1	241,852.0
2	Автомашин, техник, өөрөө явагч хэрэгсэл	134,360.1	91,537.2	44,337.3
3	Багаж, тоног төхөөрөмж	284,076.7	237,714.7	124,627.1
4	Компьютер, дагалдах хэрэгсэл	10,828.0	10,828.0	6,364.0
5	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,718.6	1,718.6	9,117.2
6	Бусад үндсэн хөрөнгө	15,788.8	5,457.8	-
7	Их засварын ажил	41,742.0	40,337.2	11,291.3
8	Геологи, хайгуулын ажил	22,788.3	20,155.3	3,130.8
9	Төслийн санхүүжилт	2,860,140.5	145,482.4	211.7
10	ТЭЗҮ, зураг төсөл	21,531.1	15,931.1	7,141.8
Дүн		5,749,889.6	1,023,855.2	448,073.3
11	Механикийн хэлтэс			25,000.0
12	Геологи, хайгуулын экспедици			10,829.0
13	Барилга, засварын цех			7,010.0
14	Худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлт			35,000.0
Нийт дүн:		5,749,889.6	1,023,855.2	525,912.3

Тайлант оны гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 525,912.3 сая төгрөг буюу 51.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өөрийн эх үүсвэрээс барилга засварын цехийн 7,010.0 сая төгрөг, геологи хайгуулын экспедицийн 10,829.0 сая төгрөг, механикийн хэлтсийн 25,000.0 сая төгрөг, нийт 42,839 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Бараа материалын ажил, үйлчилгээний худалдан авалтаас нийт 35,000.0 сая төгрөгийн хэмнэлт үүсжээ.

3.6.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 1,441 арга хэмжээнд нийт 1,830,453.7 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр 1,576,681.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,437,934.0 сая төгрөгийн 765 гэрээг байгуулсан байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийг шалгаруулж, 1,127,598.1 сая төгрөгийн 474 гэрээ;
- Нэг эх үүсвэртэй худалдан авах ажиллагааны аргаар гүйцэтгэгчийг шалгаруулж, 246,070.1 сая төгрөгийн 21 гэрээ;
- Гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгэгчийг шалгаруулж, 51,624.6 сая төгрөгийн 24 гэрээ;
- Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг шалгаруулж, 11,564.9 сая төгрөгийн 230 гэрээ;
- Ерөнхий гэрээгээр 946.0 сая төгрөгийн 6 гэрээ;
- Шууд худалдан авах аргаар 130.3 сая төгрөгийн 10 гэрээг тус тус байгуулсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний гадаад, дотоод орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг сайжруулах эдийн засгийн үндсэн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөний, гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн удирдлага, урьдчилж гарсан зардал/тооцооны үлдэгдэл, найдваргүй болох эрсдэлтэй авлага, дуусаагүй барилга, хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, үндсэн хөрөнгийн хяналт, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/-ын нэг эх үүсвэртэй худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, О.Баярмаа, П.Батцэцэг, Д.Мөнхжин, аудитор Т.Баасанцэнд, П.Ариунзаяа, С.Алтанхуяг, Ч.Мөнхбулган, Г.Тэлмүүн, Б.Тэгшсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 2025 оны санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 110/50 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 3,973,855.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 39,738.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангаар нийт орлого 4,890,490.1 сая төгрөг болж, 2024 оноос 23.1 хувиар нэмэгдсэн нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзлээ.

Материаллаг байдлыг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 4,890,490.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 48,904.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 461,573.3 сая төгрөгийн 13 зөрчил илэрч, зөрчлийг таслан зогсоох 10 албан шаардлага, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 547,902.4 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 430,632.6 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 117,269.8 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 3 зөвлөмж тус тус хүргүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны мэдээллийн системд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5,051,802.5 сая төгрөгийн 2072 орлогын, 4,533,706.6 сая төгрөгийн 3594 зарлагын гүйлгээ мэдээлэхээс 78,946.9 сая төгрөгийн 249 ажил гүйлгээг хугацаа хоцроож тайлагнасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлж байх **зөвлөмж** өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Засгийн газрын тогтоол, дээд шатны байгууллагаас төсвийн жилийн дундуур, гэнэтийн шийдвэрүүдээр ирсэн чиглэлийн дагуу үйлдвэрийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй 33,582.7 сая төгрөгийн санхүүжилт, дэмжлэг олгосон байгаа нь төрийн өмчит компаниудад ирэх төсвийн дарамтыг нэмэгдүүлж, үйлдвэрийн урт хугацааны төлөвлөлтийг удаашруулах, төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын ажлуудыг гацааж, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 127 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нүхэн жорлонг орчин үеийн стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл”-д 17.54 сая ам.доллар буюу 59,629.0 сая төгрөг төлөвлөж, Сангийн яаманд шилжүүлсэн 24,179.4 сая төгрөг;
- Засгийн газрын 2025 оны 191 дүгээр тогтоолоор “Төрийн тахилгат Бурхан Халдун хайрханд хүндэтгэлийн цогцолбор барих ажил”-д 0.29 сая ам.доллар буюу 1,000.0 сая төгрөг төлөвлөж, тодотголоор 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний жанжин штабт олгосон 1,500.0 сая төгрөг;
- Засгийн газрын 2024 оны 221 дүгээр тогтоолоор Шинэ Хархорум хотын төв цэг, төв талбайн тохижилтын ажлын санхүүжилтэд Зэвсэгт хүчний 256 дугаар ангид 222.8 сая төгрөг, нэмэлт гэрээгээр 36.5 сая төгрөг, бусад 109.6 сая төгрөг, нийт 369.0 сая төгрөг, хотын төлөвлөлтөд тусгагдсан ногоон байгууламж, нарс мод тарих арчлах ажилд Бугантнандин ХХК-д урьдчилгаа төлбөрт олгосон 1,396.4 сая төгрөг;
- МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2024 оны ТГ/694 дүгээр албан бичиг, Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-аас баталсан Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, Эрүүл Монгол Хүн үндэсний хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэс медиал эмнэлгийн үйл ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд Улсын хоёрдугаар эмнэлэгтэй 2025 онд байгуулсан 25/32 дугаар хамтран ажиллах гэрээгээр “Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг хөгжүүлэх төсөл”-д 4,500.0 сая төгрөгийг төлөвлөж, дэмжлэг олгосон 4,491.0 сая төгрөг;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 02 тоот тэрбум мод үндэсний хөдөлгөөний албан бичгийн хүрээнд Говийн бүсэд мод үржүүлгийн газар байгуулах ТЭЗҮ хийх ажилд /Дундговь аймаг/-т олгосон 39.8 сая төгрөг;
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2025 оны ХЭГ/356 тоот, Эрдэнэс монгол ХХК-ийн 01/1319 тоот албан бичгээр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т 5 менежерийн орон тоог нэмэгдүүлснээр төлөвлөгдөөгүй зардлын гүйцэтгэл 1,607.1 сая төгрөг; /тухайлбал, дээрх томилгоотой холбоотойгоор 5 менежер, 2 нарийн бичиг, 1 жолоочийн цалин хөлсний

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

зардалд 1,192.9 сая төгрөг, тээвэр шатахууны зардалд 254.1 сая төгрөг, тавилга эд хогшил, цахилгаан хэрэгсэлд 160.1 сая төгрөг/

- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг санхүүжүүлэхээр 12.08 сая ам.доллар буюу 41,079.4 сая төгрөг төлөвлөсөн, гүйцэтгэл гараагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна”, 3.1.3-т “банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан;”, 4.1.34-т “төсвийн байгууллага” гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг”, 25.10-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим”, 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.6-д “сахилга баттай байх;”, 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.”, 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 зүйлийн 3-т “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно.”, 20 дугаар зүйл. “Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг”, “3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;”, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулах тухай” 102 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм”-ийн 4.1-т “Үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.”, Баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д “Энэ хуулийн 12.4, 12.6-д заасан хуулийн этгээд нь дүрэмд заасан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэхийг хориглоно.”, Улсын Их Хурлын 2024 оны “Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 09 дүгээр тогтоолын 3-т “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК болон төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдээс цаашид төсвийн шинжтэй, компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох арга хэмжээг авах”, Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний 3.16-д “Жилийн үр дүнгийн урамшууллыг (13 дахь сарын цалин) жилд нэг удаа дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр тооцож, журмын дагуу олгоно.”, Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын “Цалин хөлсний тухай журам”-ын 4.1-д “Үйлдвэрийн газрын болон тухайн бүтцийн нэгжийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд хамт олон, ажилтны оруулж буй хувь нэмэр, ажлын гүйцэтгэл, үр дүн, идэвх зүтгэлийг бодитоор үнэлж, ажилтнуудыг идэвхжүүлэх зорилгоор сар бүрийн ажлын үр дүнгийн урамшуулал, жилийн ажлын үр дүнгийн урамшууллыг олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын чиг үүрэгт хамааралгүй, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын болон урсгал зардал, нийгмийн шинжтэй зардлуудыг хууль тогтоомж зөрчиж, бизнес төлөвлөгөө, зорилтот түвшинд тусгуулан баталж, компанийн ашигт ажиллагааг бууруулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Засгийн газрын 2025 оны 94, 135 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын А/138 дугаар тушаалаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын ажлуудыг царцаах, үйл ажиллагааны зардлыг бууруулах замаар нэгдлийн комданиудад улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлого, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх үүрэг даалгавар, чиглэл ирсний дагуу үйлдвэрийн захирлын зөвлөлийн хурлын 2025/04 дүгээр шийдвэрээр сүүлийн хагас жилийн бизнес төлөвлөгөөнд улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг нэмэгдүүлэх, зарим хөрөнгө оруулалтын ажлыг бууруулан төлөвлөж дээд газарт хүргүүлсэн байна.

Гүйцэтгэлээр жилийн эцэст 2026 оны 1 дүгээр сарын экспортын орлого буюу 235,748.2 сая төгрөгийг харилцагч 6 аж ахуйн нэгжээс урьдчилан авч улсын төсвийн татварын урьдчилгаанд 177,385.0 сая төгрөг, Эрдэнэс Монголын менежементийн төлбөрт 20,000.0 сая төгрөг, ОНХС-нд 5,000.0 сая төгрөг, Засгийн газрын 127 дугаар тогтоолоор Сангийн яаманд 754.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон бол Хаан банкнаас оны эцэст 141,943.4 сая төгрөгийн /40.0 мянган ам.доллар/-ын 8.88 хувийн хүүтэй зээл авч үндсэн үйл ажиллагааны зардлыг төлж /25.0 мянган ам.долларыг 12 дугаар сарын 30, 31-нд буцааж төлсөн/, мөн тодотголоор тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсвийг 58,535.2 сая төгрөгөөр бууруулан, зарим хөрөнгө оруулалтын ажлуудыг хойшлуулсан нь ирээдүйд үйлдвэрийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, санхүүгийн сахилга бат алдагдах, хүүгийн дарамтад орох, санхүүгийн чадавхийг бууруулах, дараа дараагийн шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах боломжийг бууруулах эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т "Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.", 6 дугаар зүйлийн 6.4.6-д "хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх", 23 дугаар зүйлийн 23.3-т "Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 3 дугаар зүйлд "Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно." 6 дугаар зүйл. "Төрийн өмчид эд хөрөнгө олж авах" 2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын ирээдүйд орох орлогыг барьцаалж харилцагч байгууллагуудаас урьдчилан санхүүжилт татаж, улсын төсвийн хөрөнгийн дутагдлыг нөхсөн зөрчлийг таслан зогсоож, Төрийн өмчит үйлдвэрийн газарт санхүүгийн дарамт үүсгэж, зээл, зээлийн хүүгийн зардал төлүүлж, компанийн ашигт ажиллагааг бууруулахгүйгээр удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын худалдан авах ажиллагаанд оролцож буй байгууллагуудын өмнөх шалгарсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл болон олон гэрээг давхардуулан авч буй эсэхийг үнэлгээний хороо үнэлдэггүйгээс 7 багцтай тендер шалгаруулалтын 5 багцад нэр бүхий 2 компани шалгарч нийт 19,358,082,000.00 /Арван есөн тэрбум гурван зуун тавин найман сая наян хоёр мянга/ төгрөгийн гэрээг байгуулсан нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлтийг хангахгүй, гэрээнд заасан хугацаанд барааг нийлүүлэхгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 26 дугаар зүйлийн 26.9-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ", 27 дугаар зүйлийн 27.9-д "Багцтай тендер шалгаруулалтын багц тус бүрд үнэлгээ хийх ба оролцогч хоёр ба түүнээс дээш багцад хамгийн сайн тендер ирүүлсэн бол оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадавхыг магадлан", 27.10-т "Хэд хэдэн багцад шалгарсан оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадавхыг магадлахад аль нэг багцад шаардлага хангахгүй бол түүний чадавхын шаардлага хангах багцуудаас гэрээний үнэ хамгийн өндөр байх нэг, эсхүл түүнээс дээш тооны багцад гэрээ байгуулах эрх олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Худалдан авах ажиллагааны тендерт оролцож байгаа аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхыг үнэлэхдээ тухайн аж ахуйн нэгжийн өмнө шалгарсан дуусаагүй ажлын төсөвт өртгийн нийлбэрээс тооцож бодитой үнэлдэггүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд байгуулсан үндсэн гэрээнд тусгагдаагүй сургалтын зардал, онгоцны тийз, гадаадад байрлах зардлыг бэлтгэн нийлүүлэгч компаниар даалгаж, үйлдвэрийн газрын ажилчдыг гадаадад томилолтоор ажиллуулсан байна. Тухайлбал:

- Ерөнхий захирлын 2025 оны А/70 дугаар тушаалаар тайлант оны 3 дугаар сард Австрали улсын Перт хотод сургалтад хамрагдах үйлдвэрийн газрын 8 ажилтны гадаад томилолтын зардлыг Майнтек технологи ХХК-иар даалгаж, Майнтек технологи ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд байгуулсан "Ил уурхайн программ хангамжийн лиценз" нийлүүлэх 2024/09-10-0369 тоот үндсэн гэрээнд 2025 оны 4 дүгээр сард нөхөн нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Ерөнхий захирлын 2025 оны А/329 дүгээр тушаалаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжинь хотод үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай танилцах, уулзалтад оролцуулахаар 2 ажилтны гадаад томилолтын зардлыг Ай эм трейдинг ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд байгуулсан "Бутлан тээвэрлэх хэсгийн туузан дамжуулгын хөтлүүр" нийлүүлэх 2024/02-11-0684 тоот үндсэн гэрээнд тусгагдаагүй байхад бэлтгэн нийлүүлэгч талаар даалгаж, ажиллуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно" 40.2.1-т "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах", Иргэний хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хууль буюу гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн гэрээнд тусгагдаагүй зардлыг бэлтгэн нийлүүлэгч компаниар даалгасан зөрчлийг таслан зогсоож, харилцагч байгууллагатай байгуулсан гэрээнд худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт тусгагдаагүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй нөхцөлөөр нэмэлт өөрчлөлт оруулахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 4.2.6-д "Цалин хөлс, урамшууллын системийг боловсронгуй болгох, цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх, цалин хөлсийг сард 2 удаа буюу сар бүрийн 05, 15-ны өдрүүдэд олгох"-оор тусгасан боловч дээрх өдрүүдээс гадна долоо хоног бүрийн 2, 4 дэх өдрүүдэд 7 банкны дансаар цалингийн гүйлгээ хийж байгаа нь цалингийн тооцоолол, цалин олголтод тавих хяналтыг сулруулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1-т "Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ.", "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 4.2.6-д "Цалин хөлс, урамшууллын системийг боловсронгуй болгох, цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх, цалин хөлсийг сард 2 удаа буюу сар бүрийн 05,15-ны өдрүүдэд олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудад ээлжийн амралтаас бусад цалин хөлсийг тооцож олгохдоо үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж сард 2 удаа тогтсон хугацаанд олгож байх **зөвлөмж** өгөв.

Илрүүлэлт 1: Засгийн газрын 2022 оны 171 дугаар тогтоолоор Уул уурхай- металлурги- химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт байрлах "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын эзэмшилд бүртгэлтэй 117,269.8 сая төгрөгийн анхны өртөгтэй, 4,690,790 кв талбайн хэмжээтэй, 6102101619 нэгж талбарын дугаартай газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай тогтоол гарсан боловч 2025 оны жилийн эцсийн тайлангаар тус газар нь байгууллагын данс бүртгэлд бүртгэлтэй хэвээр байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ын 1 дэх хэсэгт "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын дансанд бүртгэлтэй газрын улсын тусгай хамгаалалтад шилжүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилын дүнд илэрсэн зөрчил нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгууртай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, холбогдох данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлж, илэрсэн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, саналыг авсан. Завсрын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг дахин нягталж, жилийн эцсийн аудитын тайлангийн дүн дүгнэлтэд нэгтгэн тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 103,097.0 сая төгрөгийн 7 албан шаардлага, 13,419.6 сая төгрөгийн 7 зөвлөмж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаарх зөрчилд хүргүүлсэн 2 албан шаардлага, хариуцлага тооцуулах 2 албан шаардлагын нийт биелэлт 48.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт					
2	Албан шаардлага	9	103,097,019.8	5	102,148,956.6	56.0
3	Зөвлөмж	7	13,419,579.6	2	-	30.0
4	Хариуцлага тооцуулах албан шаардлага	1	-	1	-	100.0
	Нийт дүн	17	116,516,599.4	8	102,148,956.6	48.0

Өмнөх аудитаар хүргүүлсэн боловч хэрэгжээгүй албан шаардлагуудын хувьд дараах шалтгаанаар тайлант оны аудитаар дараагийн шийдлийг авалгүй дахин албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно. Үүнд:

- Өөрийн чиг үүрэгт хамааралгүй асуудлаар санхүүжилт олгосон зөрчилд шалгагдагч байгууллагаас шууд хамаарахгүй нөхцөл үүссэн;
- Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Эрдэнэт үйлдвэр ХХК, Зэс Эрдэнийн хувь ХХК-ийн асуудал хууль хяналтын байгууллагад маргаан үүссэн;
- Орхон аймаг дахь цагдаа, дотоодын цэргийн байгууллагатай байгуулсан гэрээг үндэслэн өндөр насны тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн тэтгэмжийг хувь хүний дансанд шилжүүлсэн зөрчил давтагдан гарсан боловч өмнөх аудитаар дүгнэлт өгснөөс хойш байгууллагын дансанд шилжүүлж эхэлсэн;
- Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоолын дагуу “Төрийн өмчит уул уурайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэхээр баталсны дагуу Үндэсний аудитын газрын Тусгай чиг үүргийн аудитын газраас Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 онд Худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан гэрээний хэрэгжилтийг шалгаж, 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн цахим системд байршуулаагүй гэрээний мэдээллийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор байршуулж ажиллах талаар 1236/A0170460 дугаартай хугацаатай албан шаардлага өгснийг харгалзан санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн гэрээний хэрэгжилттэй холбоотой зөрчилд дараагийн шийдэл аваагүй болно.

Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт тусгасан Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилтын хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлург-химийн үйлдвэр, (HL-SX/EW) технологиор катодын зэс үйлдвэрлэх арга хэмжээний ТЭЗҮ-ийн зардалд нийт 4,115.3 сая төгрөгийг зарцуулсан боловч төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, ашиглалтад ороогүй байна. Тус арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүйгээс баримт бичигт тусгасан хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн асуудалтай холбоотой өгсөн зөвлөмж шалгагдагч байгууллагын зүгээс хэрэгжүүлэх боломжгүй болсон бөгөөд тус төсөл Эрдэнэс Монгол ХХК-ийн харьяа Зэс боловсруулах цогцолбор ХХК-д шилжсэн байна.

Мөн өмнөх аудитаар өгсөн худалдан авах ажиллагааны үр дүнд ажил гүйцэтгэхээр тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдэд урьдчилгаа төлбөр олгосноос хугацаа хэтэрсэн авлага үүсэх, ажил хугацаандаа хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн талаар өгсөн зөвлөмж, нийгмийн шинжтэй зардлуудыг бизнес төлөвлөгөөнд тусгаж санхүүжүүлсэн, ОХУ-ын Москва хот дах худалдааны төлөөлөгчийн газар, БНХАУ-ын Бээжин хот дах төлөөлөгчийн газруудыг татан буулгасан боловч 439.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчлүүд давтагдан гарсан тул аудитаар дараагийн шийдлийг авч, албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын экспортын орлого, үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулах, нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулахад чиглэсэн дараах ажлуудыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан ажлуудын хэрэгжилтийг дунд болон богино хугацааны төлөвлөлт гүйцэтгэлтэй уялдаж байгаа эсэх;
- Улсын Их Хурлын 2024 оны “Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 09 дүгээр тогтоолын

хэрэгжилтийг хангаж үйлдвэрийн газрын зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг батлуулж байгаа эсэх;

- Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлтөөр оруулан тодотгож байгаа худалдан авалтуудын үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагааны ашигт ажиллагаанд эергээр нөлөөлж байгаа эсэх;
- Үйлдвэрийн газрын харьяа нийгмийн цехүүдэд олгож байгаа татаасыг үе шаттайгаар бууруулж, өөрийн орлогоор санхүүжих боломжийг бүрдүүлж, зах зээлийн зарчмаар ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа эсэх;
- Зорилтот түвшний төлөвлөгөөнд батлагдаж байгаа үйлдвэрийн газрын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийг бууруулах ач холбогдолтой хөрөнгө оруулалтын ажлуудыг хугацаанд нь зорилтот түвшинд хүргэн ажиллаж байгаа эсэх;
- Худалдан авах ажиллагааны гэрээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем "tender.gov.mn"-д бүрэн байршуулсан эсэх;
- Лондонгийн биржид бүртгэлгүй "China Certification & Inspection Group"-тэй 2016-2025 оны 4 дүгээр сар хүртэл шууд гэрээ байгуулан хорт бодисын шинжилгээ болон гадна сэлгэн ачилт хийлгэж, тайлант хугацаанд 2024 оны үйлчилгээний төлбөрт 601,299.0 ам.доллар буюу 2,151,616,085.91 /Хоёр тэрбум нэг зуун тавин нэгэн сая зургаан зуун арван зургаан мянга наян таван төгрөг ерэн нэгэн мөнгө/ төгрөгийг олгосон боловч гэрээг цуцалсан байгаа тул 2026 онд санхүүжилт олгосон эсэх;
- Монголын уул уурхайн үндэсний ассоциаци ТББ-д олгож байгаа санхүүжилтийн дүн нэмэгдсэн эсэхийг тус тус шалгах шаардлагатай гэж үзсэн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 262,898.7 сая төгрөгийн 53 зөрчил² илэрснээс, 18.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 225,841.8 сая төгрөгийн зөрчилд 37 албан шаардлага хүргүүлж, 27,683.8 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж, 9,354.9 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 3 албан шаардлага өгсөн.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 262,898.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс 223,160.1 сая төгрөгөөр давсан тул “**Хязгаарлалттай**” дүгнэлт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Монгол Улсын Шадар сайдын 2024 оны "Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" 10 дугаар тушаалаар хүчингүй болсон Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 22 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-г үндэслэн Ерөнхий захирлын "Ажилтнуудыг урамшуулах тухай" 2025 оны Б/85, А/751 дүгээр тушаалуудаар 912 ажилтанд 18.2 сая төгрөгийн урамшууллыг илүү олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Шадар сайдын 2024 оны "Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" 10 дугаар тушаалын 4-р хавсралт "Баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудад олгосон урамшууллыг хүчингүй болсон тушаалаар тооцож, илүү олгосон, тушаалын төсөлд, тушаалын төсөлд хяналт тавьж ажиллаагүй зөрчилд төсөвт төвлөрүүлэх **төлбөрийн акт** тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Мөнгөн хөрөнгө, зардалтай холбоотой:

Илрүүлэлт 1: Эрдэнэс монгол ХХК-ийн 2024 оны А/95 тушаалаар баталгаажуулсан Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшинд Аймгийн ЗДТГ, ИТХ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд олгох нийт 30,523.6 сая төгрөгийн хандив, дэмжлэгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны зардалд төлөвлөж, бизнес төлөвлөгөөнд тусгасан нь үйлдвэрийн ашигт ажиллагааг бууруулахад нөлөөлж байна. Үүнд:

- Орхон аймгийн ЗДТГ-тай байгуулсан 5/152-24 дүгээр хамтран ажиллах гэрээний дагуу Эрдэнэт хот доторх зам засварын ажлын гүйцэтгэлд 26,229.5 сая төгрөг, 2025 оны хамтран ажиллах 5/159-25 дугаар гэрээний дагуу 2,768.8 сая төгрөг, нийт 28,998.3 сая төгрөг;
- Булган аймгийн ЗДТГ-тай байгуулсан 5/068-25 дугаар хамтран ажиллах гэрээний дагуу олгосон 1,021.1 сая төгрөг;
- Завхан аймгийн ЗДТГ, ИТХ-тай байгуулсан 5/098-24 дүгээр хамтран ажиллах гэрээний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд санхүүжүүлсэн 304.3 сая төгрөг;
- Хөвсгөл аймгийн ЗДТГ-тай байгуулсан 5/105-25 дүгээр хамтран ажиллах гэрээний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд санхүүжүүлсэн 200.0 сая төгрөг тус тус байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлд "Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.", Төсвийн тухай хуулийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд хүлээн хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгахдаа Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчийн хуралтай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд олгох хандив, дэмжлэгийг өөрийн байгууллагын төсөвт төсөвлөж батлуулсан зөрчлийг арилгаж, ногдол ашгийн нэгэн адилаар цэвэр ашгаас хуваарилдаг байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд зорилтод түвшний 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн ГЁ-131-12/4160 дугаар албан бичгээр баталсан Худалдан авах ажиллагааны тодотголд Улаанбаатар төмөр зам ХНН 2025 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 03/2797 тоот албан бичиг, ЗГ-ын тогтоолын дагуу 2 сарын вагон түрээсийн үйлчилгээнд 6,000.0 сая төгрөгийг төсөвлөж, баталсан. Техникийн тодорхойлолтод зөвхөн шаардлагын буюу ОХУ-ын 12-132 загварын хагас вагон эсвэл түүнтэй дүйцэхүйц гэсэн төрлөөр 350 вагоныг үндэслэлгүйгээр 19-50 ширхэгээр хуваан 10 багцалсан, тендер шалгаруулалтын баримт бичигт ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх шаардлагыг огт оруулалгүй хасаж, нийт 2 сарын хугацаанд ажиллуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нийт 9 багцын 300 вагоны түрээсийн тендерТ Төмөр замын зураг, төслийн институт ХХК шалгарч 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 5/289-2025 тоот гэрээгээр 4,811.8 сая төгрөг, 1 багцад 50 вагон түрээслэхээр Дулаанвинг ХХХ шалгарч 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 5/019-2026 тоот гэрээгээр 850.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2026 оноос үйлчилгээнд явж эхлэхээр байгаа нь тодотголоор 2025 онд зайлшгүй шаардлагатай бус төсвийг баталсан, мөн тус үйлдвэрт эрх бүхий албан тушаал эрхэлж байсан хүний компани тус тендерийн 9 багцад шалгарсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", 10 дугаар зүйлийн 10.5-т "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно.", 52 дугаар зүйлийн 52.1-д "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх үүргийг хүлээнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын эрсдэлийг удирдах, ерөнхий нөхцөл магадлагаас зайлсхийж тендерийн шаардлагыг бууруулсан, тендерт өрсөлдөж байгаа аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгч, хамаарал бүхий этгээдийг тогтоож, ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөвөөр мэдүүлээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Тайлант хугацаанд гэрээт байгууллагуудтай холбоотой 802.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй. Үүнд:

- Гэрээт цагдаа, дотоодын цэргийн өндөр насны тэтгэвэрт гарахад олгох 776.4 сая төгрөгийн тэтгэмжийн санхүүжилтийг Орхон аймаг дахь Цагдаагийн газар, Дотоодын цэргийн 816 дугаар ангийн дансанд төвлөрүүлэлгүй, хаан банкны дундын депозит дансанд шилжүүлсэн;
- Гэрээт цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдын томилолтын зардалд 7.7 сая төгрөг, Дотоодын цэргийн марш тактикийн тэмцээний төсөвт 18.5 сая төгрөгийг тус тус олгосон.

Энэ нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоох, олгох байгууллага", "Цэргийн алба хаагчийн тэтгэврийг тогтоох, олгох ажлыг тухайн тэтгэвэр авагчийн алба хааж байсан зэвсэгт хүчин,

хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага буюу тэдгээрээс гэрээ байгуулсан этгээд эрхлэн гүйцэтгэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагатай байгуулсан гэрээг үндэслэн өндөр насны тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн тэтгэмжийг байгууллагын дансанд шилжүүлэхгүй, хувь хүний дансанд шилжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, цагдаа, дотоодын цэргийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу олгох санхүүжилтийг тус байгууллагууд улсын төсөвт суулгаагүй, давхардаагүй талаар баримтжуулж ажиллах **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын арилжааны банкны дансдуудаар орлогын 9,682,647.5 сая төгрөгийн 10371, зарлагын 9,627,560.3 сая төгрөгийн 13442 гүйлгээ бүртгэгдсэн байна. Үүнээс харилцахын гүйлгээнээс архивын баримт руу хөөн шалгахад дансдуудыг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн хуваарилаагүйгээс нийт бэлэн мөнгөний касс 11, арилжааны 28 банкны дансаар нийгмийн цехүүдийн болон үндсэн үйл ажиллагааны орлого, зарлагын гүйлгээ гарч байгаа нь мөнгөн хөрөнгийн зүй зохистой удирдлага, хяналт алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийнх 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д "ерөнхий нягтлан бодогч" гэж нягтлан бодох бүртгэл хөтлөх, удирдан зохион байгуулах, хариуцлага хүлээхээр аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагаас томилогдсон мэргэжлийн нягтлан бодогчийг; 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Мөнгөн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, харьяа цехүүдийн мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг нэг данснаас гаргадаг болгож, үндсэн данснаас салгаж бүртгэх, дотоод хяналтыг сайжруулах **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Бизнес төлөвлөгөөнд үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар тэргүүлэх чиглэлд тусгасан боловч урлаг, спорт, баярын арга хэмжээний зардлын төсвийн 94.8 хувь буюу 3,326.2 сая төгрөгийн гүйлгээг "батлагдсан төсвийн дагуу, төсөв" гэсэн утгатай хувь хүний дансруу 663 гүйлгээ гарсан байгаа нь төсвийн зарцуулалтын ил тод байдал, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын удирдлагын хяналт алдагдах эрсдэлтэй байна. Тухайлбал тус зардлаас спортын арга хэмжээнд 548.8 сая төгрөг, олон нийтээр тэмдэглэлт өдрүүдийн зардалд 1,029.4 сая төгрөг, байгууллагын уралдаан тэмцээний зардалд 242.4 сая төгрөг, мэргэжлийн баяр, цехүүдийн арга хэмжээнд 209.5 сая төгрөгийг тус тус зарцуулж, байгууллагын албан хаагчдын дансаар дамжуулан гүйлгээ хийж байгаа нь худалдан авалтын төлөвлөгөөнөөс гадуурх гэрээ хэлцэлгүй, хяналтгүй, шууд худалдан авалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 24 дүгээр зүйлийн 24.7-т "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урлаг, спорт, соёлын арга хэмжээтэй холбоотой худалдан авах ажиллагааг харилцагч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлээгүй, хувь хүний дансаар дамжуулан зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, гүйлгээний мэдээллийг ойлгомжтой, ил тод бүртгэж байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 6: Дараа тайлангийн тооцоогоор гадаад албан томилолтын тийзийн төлбөрийг агаарын тээврийн компаниудын арилжааны банкны дансанд шилжүүлсэн боловч харилцах дансны журналаар албан хаагчийн нэр дээр бүртгэсэн байна. Үүнд: 59 албан хаагч 182.9 сая төгрөгийг Эйртранс ХХК-руу, 13 албан хаагчийн 36.4 сая төгрөгийг Ай трип эйр ХХК-руу, 12 албан хаагчийн 27.7 сая төгрөгийг Нандинвэй ХХК-руу, 8 албан хаагчийн 19.0 сая төгрөгийг Эйрлинк ХХК-руу, 2 албан хаагчийн 3.3 сая төгрөгийг Аэрмаркет ХХК-руу, 1 албан хаагчийн 7.9 сая төгрөгийг Эйр тикет ХХК-руу тус тус шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д "ерөнхий нягтлан бодогч" гэж нягтлан бодох бүртгэл хөтлөх, удирдан зохион байгуулах, хариуцлага хүлээхээр аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагаас томилогдсон мэргэжлийн нягтлан бодогчийг; 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дараа тайлангийн тооцооны хяналтыг хэрэгжүүлэхдээ мөнгөн хөрөнгийн журналын хөтлөлтийн үнэн зөв байдлыг алдагдуулахгүйгээр анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 7: Сангийн сайдын 2024 оны "Дотоод албан томилолтын зардлыг хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаалыг мөрдөлгүй, алба, хэлтсийн дарга, ерөнхий инженер зэрэг удирдах түвшний албан хаагчдад 160.0-250.0 мянган төгрөгийн зочид буудлын төлбөр олгосноос дотоод албан томилолтын зардлын нормыг нийт 156.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Мөн томилолтын төсвийг боловсруулсан боловч холбоотой этгээдүүдийн гарын үсгээр огт баталгаажаагүй гүйлгээг гаргаж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9-д "улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох", 20.1.10-д "эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах", Сангийн сайдын 2024 оны "Дотоод албан томилолтын зардлыг хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна:", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод томилолтын төсвийг тооцож, олгохдоо эрх бүхий байгууллагын баталсан нормыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 8: Хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа шалгаруулж байгаа аж ахуйн нэгжийн санхүүгийн чадавхыг үнэлж байгаа боловч гэрээг байгуулахдаа 30 хүртэлх хувийн урьдчилгаа олгодог, мөн тендерт ажлыг хугацаандаа хэрэгжүүлэхээр шаардлага хангаж шалгарсан компаниуд ажлаа хугацаандаа хэрэгжүүлдэггүй байдлуудаас валютын ханшийн эрсдэл, үнийн өсөлтөөс шалтгаалсан зардал нэмэгдэх, урьдчилгаа төлбөрийн гүйцэтгэл хангагдахгүй байх, тайлант оны төсөвт ачаалал үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. 2025 оны гэрээгээр гүйцэтгэсэн ажлуудыг түүвэрлэн шалгахад 78,153.7 сая төгрөгийн 14 гэрээнд урьдчилгаа төлбөрийг 30 хүртэл хувиар олгохоор тооцсон, гүйцэтгэлээр 3 гэрээний урьдчилгаа төлбөрт нийт 10,858.1 сая төгрөг олгосон, 3 гэрээний хугацааг сунгасан, 1 гэрээний төсөвт өртгийг нэмэгдүүлж гэрээ байгуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", 16 дугаар зүйлийн 16.1.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод

нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын ажилд урьдчилгаа олгосон зөрчлийг таслан зогсоож, урьд жилүүдэд үүссэн эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгож байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 9: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Эрдэнэс Монгол ХХК-тай менежментийн гэрээ байгуулж менежментийн үйлчилгээний төлбөрт 20,000.0 сая төгрөг төлсөн боловч дээд газрын шийдвэрээр бизнес төлөвлөгөөнд тусгуулах замаар нэгдлийн харьяа охин компаниудын алдагдлыг нөхөх, хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 13,575.2 сая төгрөгийг санхүүжүүлсэн байгаа нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, эдийн засгийг өрсөлдөөний зарчмаар ажиллах нөхцөлийг бууруулж байна. Үүнд:

- Цемент шохой ХХК-тай 2024 оны 12 дугаар сард "Технологийн шохой" худалдан авах 1 жилийн хугацаатай 8,867.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд тус гэрээний 2025.02.24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр үндсэн гэрээний ""барааг худалдан авагчид нийлүүлж акт үйлдсэний дараа нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ"" гэж заасныг зөрчиж нийлүүлэгч компанийн үйлдвэрлэлийн хүндрэлтэй байдлыг даван туулах дэмжлэгт урьдчилан 4,000.0 сая төгрөгийг олгохоор нэмэлт гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 2,000.0 сая төгрөгийг олгосон;
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК-ээс 40 мм, 80 мм-тэй ган бөөрөнцгийн бэлдэц худалдаж авахдаа нийт 3 гэрээний гүйцэтгэлээр 27,990.7 тонныг зах зээлийн үнээс тонн тутамд 0.6 сая төгрөгөөр илүү тооцож 16,449.4 сая төгрөгөөр, байгууллагаас ирүүлсэн үнийн саналаас тонн тутамд 0.3 сая төгрөгөөр илүү тооцож гүйцэтгэлээр 9,435.4 сая төгрөгөөр өндөр үнээр авсан;
- Засгийн газрын 2025.03.26-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2024 оны 185 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж Зэс боловсруулах цогцолбор ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ байсныг Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани болгон өөрчлөн баталсан боловч тус компанийн ажилтны цалин хөлс, тогтмол зардалд 2,139.8 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д "12.8.Энэ хуулийн 12.4, 12.6-д заасан хуулийн этгээд нь дүрэмд заасан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэхийг хориглоно.", Засгийн газрын 2025 оны "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 154 дүгээр тогтоолын 1."Бүтээн байгуулалтын төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 185 дугаар тогтоолын 1 дэх заалтын "Зэс боловсруулах цогцолбор" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг" гэсний дараа ""Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компани хэлбэрээр" гэж нэмж, мөн тогтоолын 3 дахь заалтын "дүрэм, бүтэц, орон тооны хязгаар, төсвийг баталж," гэснийг "дүрмийг баталж," гэж өөрчилсүгэй." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын зах зээлийн зарчмаар ажиллах боломжийг бууруулсан, бусад аж ахуйн нэгжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор, Эрдэнэ үйлдвэр ТӨҮГ-ын эрх

үүрэгт заагдаагүй аливаа зардлыг санхүүжүүлэх чиглэл өгсөн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 10: "Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар, угсралтын ажил" гүйцэтгүүлэхээр Засагт алтай ХХК-тай Нунтаглан баяжуулах хэсэгт 261.3 сая төгрөг, Техмонтаж ХХК-тай Бутлан тээвэрлэх хэсэгт 255.8 сая төгрөгийн дүнгээр гэрээ байгуулсан бөгөөд гэрээний 3.2 дахь заалтад 2026-2027 онд үргэлжлүүлэн жил бүр гэрээний үнийн дүнтэй тэнцүү хэмжээний мөнгөн дүнг төлөхөөр баталгаажуулсан байгаа нь тендер зарлахдаа оролцогчдод үнийг дутуу мэдээлсэн, дараагийн 2 жилд дээрх аж ахуйн нэгжүүдээс сонгон шалгаруулалтгүйгээр ажил гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн дээрх нөхцөлтэй ижил заалтыг гэрээнд тусгасан Авралын эрэлд ХХК Буга сэлгэн нутагшуулах ажилд 51.9 сая төгрөгийн 3 жилийн хугацаатай гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 39 дүгээр зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно." гэж заасантай нийцэхгүй байна." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа оролцогчдыг тэгш өрсөлдөх боломжоор хангаагүй, тендер шалгаруулалтын баримт бичигт нийт төсөвт өртөг, гэрээний хугацааг зөрүүтэй тусгасан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 11: Аж ахуйн нэгжээс гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа материалын нийлүүлэлтийг хугацаа хоцроож нийлүүлсэн боловч гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй, гэрээг цуцлаагүй, нийт дүнгээр санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Erlan Jin Tai Co., Ltd-тай 1000 тонн хүхэрт натри 2,501.1 сая төгрөгөөр худалдаж авахаар 2024.08.14-ний дотор нийлүүлж дуусах гэрээ байгуулсан боловч гүйцэтгэлээр 2024.08.30-2025.05.09-ны хооронд хугацаа хоцроож нийлүүлсэн хоног тутамд гэрээнд заасны дагуу 0.1 хувийн буюу 250.1 сая төгрөгийн алданги тооцоогүй;
- Сархиа бүрд ХХК "Фанер, модон материал" 2023 онд худалдан авахаар 788.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2023.10 дугаар сард нийлүүлэх хуваарьтай байсан боловч 2025.01.31-нд нийлүүлсэн гэрээнд заасны дагуу хоног тутамд 0.1 хувийн буюу 78.8 сая төгрөгийн алданги тооцоогүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заагдаагүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй аливаа хэлцлийг гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулалгүйгээр шийдвэрлэсэн, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаагүй хугацааны алдангийг тооцож суутгаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 12: Эрдэнэс Монгол ХХК-ын 2024 оны ТУЗ-ын 96 дугаар тогтоолоор ОХУ-ын Москва хот дахь худалдааны төлөөлөгчийн газар, БНХАУ-ын Бээжин хот дахь төлөөлөгчийн газруудын санхүүжилтийг 2025 оны эхний хагас жилд олгохоор баталсан, Ерөнхий захирлын 2025 оны 69 дүгээр тушаалаар тус газруудыг татан буулгасан боловч Эрдэнэс монгол ХХК-д харьяалалд шилжсэн бөгөөд албан бичгийн дагуу 70.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр

тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Төсвийн тухай хуулийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татан буугдаж, Эрдэнэс монгол ХХК-ийн харьяанд шилжсэн байнгын төлөөлөгчийн газруудад санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 13: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж дараах шаардлагагүй арга хэмжээг санхүүжүүлж нийт 3,689.1 сая төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна. Үүнд:

- Фитнесийн тоног төхөөрөмж худалдан авахад Их танил ХХК-аас 261.3 сая төгрөг;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын батлагдсан төсвөөс ажилтнуудын эрүүл мэнд асаргаа сувилгааны хөнгөлөлтөд 2,898.0 сая төгрөг, хамтын гэрээгээр олгож буй сургалтын зардалд 53.1 сая төгрөг, ажил мэргэжлийн уралдааны зардалд 1.4 сая төгрөг, нийт хэтрүүлэн зарцуулсан 2,952.2 сая төгрөг;
- Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар нь өөрийн байртай боловч барилгын зураг төсөв боловсруулах ажил гүйцэтгүүлэхэд 242.7 сая төгрөг;
- "Уурхайчдын спортын их наадам-2025" тэмцээнийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Монголын Уул уурхайн Үндэсний ассоциацитай хамтран Би саунд продакшн ХХК-д 60.0 сая төгрөг, тамирчдын хувцас худалдан авахад 22.1 сая төгрөг, нийт 82.1 сая төгрөг;
- Дарьганга гоёл ХХК-аас бэлэг дурсгалын зүйл авахад 75.7 сая төгрөг;
- Нью жуулчин турс ХХК-аас аяллын багцад шилжүүлсэн 72.0 сая төгрөг;
- Үйлдвэрийн бүтцэд 21 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй хуулийн хэлтэстэй боловч Өмгөөллийн онч нүүдэл ХХК-аас өмгөөллийн үйлчилгээнд 72.0 сая төгрөг;
- Наурызын баярын арга хэмжээнд 20.4 сая төгрөг;
- Улсын бүртгэл дээрх үйл ажиллагааны чиглэл таарахгүй Дүдү зоне ХХК-аас сургалтын зардал гэж 17.0 сая төгрөг;
- Зочин төлөөлөгч хүлээн авах, хурлын танхим цэцэгжүүлэхэд 14.2 сая төгрөг;
- Харбин 2025 Азийн өвлийн наадам үзэхэд 1 албан хаагчид олгосон 5.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна: 3.1.3."банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан;", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;", 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 4.2.9-т "энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8 "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулаагүй, хуулиар хязгаарласан үйл ажиллагаанд үр ашиггүй зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 14: Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх Хамтын гэрээнд үйлдвэрийн газарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмадуудад ахмадын өдөр, Монголын цагаан сараар нэг удаа тэтгэмж олгоно гэж заасан

боловч Ерөнхий захирлын Б/508, Б/514 тушаалуудаар сар шинийн баярыг тохиолдуулан нийт 464 ахмадад тэтгэмж олгосон боловч үүнээс 13 ахмадад нийт 46.5 сая төгрөгийн тэтгэмжийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна: 3.1.3-т "банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын захиргаа болон үйлдвэрчний эвлэлийн хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх Хамтын гэрээний 7.16-д " Үйлдвэрийн газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмадад Ахмадын өдөр, Монголын цагаан сараар тус тус нэг удаа батлагдсан журмын дагуу тэтгэмжийг олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хамтын гэрээний заалтыг зөрчиж, тэтгэмж давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 15: "Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай" хууль болон Засгийн газрын 2017 оны "Журам батлах тухай" 340 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд хүүхэд асрах чөлөөтэй эхчүүдэд олгодог мөнгөн тэтгэмжтэй давхцуулж Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх хамтын гэрээнд 0-3 хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй эхчүүдэд сар бүр 500.0 мянган төгрөг олгохоор тусгаж, тэтгэмжийн зардалд 1,263.7 сая төгрөг, Үйлдвэрчний эвлэлийн 2 гишүүнд 3.0 сая төгрөг нийт 1,266.7 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна: 3.1.3."банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан";, 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох";, Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дугаар зүйлийн 139.1-т "Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.", Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т " 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж";, 7 дугаар зүйлийн 7.1-т "Энэ хуулийн 5.1.1, 5.1.2, 5.1.3-т заасан тэтгэмжийн хэмжээг Засгийн газар тогтооно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дүгээр зүйл. Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг: "10/ эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах";, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "Журам батлах тухай" 340 дүгээр тогтоолын 2.-т "Жирэмсэн эхийн тэтгэмжийн хэмжээг сард 40.000 (дөчин мянган) төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг сард 50.000 (тавин мянган) төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 1.000.000 (нэг сая) төгрөг, 3 болон түүнээс дээш ихэр хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 3.000.000 (гурван сая) төгрөг байхаар тус тус тогтоосугай." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгалийн баялгийн хуваарилалтыг тэгш хүртэх, нийтийн эрх ашгийг хөндсөн зөрчлийг арилгаж, Хамтын гэрээний заалтыг холбогдох хууль тогтоомжийн заалттай нийцүүлэн боловсруулах **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 16: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй дараах зөрчлүүдийг давтан гаргаж, нийт 86.6 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Үүнд:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны Бизнес төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдаагүй хагас жилийн үр дүнгийн урамшууллыг ерөнхий захирлын 2025 оны "Үйлдвэрийн газрын 2025 оны эхний хагас жилийн ажлын үр дүнгээр ажилтнуудыг урамшуулах тухай" Б/1624 дүгээр тушаалаар үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй Эрдэнэт медикал ХХК-ийн албан хаагчдад олгосон 81.3 сая төгрөг,
- Эрдэнэт хотын бүтээн байгуулалтад оролцож байсан Монгол ажилчдын нэгдсэн захиргааны барилгачдын эрх ашгийг хамгаалах "Баатар" холбооны гишүүд болон Эрдэнэт үйлдвэрийн орон сууцны удирдах газарт ажиллаж байсан анхдагчдад олгосон 5.3 сая төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг, 25 дугаар зүйлийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг: "З/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй арга хэмжээнд дэмжлэг, хандив, тусламжийн шинжтэй зардлыг санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 17: Ерөнхий захирлын 2025 оны "2024 оны жилийн үр дүнгийн урамшуулал олгох тухай" Б/473 тоот тушаалаар үйлдвэрийн газрын бүтцийн нэгжүүдийн 2024 оны жилийн ажлын үр дүнг үнэлж урамшуулал олгосон ч 2025 оны Бизнес төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдаагүй хагас жилийн үр дүнгийн урамшуулалд нийт 10,702.3 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын цалин хөлсний талаар баримтлах бодлого" А/1147 тоот тушаалын 2-р хавсралт "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын цалин хөлсний тухай журам"-ын 4. Урамшуулал. 4.1. Үйлдвэрийн газрын болон тухайн бүтцийн нэгжийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамт олон, ажилтны оруулж буй хувь нэмэр, ажлын гүйцэтгэл, үр дүн, идэвх зүтгэлийг бодитоор үнэлж, ажилтнуудыг идэвхжүүлэх зорилгоор сар бүрийн ажлын үр дүнгийн урамшуулал, жилийн ажлын үр дүнгийн урамшуулал олгоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бизнес төлөвлөгөөнд тусгаж, батлуулаагүй аливаа зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв

Илрүүлэлт 18: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр, бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхээр нийт 10687 ажилтанд 8,433.3 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Үүнд:

- Ерөнхий захирлын 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/797 тоот тушаалаар үйлдвэрийн газрын хамт олонд 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөөг 106 хувиар биелүүлж, цэвэр ашгийн төлөвлөгөөг 123 хувиар давуулан биелүүлснийг үндэслэн Монгол Улсад уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 103 жилийн ой, уурхайчдын баярын өдрийг тохиолдуулан үйлдвэрийн газрын ажилтан,

үйлдвэрчний эвлэлийн гишүүд, тэтгэвэр тогтоолгосон ахмад, МШӨ-ий улмаас хөдөлмөрийн чадвар алдсан 10483 ажилчдад 8,076.9 сая төгрөг;

- "Урамшуулал олгох тухай" Б/1255, 1308, 1922, 2165, 2194, 2206, 2216, 2243, 2256, 2257, 2270 тоот тушаалуудаар салбарын болон зарим ажил мэргэжлийн, ажилчдын өдрийг тэмдэглэхээр 204 ажилтанд олгосон урамшуулалд 166.3 сая төгрөг;
- Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан ажилчдад үр дүнгийн урамшууллаас гадна Б/2208 тушаалаар байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх байгууллагын комиссын бүрэлдэхүүн болох 53 ажилтанд 75.5 сая төгрөг, А/736 тушаалаар ногоон хөгжлийн төслийн нэгжийн ажилчдыг мод тарьж ургуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажилласныг урамшуулж 8 ажилтанд 8.0 сая төгрөг, Б/2176 тушаалаар хамтын гэрээг дүгнэх, шинээр мөрдөх хамтын гэрээг байгуулах ажлын хэсгийн 13 ажилтанд 106.6 сая төгрөг, нийт 190.1 сая төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын цалин хөлсний талаар баримтлах бодлого" А/1147 тоот тушаалын 2-р хавсралт "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын цалин хөлсний тухай журам"-ын 4. Урамшуулал. 4.1. Үйлдвэрийн газрын болон тухайн бүтцийн нэгжийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамт олон, ажилтны оруулж буй хувь нэмэр, ажлын гүйцэтгэл, үр дүн, идэвх зүтгэлийг бодитоор үнэлж, ажилтнуудыг идэвхжүүлэх зорилгоор сар бүрийн ажлын үр дүнгийн урамшуулал, жилийн ажлын үр дүнгийн урамшуулал олгоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, ажилчдад үр дүнгийн урамшууллаас гадна нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр, бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 19: Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй хүргэх ажлыг гүйцэтгүүлэхээр МҮОНРТ-тэй 200.0 сая төгрөгийн гэрээ байгуулан тайлант онд 100.0 сая төгрөг, хэвлэл мэдээлэл, сонин, сайтын үйл ажиллагаа эрхэлдэг 20 байгууллагад 183.1 сая төгрөг, үйл ажиллагааны чиглэл өөр 4 байгууллагад 79.6 сая төгрөг, нийт 362.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлсэн, нотлох баримтын шаардлага хангаагүй, үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудад санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 20: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад оронд болох хурал, зөвлөгөөн, уулзалт яармагт оролцох, гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан томилолтын зам хоног, зочид буудлын зардлын хэмжээ"-г мөрдөлгүй үйлдвэрийн ажилтнуудын гадаад томилолт, сургалтын зардлын хэмжээг албан тушаалын ангилал тус бүрээр харилцан адилгүй тогтоож

олгосон байна. Тайлант хугацаанд аудитын түүвэрт хамрагдсан 35 гадаад томилолтын зардлыг тулган баталгаажуулахад Сангийн сайдын баталсан гадаад албан томилолтын зардлын хэмжээг 207.5 сая төгрөгөөр хэтрүүлэн олгож, өмнөх аудитаар хүргүүлсэн 681/А0170064/СНАГ-2025/098/НА-СТА-ТӨҮГ албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9-д "улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох", 20.1.10-д "эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Сангийн сайдын 2018 оны "Гадаад томилолтын зардлын хэмжээг батлах тухай" 188 дугаар тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажилтныг албан томилолтоор ажиллуулах тухай журмыг эрх бүхий байгууллагын баталсан "Гадаад томилолтын зардлын хэмжээг батлах тухай" журамтай нийцүүлэн боловсруулах, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, албан хаагчид **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 21: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдөр ирүүлж, хуулийн хугацааг хоцроосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", 70 дугаар зүйлийн 70.1-д "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг хуульд заагдсан хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлээгүй албан хаагчид **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэв.

2. Авлага данстай холбоотой:

Илрүүлэлт 1: Санхүүгийн тайланд шинж чанарын хувьд материаллаг нөлөөтэй, хэрэглэгчдийн санхүүгийн тайлангийн талаарх ойлголтод ач холбогдолтой, хууль, хяналтын байгууллага шилжүүлсэн Үндэсний хөрөнгө оруулалтын банктай холбоотой 42,358.7 сая төгрөгийн бусад авлага, Стандарт банктай холбоотой 107,264.4 сая төгрөгийн урт хугацаат авлагыг санхүүгийн тайланд дэлгэрэнгүй тодруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт", СТОУС-7 Санхүүгийн хэрэглүүр-Тодруулга 31-д "Санхүүгийн хэрэглүүрээс үүсэн бөгөөд тухайн тайлант үеийн эцэст аж ахуйн нэгжид учрах эрсдэлийн шинж төрөл ба хэмээг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн олгох мэдээллийг уг аж ахуйн нэгж нь тодруулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой, стандартаар заагдсан мэдээллийг тайланд тодруулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Санхүүгийн тайланд 110,677.6 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл байгаагаас 48.8 хувь буюу 53,970.3 сая төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга үүссэн байна. Үүнээс 2004-2021 оны хооронд 98 бэлтгэн нийлүүлэгчийн гэрээт ажлын урьдчилгаанд төлсөн 21,142.7 сая төгрөгийн ажлын гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаас 94 бэлтгэн нийлүүлэгчийн 20,259.0 сая төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга үүссэн бөгөөд авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Найдваргүй авлагын хасагдуулгад тооцож бүртгэсэн он удаан жил болсон авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, 30-с доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллах **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Санхүүгийн тайланд Стандарт банктэй холбоотой нийт 140,979.7 сая төгрөгийн урт хугацаат авлага бүртгэлтэй байгаагаас 107,264.4 сая төгрөгийн авлагыг Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2022 онд эцэслэн шийдвэрлэгдсэн боловч авлага өнөөг хүртэл барагдаагүй байна. Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Стандарт банктэй холбоотой 33,715.4 сая төгрөгийн бусад зардлыг иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэх эрхтэй болохыг дурдсан боловч үйлдвэрийн газар нь иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэрээр эцэслэн шийдвэрлэгдсэн авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, боломжит түргэн хугацаанд авлага барагдуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллах **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Өмнөх аудитаар өгсөн 676/A0170064/СНАГ-2025/098/НА-СТА-ТӨҮГ болон 682/A0170064/СНАГ-2025/098/НА-СТА-ТӨҮГ албан шаардлагын хэрэгжилтийг биелүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Эрдэнэс ус ДТС ОНӨХК-ийн 6,438.5 сая төгрөг, Ачит-Ихт ХХК-ийн 2,708.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр Эрдэнэт Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий захиралд даалгасан асуудал шийдэгдээгүй, Ачит ихт ХХК ногдол ашиг нөхөж төлөөгүй, байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөрийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй, үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа нь Ачит ихт ХХК Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлийг хууль бус захиргааны акт тул хүчингүй болгох тухай нэхэмжлэхийг шүүхэд гаргаж, байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагыг өөрийн эзэмшлийн талбайд нэвтрүүлээгүй мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/197 тоот албан бичгээр "Ачит ихт ХХК-ийн катодын зэс боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоосноос байгаль орчны болон технологийн ноцтой эрсдэл үүсэж буй тул эрсдэлийг бууруулах шаардлагын үүднээс үйлдвэрлэлийн ус, цахилгаан, зам ашиглалтын хязгаарлалтыг зогсоож, үйл ажиллагааг 2024 оны 08 дугаар сарын 21-ны өдрөөс эхлэн эрсдэл бүрэн арилгах хүртэл хэвийн явуулах" тухай чиглэл хүргүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна", Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т "Баялгийн сангийн хөрөнгө нь нийт ард түмний мэдэлд байх", 5.1.2-т "газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх", 11 дүгээр зүйлийн 11.1.2-т "...уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашгийг", Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл, Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т "Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлыг хэрэгжүүлж ажиллаагүй буруутай алба тушаалтанд **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэв.

3. Үндсэн хөрөнгө данстай холбоотой:

Илрүүлэлт 1: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2014 онд Номун Гранд ХХК-тай өр барагдуулах гэрээ байгуулж, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 7 дугаар багийн Дэнжийн 49 дүгээр байрны нийт 28 айлын 919.9 мкв талбай бүхий 1-2 өрөө орон сууцыг хүлээн авсан ба 28 ажилтан, ахмад настантай "Орон сууц зээлээр худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулснаас 13 ажилтан нь хуваарийн дагуу орон сууцны төлбөрийг бүрэн төлж, өөрийн өмчлөлд шилжүүлэн авах эрх үүссэн ба үндсэн хөрөнгийг данснаас хасах эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад ТӨБЗГ-ын 2025 оны А-2/1993 дугаар "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгээр Орхон аймгийн орон сууц хувьчлах товчоонд өмчлөх асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-ын 2 дахь хэсэг "Төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө", 11 дүгээр зүйл "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх", 11.8 дахь хэсэгт "төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах", 16 дугаар зүйл 16.2-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий байгууллагын шийдвэрээр баталгаажаагүй хөрөнгийн асуудлыг дур мэдэн шийдвэрлэсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны жилийн эцсийн тооллогоор нийт 197.9 сая төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй байна. Үүнд:

- Бараа материалын дансанд бүртгэлтэй 97.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ширхэг МПЭ-350-9006У2 маркийн цахилгаан хөдөлгүүр эд хөрөнгийн тооллогоор дутагдсан ба холбогдох хууль хяналтын байгууллагад хандсан боловч шийдвэрлүүлэх явц удаашралтай;
- Үндсэн хөрөнгийн дансанд Аж ахуй, үйлчилгээний цехэд бүртгэлтэй 24.7 сая төгрөгийн анхны өртөгтэй, 27 ширхэг тавилга, эд хогшил дутагдсан;
- Аж ахуй, үйлчилгээний цехийн орон сууцны хэсэгт бүртгэлтэй 75.5 сая төгрөгийн анхны өртөгтэй, 64 ширхэг тавилга, эд хогшил биетээр тоологдоогүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн тооллогоор дутагдсан хөрөнгийг тухайн хөрөнгийг ашиглахаар бүртгэлд тусгасан албан хаагчдаар нөхөн төлүүлээгүй, үйлдвэрийн газрын хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын данс бүртгэлд тусгаагүй эзэмших, ашиглах эрхтэй газар, орон сууцтай холбоотой нийт 27,112.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Орхон аймгийн Баян-Өндөр сумын Зэст багийн нутаг, Цагаанчулуутын аманд байрлах Уурхайчин-2, Уурхайчин-3 хорооллын 26,288.3 сая төгрөгийн үнэлгээтэй 4 өмчлөх эрхийн 72.63 га газрын өмчлөх эрхийн хугацаа 2021 онд дууссан бөгөөд 2022 онд Орхон аймгийн Засаг даргын захирамжаар тус газраас нийтийн эзэмшлийн шугам сүлжээ, зам

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

талбайг хасаж, газрын хэмжээг 56.05 га болгон 5 газрын гэрчилгээ олгосон боловч шинэчлэн олгосон газрын үнэлгээг хийлгэж, үндсэн хөрөнгөд бүртгээгүй;

- Үндсэн хөрөнгийн дансанд уул уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламж, Зуслан, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаас бусад, Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор, Амралтын газар зэрэг үйл ажиллагааны зориулалтаар 2019-2025 онуудад газар эзэмших эрхийн гэрчилгээг олгосон нийт 11,394.8 га талбайн хэмжээтэй 22 газрыг балансад бүртгээгүй;
- 6104143421 нэгж талбарын дугаартай Амины орон сууцны зориулалттай 1,546 кв газрын газар эзэмших эрхийн хугацаа дууссан, тус газар хаана байрлалтай, газар эзэмших эрхийн хугацааг сунгасан эсэх талаар мэдээлэл тодорхойгүй;
- Неман констракшн ХХК-тай 2021 онд орон сууцны фонд бүрдүүлэхээр 2021/14/30/0698 дугаартай "Худалдах худалдан авах" гэрээг байгуулсан. Тус гэрээний нөхцөлд заасан 4 өөр талбайн хэмжээтэй 18 орон сууцыг хүлээн авахаас гүйцэтгэлээр "Уурхайчин-1" хороололд 13 орон сууцыг хүлээн авч, 99.92 кв талбайн хэмжээтэй 3 өрөө, нийт 824.3 сая төгрөгийн анхны өртөгтэй 5 орон сууцыг хүлээн аваагүй, данс бүртгэлд тусгаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ын 1 дэх хэсэгт "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", НББОУС 16 Үндсэн хөрөнгө, Хүлээн зөвшөөрөлт 7. "Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө", 7(а) тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь тухайн аж ахуйн нэгжид орох нэлээд их магадлалтай байх; (б) аж ахуйн нэгж тухайн хөрөнгөөс олж авахаар хүлээгдэж буй бүтээгдэхүүн буюу түүнтэй ижил төсөөтэй нэгжүүдийн тоо хэмжээ, СТОУС 9 Бүлэг 3 хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын эзэмшилтэй боловч данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийг бүртгэлжүүлээгүй, хугацаа дууссан газрын эрхийг сунгуулаагүй, өмч хөрөнгөд тавих хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын барилга байгууламжийн данстай холбоотой нийт 10,314.7 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Тус ТӨҮГ нь 2021 онд нэр бүхий 2 компанитай Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4-р баг, Хүрэнбулаг Цагаанчулуутын ам 0 тоот газарт "Уурхайчин-1" хороололд орон сууцны фонд бүрдүүлэхээр Худалдах худалдан авах гэрээг байгуулж, 6,448.2 сая төгрөгийн анхны өртөгтэй 27 орон сууцыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн боловч орон сууцны өмчлөх эрхийн гэрчилгээг одоог хүртэл Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын нэр дээр гаргуулаагүй;
- Эко хороололд нийт 2,107.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, тус бүр 116 кв талбайтай, 2 давхар 4 ширхэг хаус, нийт 1,759.2 сая төгрөгийн анхны өртөгтэй тус бүр 50-64 кв талбайтай 3 өрөө 6 ширхэг амины орон сууц бүртгэлтэй бөгөөд тухайн хороололд ямар албан тушаалтан ямар нөхцөлөөр амьдардаг нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна", 16 дугаар зүйлийн 16.1-ын 1 дэх хэсэгт "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө

хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, орон сууц, түүнд оршин сууж байгаа этгээд тодорхойгүй, бүртгэлжүүлээгүй, мэдээллийн сан үүсгэж ажиллаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2025 оны А/351, А/352 дугаар Бээжин дэх худалдааны төлөөлөгчийн газар, Москва дах худалдааны төлөөлөгчийн газруудыг татан буулгах тухай тушаал гаргасан ч нийт 9,554.7 сая төгрөгийн хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах талаар тушаал, шийдвэр гараагүй, хөрөнгийн асуудлыг шийдээгүй байна. Үүнд:

- Бээжин дэх худалдааны төлөөлөгчийн газарт бүртгэлтэй нийт 3,058.1 сая төгрөгийн төлөөлөгчийн газрын оффис, 3 өрөө байр, "Mercedes Benz V260" маркийн автомашин болон тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүд;
- Москва дахь худалдааны төлөөлөгчийн газарт бүртгэлтэй нийт 6,496.6 сая төгрөгийн 4 орон сууц, "Volkswagen Caravelle" маркийн микроавтобус Toyota Alphard, Toyota Land Cruiser Prado-150 автомашин, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүд.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ын 1 дэх хэсэгт "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Татан буугдсан төлөөлөгчийн газрын хөрөнгийг шаардлагатай алба хэлтэст шилжүүлээгүй, тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

4. Өглөг данстай холбоотой:

Илрүүлэлт 1: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2020 онд Хятадын Засгийн газарт зориулж 278.0 сая төгрөг, ОХУ-д 128.2 сая төгрөгийн "Ковид-19"-ийн хандив, 2024 онд Малчдад 142.7 сая төгрөгийн хандив цуглуулах зорилгоор үйлдвэрийн ажилчдын цалингаас 30.0-50.0 мянган төгрөгийг суутган авч Хятадын засгийн газарт 288.0 сая төгрөг, ОХУ хандив авахаас татгалзсан тул цуглуулсан хандиваас 80.0 сая төгрөгийг Орхон, Булган аймгийн Онцгой байдлын ерөнхий газрууд руу тус тус шилжүүлсэн боловч, нийт суутган авсан хандивыг бүрэн шилжүүлэлгүйгээр тайлант оны эцэст цалингаас суутгасан бусад өглөг дансны үлдэгдэлд 180.9 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно", 119.1.1-д "ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг ажилтнаар нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан", 119.1.2-т "шүүхийн, эсхүл хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсон", 119.1.3-т "ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан", 119.1.4-т "хууль тогтоомжид заасан бусад тохиолдол", Төсвийн тухай хуулийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3-т "Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд зааснаас өөрөөр ажилтнуудын цалингаас хандивын мөнгө суутган авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

5. Худалдан авах ажиллагаатай холбоотой:

Илрүүлэлт 1: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний 1.3-т заасны дагуу +/-5 хувийн тоо хэмжээний хэлбэлзэлтэй уялдуулан гэрээний үнийн дүнг нийт 2,551.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд:

- Сан петролиум ХХК-тай байгуулсан "Өвлийн дизель түлш евро 5"-г нийлүүлэх 2025/07-Н-0093 дугаартай гэрээнд заасны дагуу 6,536.0 мянган килограммыг 7-50 хоногийн дотор богино хугацаанд нийлүүлсэн боловч гэрээний 1.3-т заасныг үндэслэн +/-5 хувийн тоо хэмжээний хэлбэлзлийг тооцож 307.2 килограмм буюу 980.0 сая төгрөгөөр;
- Jinan Libao Mine Accessories Co.,Ltd компанитай 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 2025/10-11-0085 дугаартай, 1,410,750.00 ам.доллараар ган бөөрөнцөг ф125 /багц 1,2/-ыг худалдан авах гэрээг, 282,975.00 ам.долларын нэмэлт гэрээг, нийт 1,693,725.00 ам.долларын гэрээг байгуулж, гүйцэтгэлээр нийт 1,477,924.80 ам.долларыг олгож, +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож 78,769.35 ам.доллар буюу 275.8 сая төгрөгөөр;
- Шинэгангиг ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр 2025/11-38-0048 дугаартай "Баяжмалын уутны бэлдэц Багц 1"-ийг худалдан авах гэрээг, 5,783.5 сая төгрөгийн гэрээг байгуулж, гүйцэтгэлээр нийт 6,044.4 сая төгрөгийг олгож, +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож 261.0 сая төгрөгөөр;
- Yiwu Hongtai Import and Export Co Ltd компанитай 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр 2025/07-11-0001 дугаартай, 1,440,000.00 ам.доллараар 2000 тонн хүхэрт натрийг худалдан авах гэрээ байгуулж, гүйцэтгэлээр +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож, 85.8 тонн 61,798.32 ам.доллар буюу 246.7 сая төгрөгөөр;
- Yiwu Hongtai Import and Export Co.,Ltd компанитай 2025/05-11-0140 дугаартай гэрээнд 2000 тонн хүхэрт натрийг 1,300,00.00 ам.доллараар худалдан авахаар тусгаж, гүйцэтгэлээр +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож 78.0 тонн 50,710.40 ам.доллар буюу 189.4 сая төгрөгөөр;
- Мөн нээлттэй тендер шалгаруулалтын аргаар шалгаруулж, үр дүн гарсан 19 ажлын гэрээний үнийн дүнг нийт 598.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 36 дугаар зүйлийн 36.1-т "Захиалагч дараах нөхцөлд нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж болно", 36.1.3-т "нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол", 36.1.4-т "нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан ажлын нэмэлт ажлын өртөг анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрэхгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол", 39 дүгээр зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно", 39.3.Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана: 39.3.1-д "гэрээний үнэ", 39.3.8-д "гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал", 40 дугаар зүйлийн 40.1.2-т "энэ хуулийн 11.11-д заасан нөхцөл, аргачлалын дагуу гэрээний үнийг тохируулах" гэж заасантай тус тус нийцэхгүй, Баяжмалын уутны бэлдэц I худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичгийн II бүлэг. Өгөгдлийн хүснэгт: ТШЗ 21.5-д "Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: "Тохируулахгүй тогтмол байна" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжийн дагуу нэмэлт гэрээ байгуулалгүйгээр, гэрээний заалтад тусгаж, төсөвт өртгийг хэтрүүлэн худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Тайлант онд Хүнд механизм худалдан авах ЭҮТӨҮГ/202402681 дугаартай тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасныг зөрчин Майнс ап ХХК-аас 2023 онд үйлдвэрлэсэн 3,699.0 сая төгрөгийн өртөгтэй "Гинжит бульдозер Liebherr PR 776"-г Чанарын хяналтын хэлтсийн актаар хүлээн авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно", 39.3.Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана: 39.3.1-д "гэрээний үнэ", 39.3.8-д "гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал", 40 дугаар зүйлийн 40.1.2-т "энэ хуулийн 11.11-д заасан нөхцөл, аргачлалын дагуу гэрээний үнийг тохируулах", 40 дүгээр зүйлийн 40.1.1-д "захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах" гэж заасныг мөрдөөгүй, мөн Хүнд механизм худалдан авах ЭҮТӨҮГ/202402681 дугаартай тендерийн баримт бичиг, Ү24/10-8290 техникийн тодорхойлолтын 7-д "Үйлдвэрлэсэн огноо: шинэ, 2024 ба 2025 онд үйлдвэрлэсэн байх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заагдаагүй хөрөнгө худалдан авч, зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний дүнгээс 2,921.7 сая төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна. Үүнд:

- Yiwu Hongtai Import and Export Co Ltd компанитай 2025.01.14-ний өдөр 2025/07-11-0001 дугаартай, 1,440,000.00 ам.доллороор 2000 тонн хүхэрт натрийг худалдан авах гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нэмэлт гэрээ байгуулалгүйгээр +/-5%-ийн хэлбэлзлийг тооцож олгосноос гадна гэрээний үнийн дүнг 107.0 тонн 77,018.24 ам.доллар буюу 275.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж худалдан авалт хийсэн;
- Шарын гол ХК-тай 2024 онд байгуулсан "Эрчим хүчний нүүрс"-ний 29,007.0 сая төгрөгийн гэрээг +/-5 хувийн нөхцөлтэйгээр худалдан авсан бөгөөд гүйцэтгэлээр 33,104.0 сая төгрөгийн бараа материал авсан нь гэрээнд заасан нийлүүлэлтээс 2,646.6 сая төгрөгөөр давсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 39 дүгээр зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно", 39.3.Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана: 39.3.1-д "гэрээний үнэ", 39.3.8-д "гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал", 40 дугаар зүйлийн 40.1.2-т "энэ хуулийн 11.11-д заасан нөхцөл, аргачлалын дагуу гэрээний үнийг тохируулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Харилцагчтай байгуулсан гэрээний үнийн дүнгээс хэтрүүлсэн, нэмэлт гэрээ байгуулаагүй, төлөвлөгдөөгүй худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй нэг эх үүсвэрээс худалдан авалт хийхдээ албан ёсны эрхийг төлөөлж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулсан туршлага, тендер шалгаруулалтад оролцсон, гүйцэтгэсэн ажлын үр дүн, эрхээ хязгаарлуулсан

эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан эсвэл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд эсэхийг магадалж, цаашид нийлүүлэгчээс шалтгаалсан үйлдвэрт учирч болзошгүй эрсдэлийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээг үйл ажиллагаанд ашиглах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Беллинк ХХК-тай "Хүнд даацын өөрөө буулгагч автомашины сэлбэг"-ийг 22,944.8 сая төгрөгөөр худалдан авах №2025/03-20-0227 дугаар гэрээг 2025.07.04-ны өдөр байгуулсан ба 2025.12.18-нд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрээний хугацааг 2025.12.31-ны өдрийг дуустал сунгасан боловч 2025 оны жилийн эцсийн байдлаар бараа материалыг дутуу нийлүүлсэн, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ", 7.1.9-д "энэ хуулийн 56.5.3, 56.5.4, 56.5.5-д заасан үндэслэлээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд" гэж заасантай тус тус нийцээгүй, Худалдах худалдан авах №2025/03-20-0227 дугаар гэрээний 10.2-т "Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал энэ тухайгаа уг нөхцөл байдал үүссэнээс хойш бараа нийлүүлэх хугацаанд багтаж 10 хоногийн дотор нөгөө талд бичиг (албан ёсны цахим шуудан болон цаасаар)-ээр мэдэгдэнэ. Уг мэдэгдэл нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим эсхүл эрх бүхий байгууллагаар баталгаажсан байна" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй аж ахуйн нэгжийн урьдчилгаа төлбөрийн баталгааг арилжааны банкнаас үл маргах журмаар гаргуулах, гэрээг дүгнэж алданги тооцох, эсхүл гэрээг цуцлах, байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тодотгол хийгээгүй дараах ажлууд байна. Үүнд:

- "Хүдэр бэлтгэх нэгдүгээр шатны бутлуурын шинэчлэлийн ажил Багц-2+"-ын ЭҮТӨҮГ/202501011408 дугаартай худалдан авах ажиллагаанд Барилга хөгжлийн төвийн магадлалыг үндэслэн зураг төслийн ажлын зохиогчийн хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээг 1,276.7 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан;
- Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авахаар Өмгөөллийн Онч Нүүдэл ХХН-тэй 2025.05.06-нд Ачит Ихт ХХК-ийн 2024.05.24-ны 1/179 дугаар албан бичгээр Захиргааны хэргийн давж заалдах анхан шатны шүүхэд Засгийн газрын 2024 оны 16 дугаар тэмдэглэлийн 26.5-ийн 1,2 дугаар хэсэгт заасан шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасантай холбоотой ТӨБЗГ-ын даргын 2024 оны А-1/1588 дугаар албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу ГШБА-аар 180.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй, төсөвт төлөвлөөгүй арга хэмжээг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 6: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс 18,804.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий 45 гэрээ байгуулсан 31 аж ахуйн нэгж байгууллага нь гэрээнд заасан хугацаанд бараа материалыг бүрэн нийлүүлэхгүй, гэрээний

үүргээ биелүүлэхгүй байгаа нь үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа доголдох эрсдэлийг дагуулж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина", Худалдах, худалдан авах гэрээний 5 дугаар зүйлийн 5.2.1-т "Гэрээнд заасан чанар, стандартын шаардлагад нийцсэн, тоо хэмжээ, иж бүрдэл бүхий биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй барааг дагалдах баримт бичгийн хамт заасан хугацаанд нийлүүлэх мөн шинэ байх ба ашиглагдсанаас хойш баталгаат хугацаа 12 сар байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-т "Гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу барааг нийлүүлэхийг худалдагчаас шаардах", 9 дүгээр зүйлийн 9.1-т "Худалдагч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг худалдан авагчид төлөх ба алдангийн нийт дүн нийт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулахаас өмнө тендерийн баримт бичиг, оролцогчид тавих шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, шаардлагад нийцэж байгаа эсэхийг бүрэн нягтлаагүй, харилцагч талуудын гэрээний эрх, үүргийн заалт, хариуцлагын асуудлыг нэмэгдүүлж гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах гэрээний хэрэгжилтээс хамаарах аливаа эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 7: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2 төрлийн нийт 992.7 сая төгрөгийн үйлчилгээг худалдан авах ажиллагааны цахим системээр зарлаагүй байна. Үүнд:

- Оюутын талбайн археологийн хайгуул, судалгааны ажил хийлгэхээр 45.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр харьцуулалтын аргаар шалгаруулахаар төлөвлөгөөнд тусгасан ч худалдан авах ажиллагааны цахим системээр зарлаагүй МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэнтэй 44.7 сая төгрөгийн гэрээг шууд байгуулсан;
- Санхүүгийн тайланд олон улсын хөндлөнгийн аудит хийлгэх 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулахаар төлөвлөгөөнд тусгасан боловч худалдан авах ажиллагааны цахим системд нийтлээгүй, Кэй Пи Эм Жи Аудит ХХК-тай 948.0 сая төгрөгийн гэрээг шууд байгуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана", 32 дугаар зүйлийн 32.1-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ", 32.2-т "Нээлттэй тендер шалгаруулалтын зарлалыг энэ хуулийн 18.1-д заасны дагуу нийтэлнэ", 34 дүгээр зүйлийн 34.1-т "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалт явуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 8: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бодитой төлөвлөж, нэмэлтээр шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаас өмнө хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж ажиллаагүйгээс шалтгаалан "Хүнд даацын өөрөө буулгагч автомашин"-ны 8 авто тээврийн хэрэгслийн 2 удаагийн нээлттэй тендер шалгаруулалтад Трансвест Монголиа ХХК шалгарч Уурхайн хүнд даацын өөрөө буулгагч автомашин Komatsu HD1500-8 маркийн тээврийн хэрэгслийг худалдан авсан ч нийлүүлж зарлаагүй тендерийн үр дүнд нэгж тээврийн хэрэгслээс 584.5 сая төгрөг, нийт 2,338.0 сая төгрөгийн алдагдалтай гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Komatsu HD1500-8 уурхайн хүнд даацын өөрөө буулгагч 4 автомашиныг 2025.06.18-ны өдрийн 2025/03-20-0211 тоот гэрээгээр нэгж тээврийн хэрэгслийг 9,334.3 сая төгрөгөөр нийт 37,337.4 сая төгрөгөөр;
- Komatsu HD1500-8 уурхайн хүнд даацын өөрөө буулгагч 4 автомашиныг 2025.11.10-ны өдрийн 2025/10-20-0460 тоот гэрээгээр нэгж тээврийн хэрэгслийг 8,749.8 сая төгрөгөөр нийт 34,999.4 сая төгрөгөөр тус тус гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бодитой төлөвлөж, нэмэлтээр шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаас өмнө хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж ажиллаагүй, нэг бараа ажил үйлчилгээг нэг аж ахуйн нэгжээс, нэг тайлант хугацаанд, өөр үнээр худалдан авч илүү зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 9: Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ЭҮТӨҮГ/20250102007 тендер шалгаруулалтын дугаартай 36,122.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Өвлийн дизель түлш I"-ийг Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн ч тус тендер шалгаруулалттай холбоотой нийт 9,886.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Тус ажлын төсөвт өртгөөс технологийн нормчлогдсон материалын нөөц бүрдүүлж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангах зайлшгүй шаардлагаар "Сод Монгол групп" ХХК-тай 2024 онд "Зуны дизель түлш" нийлүүлэхээр байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан тус гэрээний техникийн тодорхойлолтод тусгагдаагүй өвлийн евро 5 дизель түлшийг худалдан авахаар 2025.02.07-нд нэмэлт гэрээ байгуулан 9,395.1 сая төгрөгийн дизель түлшийг тухайн нийлүүлэх барааны зах зээлийн үнэлгээг үл харгалзан зуны дизель түлш худалдан авсан нэгжийн үнийн дүнгээр тооцоолон нэмэлт гэрээ байгуулсан;
- Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагддаг өвөл, зуны дизель түлшний худалдан авах гэрээнд бараа нийлүүлэх хуваарийг оновчтой тодорхойлоогүй, нөөц агуулах савны багтаамж хүрэлцээг тооцоогүй зэргээс гэрээний хугацааг сунгаж, нийлүүлэгч "Шунхлай групп" ХХК-д шатахуун хадгалалтын хөлсөнд 491.1 сая төгрөг төлж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн

аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд тогтмол ашиглагддаг бараа материалын худалдан авалтыг үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангаж, хуулийн хүрээнд оновчтой төлөвлөж, зохион байгуулж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээгээр зөвшөөрөгдөөгүй, чиг үүрэгт заагдаагүй бүтцийн 7 нэгж /Соёл урлагийн цогцолбор, Спорт цогцолбор, Оёдлын цех, Барилга засварын цех, Ногоон хөгжил төслийн нэгж, Сэлэнгэ амралт, аялал жуулчлалын цогцолбор /амралтын бааз, зуслан, катеринг, зочид буудал, нийтийн хоол, асрамжийн төв/-ийг цех хэлбэрээр, түүнд харьяалах 791 албан хаагчийг бүтцэд баталж, тайлант онд 16,566.6 сая төгрөгийн алдагдлыг санхүүжүүлсэн нь үйлдвэрийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна. Үүнд:

- Үйлдвэрийн газрын 2025 оны бизнес төлөвлөгөөнд орлогыг 7,844.5 сая төгрөг, зардлыг 44,668.1 сая төгрөгөөр буюу 36,783.6 сая төгрөгийн алдагдалтайгаар баталсан;
- Гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөөг 52.5 хувь буюу 4,142.3 сая төгрөг, зардлыг 85.0 хувь буюу 37,976.3 сая төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна: 3.1.3."банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан"; 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох."; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг: 3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д "12.8.Энэ хуулийн 12.4, 12.6-д заасан хуулийн этгээд нь дүрэмд заасан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэхийг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрийн газрын Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдаагүй, үйл ажиллагааны чиг үүрэгт хамааралгүй нийгмийн шинжтэй цехүүдэд олгох татаасыг нэн тэргүүнд бууруулж, үе шаттайгаар хувьчлах асуудлыг шийдвэрлэх.

Илрүүлэлт 2: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын өмчлөлийн "Монголиан смелтинг корпорэйшн" ХХК нь үйлдвэрийн арилжааны банкны 407359915 дугаартай дансанд өмнөх эзэмшигчийн данснаас 34,556.25 фунт стерлинг буюу 162.8 сая төгрөгийн буцаалт гэсэн утгатай орлого орж ирсэн бөгөөд компанийн арилжааны банкны валютын дансанд 21,717.5 фунт стерлинг, төгрөгөөрх дансны 133.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т 153.8 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа ч үйлдвэрт төлөх өглөгийн асуудлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө."; 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт"; СТОУС-10 Санхүүгийн нэгтгэсэн тайлан "5 Санхүүжигч аж ахуйн нэгж дэх оролцооныхоо шинж төрлөөс үл хамааран, хөрөнгө оруулагч нь уг санхүүжүүлэгчийг хянадаг эсэхээ үнэлснээр өөрөө толгой компани мөн эсэхийг тодорхойлно. 6 Хөрөнгө оруулагч

нь санхүүжигч аж ахуйн нэгж дэх өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй бөгөөд уг санхүүжүүлэгч дэх бүрэн эрхээрээ дамжуулан тэдгээр өгөөжид нөлөө үзүүлэх чадвар, боломжтой бол тухайн хөрөнгө оруулагч нь санхүүжигчийг хянана. 7 Иймээс хөрөнгө оруулагч нь дараах шинжүүдтэй бол, зөвхөн тийм тохиолдолд уг хөрөнгө оруулагч нь санхүүжигчийг хянана: (а) санхүүжигчийн хувь бүрэн эрхтэй (10–14-р параграфыг үзнэ үү); (б) санхүүжигч дэх өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй (15, 16-р параграфыг үзнэ үү); ба (в) хөрөнгө оруулагчийн өгөөжийн дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн санхүүжигч дэх өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломжтой (17, 18-р параграфыг үзнэ үү)." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрийн газар болон харьяа компанийн өр төлбөрийн асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж ажиллах.

Илрүүлэлт 3: ЗВТЕС Aufbereitungssysteme-тай 2020 онд байгуулсан 40.7 сая долларын төсөвт өртөгтэй "Ил уурхайн хөрсний тээвэрт мөчлөг урсгалт тээврийн технологи нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэх түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ"-нд 2023.07.21-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулж KPMG аудит ХХК-ийн тооцооллыг үндэслэн төсөвт өртгийг 29.3 сая ам.доллар буюу 30,657.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалтаар батлагдаж, тендер зарлан гэрээ байгуулсан ажлуудыг хугацаанд нь гүйцэтгүүлэх, бүтээгдэхүүний үнэ, валютын ханшийн зөрүүнээс шалтгаалан төсөвт өртөг нэмэгдэх нөхцөлд эрх бүхий байгууллагын тооцооллыг Төрийн аудитын байгууллагаар баталгаажуулж байх.

Илрүүлэлт 4: Төрийн дээд одон медаль, засгийн газрын болон аймаг, иргэдийн төлөөлөгчдийн хурлын жуух, тэмдгээр шагнагдсан ажилчдад нийт 492.7 сая төгрөгийн урамшуулал, тэтгэмж олгосон байна. Үүнд:

- Төрийн дээд одон медалиар шагнагдсан хүмүүст мөнгөн урамшуулал олгохоор заагдаагүй байхад тус үйлдвэрийн газрын шагналын ерөнхий журамд 1.0-5.0 сая төгрөгийн хооронд буюу хэт өндрөөр тусгаж, 219.9 сая төгрөгийн шагнал;
- "Засгийн газрын жуух бичиг", "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг болон Орхон аймгийн засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын жуух бичгээр шагнагдсан 721 ажилчдад нийт 272.8 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна: 3.1.3."банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дүгээр зүйл. Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг: "10/ эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах", Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 19-ний "Журам батлах тухай" 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 1.7-д "Төрийн албан хаагчид энэ журамд заасан

мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн дээд одон медаль, засгийн газрын болон аймаг, иргэдийн төлөөлөгчдийн хурлын жуух, тэмдгээр шагнагдсан ажилчдад урамшуулал олгохгүй байх.

Илрүүлэлт 2: Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-т шаардлагатай ажил, мэргэжлийн жагсаалтад заагдаагүй бизнесийн эрх зүй-хуульч мэргэжлээр Австри улсад суралцах 1 ажилтны сургалтын тэтгэлэгт 2023-2025 онуудад 15,000.00 ам.доллар буюу 52.3 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ерөнхий захирлын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр баталсан "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-т шаардлагатай ажил, мэргэжлийн жагсаалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын захирлын баталсан тушаалыг мөрдөөгүй, жагсаалтад тусгагдаагүй мэргэжлээр албан хаагчийг тэтгэлэгтэй сургалтад хамруулж, санхүүжилт олгохгүй байх.

2. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Өргөө хаан констракшн" ХХК 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын эзэмшлийн газар дээр 600 айлын орон сууцны барилгыг 100 хувь өөрийн хөрөнгөөр барьж, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын байр худалдан авах хүсэлтэй ажилчдад орон сууц худалдах, худалдан авах гэрээ байгуулан хүлээлгэн өгөх харилцааг зохицуулах "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ажилчдыг орон сууцжуулах барилгын ажлын гэрээ" байгуулсан. Харин үйлдвэрийн ажилтнууд "Өргөө хаан констракшн" ХХК-тай "Орон сууц захиалгаар бариулах гэрээ" байгуулж, гэрээний дагуу орон сууцны урьдчилгаа төлбөр төлсөн боловч 2021 оноос барилгын ажил зогссон байна. Хохирол, төлбөр барагдуулах тухай 2023 оны гэрээгээр "Уурхайчин-2" орон сууцны хороололд байр захиалж хохирсон үйлдвэрийн газрын ажилтан, ахмад настны "Өргөө хаан констракшн" ХХК-д төлсөн орон сууцны төлбөрийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь энэхүү гэрээнд заасан нөхцөлөөр үйлдвэрийн ажилтан, ахмад настанд төлөх, мөнгөн хөрөнгийг буцаан төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Үндэсний аудитын газраас 2023 онд өгсөн зөвлөмжийг дагуу дээр дурьсан асуудлыг хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх талаар арга хэмжээг авч ажилласан боловч шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй, санхүүгийн тайланд Өргөө хаан констракшн" ХХК-аас авах 9,766.3 сая төгрөгийн авлага бүртгэлд байна.

"Өргөөхаан констракшн" ХХК-иас 2026 оны 02-р сарын 10-ны өдрийн 004 албан бичгээр шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаа 9,766.3 сая төгрөгийн авлагыг 2026 оны 12-р сарын 15-ны дотор төлж барагдуулах боломжтой талаар санал хүргүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтнуудын орон сууцны урьдчилгаанд төлсөн төлбөрийг барагдуулах ажиллагааг эрчимжүүлэх, үйлдвэрийн газарт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авах

3. Хайгуултай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Хайгуул үнэлгээний хөрөнгийг хэрхэн бүртгэлд тусгах талаар байгууллагын онцлогт тохируулан, стандартад заасан аргуудаас оновчтой аргыг сонгон бүртгэлд тусгах талаар нарийвчлан тодорхойлоогүй, хэт ерөнхий байдлаар тусгасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 409 дүгээр тушаал "Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт" 4.2.2.1. "Аж ахуйн нэгж ашигт малтмалын нөөцийн хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлуудыг НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандарт, НББОУС 38 Биет бус хөрөнгө стандартуудад тодорхойлсон шаардлагатай нийцэж байвал хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үүнээс бусад хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлыг СТОУС 6 "Ашигт малтмалын нөөцийн хайгуул, үнэлгээ" стандартад нийцүүлэн тусгай зөвшөөрөл бүрээр НББ-дээ хөрөнгөөр бүртгэх, эсвэл зардал гарсан үед ашиг/алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэх гэсэн аргуудаас аль нэгийг нь сонгон нягтлан бодох бүртгэлийн бодлогоо тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Хайгуул үнэлгээний хөрөнгийг хэрхэн бүртгэлд тусгах талаар байгууллагын онцлогт тохируулан, стандартад заасан аргуудаас оновчтой аргыг сонгон бүртгэлд тусгах талаар нарийвчлан тодорхойлох.

Илрүүлэлт 2: Стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн овоо ордыг ашиглах явцад үүссэн, одоогоор ашиглагдахгүй байгаа бага агуулгатай хүдрийн овоолгыг ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулах чадавх бүхий хөрөнгө оруулагчийг хууль тогтоомжид нийцүүлэн нээлттэй, ил тод байх зарчмаар сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулахыг даалгасан Засгийн газрын 2025 оны 210 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Монгол Улсын засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 210 дугаар тогтоол "Экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэт овоо ордыг ашиглах явцад үүссэн, одоогоор ашиглагдахгүй байгаа бага агуулгатай хүдрийн овоолгыг ашиглах" гэж заасныг хэрэгжүүлээгүй.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангуулах тодорхой ажлын төлөвлөгөө гарган зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэх.

Илрүүлэлт 3: Эрдэнэт ТӨҮГ нь үйлдвэрлэлийн өртөг тооцохдоо зардлыг хуримтлуулан бүртгэж, өртөг тооцох тусгай бодлогыг оновчтой тодорхойлсон боловч бодит практикт энэхүү бодлого уялдахгүй байна. Тус үйлдвэр нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зардлыг "Дуусаагүй үйлдвэрлэл" дансанд хуримтлуулахгүйгээр тайлант сар бүрийн эцэст "Зардлын дахин хуваарилалт", "Дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлт", "Бэлэн бүтээгдэхүүний өөрчлөлт" зэрэг дансдуудыг ашиглан "Борлуулсан бүтээгдэхүүний өртөг" данс руу зардлыг шууд хуримтлуулан бүртгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.1.11 "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх", Сангийн сайдын 2022 оны 09 сарын 30-ний өдрийн 197 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Аж ахуй нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын 1.2 Тооцооны аргачлал нь олон улсын стандартад заагдсан бүх аргыг хэрэглэх боломжтой байх, 1.10 Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх үүсвэр иж бүрнээр/ анхан шатны баримтын мэдээлэл, дансанд бичилт хийсэн мэдээлэл/ тодорхой харуулдаг байх гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрлэлийн өртгийн тооцоолол, зардлыг хуримтлуулан бүртгэсэн бүртгэлийг санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд хялбар дөхөм, мэдээллийн эх үүсвэр иж бүрэн байдлаар харуулдаг байхаар программчлах.

Илрүүлэлт 4: Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний урсгал хөдөлгөөний дагуу зардал хуримтлуулан бүртгэж, өртөг тооцох процесс MS-Excel программд тулгуурлан гар аргаар боловсруулж байна. Тус байгууллагын санхүү бүртгэлийн ERA программын хязгаарлагдмал байдлаас шалтгаалан /өртөг тооцоолон бүртгэх цэс байхгүй/ зөвхөн "Зардлын дахин хуваарилалт", "Дуусаагүй

үйлдвэрлэлийн өөрчлөлт", "Бэлэн бүтээгдэхүүний өөрчлөлт" гэсэн данстуудаар дамжиж үүссэн хэлбэлзлийг тохируулах бичилт хийн бүртгэж, тайлагнаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.1.11 "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх", Сангийн сайдын 2022 оны 09 сарын 30-ний өдрийн 197 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Аж ахуй нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын 1.2 Тооцооны аргачлал нь олон улсын стандартад заагдсан бүх аргыг хэрэглэх боломжтой байх, 1.10 Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх үүсвэр иж бүрнээр/ анхан шатны баримтын мэдээлэл, дансанд бичилт хийсэн мэдээлэл/ тодорхой харуулдаг байх гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүртгэлийн өртөг тооцох, зардал хуваарилах процессын excel-ээр гүйцэтгэдэг механик ажиллагааг халах, хүнээс шалтгаалах алдааг бууруулах, программчлах асуудлыг шийдвэрлэх.

Илрүүлэлт 5: Нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалтыг холбогдох заавар журамд нийцүүлэн боловсруулж, мөрдөн ажиллах, зарим журнал, санхүүгийн баримтыг монгол хэлээр нийтэд ойлгомжтой хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1."Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нь нягтлан бодох бүртгэлээ монгол хэлээр хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй байна..

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалтыг холбогдох заавар журамд нийцүүлэн боловсруулж, мөрдөн ажиллах, зарим журнал, санхүүгийн баримтыг монгол хэлээр нийтэд ойлгомжтой хөтлөх.

4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 2: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 89-89УБ улсын дугаартай "Pisten bully.600" маркийн, 653.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн Трактор авто тээврийн хэрэгслийг 2009 онд "Шинэ Фермер" ХХК-ийн өмчлөлд бүртгэсэн, одоог хүртэл өмчлөгчийн мэдээллийг шилжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ын 1 дэх хэсэгт "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг хурааж, борлуулан улсын орлого болгох.

5. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий захирлын 2023 оны А/495 дугаар тушаалаар баталсан "Тус үйлдвэрт гэрээ байгуулах, бүртгэх, албан хэрэгцээнд ашиглах дүгнэх журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.3-т "Гэрээний нэр төрөл тус бүрээр +/-5%-ийн тоо хэмжээний хэлбэлзэл зөвшөөрөгдөх бөгөөд үүнтэй уялдуулан гэрээний үнийн дүнд +/-5%-ийн өөрчлөлт орохыг зөвшөөрөв" гэж заасан. Барааны шинж чанар, хэмжих нэгжээс хамаарч уг заалтыг гэрээнд тусгаж мөрдөхөөр байгаа боловч бараа бүтээгдэхүүний нарийвчлан гаргасан жагсаалт байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай, ачилт, тээвэрлэлтийн явцад хорогдох эрсдэлтэй бараа материалын жагсаалтыг боловсруулж, эрх

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

бүхий байгууллагаас зөвшөөрөл авч, батлуулсны дараа гэрээнд заалтаар тусгаж мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрдэнэс монгол ХХК-ийн 2024 оны А/95 тушаалаар баталгаажуулсан Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшинд Аймгийн ЗДТГ, ИТХ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд олгох нийт 30,523.6 сая төгрөгийн хандив, дэмжлэгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны зардалд төлөвлөж, бизнес төлөвлөгөөнд тусгасан нь үйлдвэрийн ашигт ажиллагааг бууруулахад нөлөөлж байна.	1	-			1	-						
2	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээгээр зөвшөөрөгдөөгүй, чиг үүрэгт заагдаагүй бүтцийн 7 нэгж /Соёл урлагийн цогцолбор, Спорт цогцолбор, Оёдлын цех, Барилга засварын цех, Ногоон хөгжил төслийн нэгж, Сэлэнгэ амралт, аялал жуулчлалын цогцолбор /амралтын бааз, зуслан, катеринг, зочид буудал, нийтийн хоол, асрамжийн төв/-ийг цех хэлбэрээр, түүнд харьяалах 791 албан хаагчийг бүтцэд баталж, тайлант онд 16,566.6 сая төгрөгийн алдагдлыг санхүүжүүлсэн нь үйлдвэрийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна.	1	16,566.6					1	16,566.6				
3	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын өмчлөлийн "Монголиан смелтинг корпорэйшн" ХХК нь үйлдвэрийн арилжааны банкны 407359915 дугаартай дансанд өмнөх эзэмшигчийн данснаас 34,556.25 фунт стерлинг буюу 162.8 сая төгрөгийн буцаалт гэсэн утгатай орлого орж ирсэн бөгөөд компанийн арилжааны банкны валютын дансанд 21,717.5 фунт стерлинг, төгрөгөөрх дансны 133.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т 153.8 сая төгрөгийн өр төлбөрийн	1	-					1	-				

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	үлдэгдэлтэй байгаа ч үйлдвэрт төлөх өглөгийн асуудлыг шийдүүрлээгүй байна.											
4	<p>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны эдийн үндсэн үзүүлэлтүүд зорилтод түвшний 2025.10.21-ний өдрийн ГЁ-131-12/4160 дугаар албан бичгээр баталсан Худалдан авах ажиллагааны тодотголд Улаанбаатар төмөр зам ХНН 2025.08.22-ны өдрийн 03/2797 тоот албан бичиг, ЗГ-ын тогтоолын дагуу 2 сарын вагон түрээсийн үйлчилгээнд 6,000.0 сая төгрөгийг төсөвлөж, баталсан. Техникийн тодорхойлолтод зөвхөн шаардлагын буюу ОХУ-ын 12-132 загварын хагас вагон эсвэл түүнтэй дүйцэхүйц гэсэн төрлөөр 350 вагоныг үндэслэлгүйгээр 19-50 ширхгээр хуваан 10 багцалсан, тендер шалгаруулалтын баримт бичигт ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх шаардлагыг огт оруулалгүй хасаж, нийт 2 сарын хугацаанд ажиллуулахаар төлөвлөсөн байна.</p> <p>Гүйцэтгэлээр нийт 9 багцын 300 вагоны түрээсийн тендерт Төмөр замын зураг, төслийн институт ХХК шалгарч 2025.12.28-ны өдрийн 5/289-2025 тоот гэрээгээр 4,811.8 сая төгрөг, 1 багцад 50 вагон түрээслэхээр Дулаанвинг ХХХ шалгарч 2026.01.26-ны өдрийн 5/019-2026 тоот гэрээгээр 850.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2026 оноос үйлчилгээнд явж эхлэхээр байгаа нь тодотголоор 2025 онд зайлшгүй шаардлагатай бус төсвийг баталсан, мөн тус үйлдвэрт эрх бүхий албан тушаал эрхэлж байсан хүний компани тус тендерийн 9 багцад шалгарсан байна.</p>	1	4,811.8			1	4,811.8			1	4,811.8	
5	<p>Тайлант хугацаанд гэрээт байгууллагуудтай холбоотой дараах зөрчил илэрсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.</p> <p>Үүнд: 1. Гэрээт цагдаа, дотоодын цэргийн өндөр насны тэтгэвэрт гарахад олгох 776.4 сая төгрөгийн тэтгэмжийн санхүүжилтийг Орхон аймаг дахь Цагдаагийн газар, Дотоодын цэргийн 816 дугаар ангийн дансанд төвлөрүүлэлгүй, хаан банкны дундын депозит</p>	1	802.5			1	802.5					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	дансанд шилжүүлсэн; 2. Гэрээт цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдын томилолтын зардалд 7.7 сая төгрөг, Дотоодын цэргийн марш тактикийн тэмцээний төсөвт 18.5 сая төгрөгийг тус тус олгосон байна.											
6	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын арилжааны банкны данстуудаар орлогын 9,682,647.5 сая төгрөгийн 10371, зарлагын 9,627,560.3 сая төгрөгийн 13442 гүйлгээ бүртгэгдсэн байна. Үүнээс харилцахын гүйлгээнээс архивын баримт руу хөөн шалгахад данстуудыг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн хуваарилаагүйгээс нийт бэлэн мөнгөний касс 11, арилжааны 28 банкны дансаар нийгмийн цехүүдийн болон үндсэн үйл ажиллагааны орлого, зарлагын гүйлгээ гарч байгаа нь мөнгөн хөрөнгийн зүй зохистой удирдлага, хяналт алдагдах эрсдэлийг үүсгэж байна.	1	-			1	-					
7	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Бизнес төлөвлөгөөнд үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар тэргүүлэх чиглэлд тусгасан боловч урлаг, спорт, баярын арга хэмжээний зардлын төсвийн 94.8 хувь буюу 3,326.2 сая төгрөгийн гүйлгээг "батлагдсан төсвийн дагуу, төсөв" гэсэн утгатай хувь хүний дансруу 663 гүйлгээ гарсан байгаа нь төсвийн зарцуулалтын ил тод байдал, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын удирдлагын хяналт алдагдах эрсдэлтэй байна. Тухайлбал тус зардлаас спортын арга хэмжээнд 548.8 сая төгрөг, олон нийтээр тэмдэглэлт өдрүүдийн зардалд 1,249.0 сая төгрөг, байгууллагын уралдаан тэмцээний зардалд 242.4 сая төгрөг, мэргэжлийн баяр, цехүүдийн арга хэмжээнд 209.5 сая төгрөгийг тус тус зарцуулж, байгууллагын албан хаагчдын дансаар дамжуулан гүйлгээ хийж байгаа нь худалдан авалтын төлөвлөгөөнөөс гадуурх гэрээ хэлцэлгүй, хяналтгүй, шууд худалдан авалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	1	2,030.2			1	2,030.2					
8	Дараа тайлангийн тооцоогоор гадаад албан томилолтын тийзийн төлбөрийг агаарын	1	277.2			1	277.2					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	тээврийн компаниудын арилжааны банкны дансанд шилжүүлсэн боловч харилцах дансны журналаар албан хаагчийн нэр дээр бүртгэсэн байна. Үүнд: 59 албан хаагч 182.9 сая төгрөгийг Эйртранс ХХК-руу, 13 албан хаагчийн 36.4 сая төгрөгийг Ай трип эйр ХХК-руу, 12 албан хаагчийн 27.7 сая төгрөгийг Нандинвэй ХХК-руу, 8 албан хаагчийн 19.0 сая төгрөгийг Эйрлинк ХХК-руу, 2 албан хаагчийн 3.3 сая төгрөгийг Аэрмаркет ХХК-руу, 1 албан хаагчийн 7.9 сая төгрөгийг Эйр тикет ХХК-руу тус тус шилжүүлсэн байна.											
9	Сангийн сайдын 2024 оны "Дотоод албан томилолтын зардлыг хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаалыг мөрдөлгүй, алба, хэлтсийн дарга, ерөнхий инженер зэрэг удирдах түвшний албан хаагчдад 160.0-250.0 мянган төгрөгийн зочид буудлын төлбөр олгосноос дотоод албан томилолтын зардлын нормыг нийт 156.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Мөн томилолтын төсвийг боловсруулсан боловч холбоотой этгээдүүдийн гарын үсгээр огт баталгаажаагүй гүйлгээг гаргаж байна.	1	156.5			1	156.5					
10	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад оронд болох хурал, зөвлөгөөн, уулзалт яармагт оролцох, гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан томилолтын зам хоног, зочид буудлын зардлын хэмжээ"-г мөрдөлгүй үйлдвэрийн ажилтнуудын гадаад томилолт, сургалтын зардлын хэмжээг албан тушаалын ангилал тус бүрээр харилцан адилгүй тогтоож олгосон байна. Тайлант хугацаанд аудитын түүвэрт хамрагдсан 35 гадаад томилолтын зардлыг тулган баталгаажуулахад Сангийн сайдын баталсан гадаад албан томилолтын зардлын хэмжээг 207.5 сая төгрөгөөр хэтрүүлэн олгож, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	207.5						1	207.5		
11	Хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион	1	10,858.1			1	10,858.1					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	байгуулахдаа шалгаруулж байгаа аж ахуйн нэгжийн санхүүгийн чадавхыг үнэлж байгаа боловч гэрээг байгуулахдаа 30 хүртэлх хувийн урьдчилгаа олгодог, мөн тендерт ажлыг хугацаандаа хэрэгжүүлэхээр шаардлага хангаж шалгарсан компаниуд ажлаа хугацаандаа хэрэгжүүлдэггүй байдлуудаас валютын ханшийн эрсдэл, үнийн өсөлтөөс шалтгаалсан зардал нэмэгдэх, урьдчилгаа төлбөрийн гүйцэтгэл хангагдахгүй байх, тайлант оны төсөвт ачаалал үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. 2025 оны гэрээгээр гүйцэтгэсэн ажлуудыг түүвэрлэн шалгахад 78,153.7 сая төгрөгийн 14 гэрээнд урьдчилгаа төлбөрийг 30 хүртэл хувиар олгохоор тооцсон, гүйцэтгэлээр 3 гэрээний урьдчилгаа төлбөрт нийт 10,858.1 сая төгрөг олгосон, 3 гэрээний хугацааг сунгасан, 1 гэрээний төсөвт өртгийг нэмэгдүүлж гэрээ байгуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.											
12	<p>Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Эрдэнэс Монгол ХХК-тай менежментийн гэрээ байгуулж менежментийн үйлчилгээний төлбөрт 20,000.0 сая төгрөг төлсөн боловч дээд газрын шийдвэрээр бизнес төлөвлөгөөнд тусгуулах замаар нэгдлийн харьяа охин компаниудын алдагдлыг нөхөх, хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 13,575.2 сая төгрөгийг санхүүжүүлсэн байгаа нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, эдийн засгийг өрсөлдөөний зарчмаар ажиллах нөхцөлийг бууруулж байна. Үүнд:</p> <p>1. Цемент шохой ХХК-тай 2024 оны 12 дугаар сард "Технологийн шохой" худалдан авах 1 жилийн хугацаатай 8,867.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд тус гэрээний 2025.02.24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр үндсэн гэрээний "барааг худалдан авагчид нийлүүлж акт үйлдсэний дараа нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ" гэж заасныг зөрчиж нийлүүлэгч компанийн үйлдвэрлэлийн хүндрэлтэй байдлыг даван туулах дэмжлэгт урьдчилан 4,000.0 сая төгрөгийг олгохоор нэмэлт гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 2,000.0 сая төгрөгийг олгосон;</p>	1	13,575.2			1	13,575.2					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	<p>2. Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК-ээс 40 мм, 80 мм-тэй ган бөөрөнцгийн бэлдэц худалдаж авахдаа нийт 3 гэрээний гүйцэтгэлээр 27,990.7 тонныг зах зээлийн үнээс тонн тутамд 0.6 сая төгрөгөөр илүү тооцож 16,449.4 сая төгрөгөөр, байгууллагаас ирүүлсэн үнийн саналаас тонн тутамд 0.3 сая төгрөгөөр илүү тооцож гүйцэтгэлээр 9,435.4 сая төгрөгөөр өндөр үнээр авсан;</p> <p>3. Засгийн газрын 2025.03.26-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2024 оны 185 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж Зэс боловсруулах цогцолбор ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ байсныг Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани болгон өөрчлөн баталсан боловч тус компанийн ажилтны цалин хөлс, тогтмол зардалд 2,139.8 сая төгрөг олгосон байна.</p>											
13	<p>Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар, угсралтын ажил" гүйцэтгүүлэхээр Засагт алтай ХХК-тай Нунтаглан баяжуулах хэсэгт 261.3 сая төгрөг, Техмонтаж ХХК-тай Бутлан тээвэрлэх хэсэгт 255.8 сая төгрөгийн дүнгээр гэрээ байгуулсан бөгөөд гэрээний 3.2 дахь заалтад 2026-2027 онд үргэлжлүүлэн жил бүр гэрээний үнийн дүнтэй тэнцүү хэмжээний мөнгөн дүнг төлөхөөр баталгаажуулсан байгаа нь тендер зарлахдаа оролцогчдод үнийг дутуу мэдээлсэн, дараагийн 2 жилд дээрх аж ахуйн нэгжүүдээс сонгон шалгаруулалтгүйгээр ажил гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн дээрх нөхцөлтэй ижил заалтыг гэрээнд тусгасан Авралын эрэлд ХХК Буга сэлгэн нутагшуулах ажилд 51.9 сая төгрөгийн 3 жилийн хугацаатай гэрээ байгуулсан байна.</p>	1	569.1			1	569.1					
14	<p>ЗВТЕС Aufbereitungssysteme-тай 2020 онд байгуулсан 40.7 сая долларын төсөвт өртөгтэй "Ил уурхайн хөрсний тээвэрт мөчлөг урсгалт тээврийн технологи нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэх түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ"-нд 2023.07.21-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулж KPMG аудит ХХК-ийн тооцооллыг үндэслэн төсөвт өртгийг 29.3 сая ам.доллар</p>	1	-			1	-					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	буюу 30,657.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.												
15	Аж ахуйн нэгжээс гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа материалын нийлүүлэлтийг хугацаа хоцроож нийлүүлсэн боловч гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй, гэрээг цуцлаагүй, нийт дүнгээр санхүүжилтийг олгосон байна. Үүнд: 1. Erlan Jin Tai Co., Ltd-тай 1000 тонн хүхэрт натри 2,501.1 сая төгрөгөөр худалдаж авахаар 2024.08.14-ний дотор нийлүүлж дуусах гэрээ байгуулсан боловч гүйцэтгэлээр 2024.08.30-2025.05.09-ны хооронд хугацаа хоцроож нийлүүлсэн хоног тутамд гэрээнд заасны дагуу 0.1 хувийн буюу 250.1 сая төгрөгийн алданги тооцоогүй; 2. Сархиа бүрд ХХК "Фанер, модон материал" 2023 онд худалдан авахаар 788.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2023.10 дугаар сард нийлүүлэх хуваарьтай байсан боловч 2025.01.31-нд нийлүүлсэн гэрээнд заасны дагуу хоног тутамд 0.1 хувийн буюу 78.8 сая төгрөгийн алданги тооцоогүй.	1	328.9			1	328.9						
16	Эрдэнэс Монгол ХХК-ын 2024 оны ТУЗ-ын 96 дугаар тогтоолоор ОХУ-ын Москва хот дахь худалдааны төлөөлөгчийн газар, БНХАУ-ын Бээжин хот дахь төлөөлөгчийн газруудын санхүүжилтийг 2025 оны эхний хагас жилд олгохоор баталсан, Ерөнхий захирлын 2025 оны 69 дүгээр тушаалаар тус газруудыг татан буулгасан боловч Эрдэнэс монгол ХХК-д харьяалалд шилжсэн бөгөөд албан бичгийн дагуу 70.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	70.7			1	70.7						
17	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж дараах шаардлагагүй арга хэмжээг санхүүжүүлж нийт 3,689.1 сая төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.	1	3,689.1			1	3,689.1						
18	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх Хамтын гэрээнд үйлдвэрийн газарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмадуудад цагаан сараар нэг удаа	1	46.5			1	46.5						

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	тэтгэмж олгоно гэж заасан боловч Ерөнхий захирлын Б/508, Б/514 тушаалуудаар 464 ахмадад нийт 46.5 сая төгрөгийн тэтгэмжийг давхардуулан олгосон байна.											
19	Төрийн дээд одон медаль, засгийн газрын болон аймаг, иргэдийн төлөөлөгчдийн хурлын жуух, тэмдгээр шагнагдсан ажилчдад нийт 492.7 сая төгрөгийн урамшуулал, тэтгэмж олгосон байна. Үүнд: - Төрийн дээд одон медалиар шагнагдсан хүмүүст мөнгөн урамшуулал олгохоор заагдаагүй байхад тус үйлдвэрийн газрын шагналын ерөнхий журамд 1.0-5.0 сая төгрөгийн хооронд буюу хэт өндрөөр тусгаж, 219.9 сая төгрөгийн шагнал; - "Засгийн газрын жуух бичиг", "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг болон Орхон аймгийн засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын жуух бичгээр шагнагдсан 721 ажилчдад нийт 272.8 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.	1	492.7				1	492.7				
20	"Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай" хууль болон Засгийн газрын 2017 оны "Журам батлах тухай" 340 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд хүүхэд асрах чөлөөтэй эхчүүдэд олгодог мөнгөн тэтгэмжтэй давхцуулж Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх хамтын гэрээнд 0-3 хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй эхчүүдэд сар бүр 500.0 мянган төгрөг олгохоор тусгаж, тэтгэмжийн зардалд 1,263.7 сая төгрөг, Үйлдвэрчний эвлэлийн 2 гишүүнд 3.0 сая төгрөг нийт 1,266.7 сая төгрөг олгосон.	1	-			1	-					
21	Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагуудыг хэрэгжүүлж ажиллаагүй дараах зөрчлүүдийг давтан гаргаж, нийт 120.9 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Үүнд: 1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны Бизнес төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдаагүй хагас жилийн үр дүнгийн урамшууллыг ерөнхий захирлын 2025 оны "Үйлдвэрийн газрын 2025	1	86.6			1	86.6					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	оны эхний хагас жилийн ажлын үр дүнгээр ажилтнуудыг урамшуулах тухай" Б/1624 дүгээр тушаалаар үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй Эрдэнэт медиал ХХК-ийн албан хаагчдад олгосон 81.3 сая төгрөг, 2. Эрдэнэт хотын бүтээн байгуулалтад оролцож байсан МАНЗ-ны барилгачдын эрх ашгийг хамгаалах "Баатар" холбооны гишүүд болон Эрдэнэт үйлдвэрийн орон сууцны удирдах газарт ажиллаж байсан анхдагчдад олгосон 5.3 сая төгрөг.											
22	Монгол Улсын Шадар сайдын 2024 оны "Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" 10 дугаар тушаалаар хүчингүй болсон Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 22 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-г үндэслэн Ерөнхий захирлын "Ажилтнуудыг урамшуулах тухай" 2025 оны Б/85, А/751 дугаар тушаалуудаар 912 ажилтанд 18.2 сая төгрөгийн урамшууллыг илүү олгосон байна.	1	18.2	1	18.2							
23	Ерөнхий захирлын 2025 оны "2024 оны жилийн үр дүнгийн урамшуулал олгох тухай" Б/473 тоот тушаалаар үйлдвэрийн газрын бүтцийн нэгжүүдийн 2024 оны жилийн ажлын үр дүнг үнэлж урамшуулал олгосон ч 2025 оны Бизнес төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдаагүй хагас жилийн үр дүнгийн урамшуулалд нийт 10,702.3 сая төгрөгийн урамшуулал олгосон.	1	10,702.3			1	10,702.3					
24	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр, бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхээр нийт 10687 ажилтанд 8,433.3 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Үүнд: - Ерөнхий захирлын 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/797 тоот тушаалаар үйлдвэрийн газрын хамт олонд 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөөг 106 хувиар биелүүлж, цэвэр ашгийн төлөвлөгөөг 123 хувиар давуулан	1	8,433.3			1	8,433.3					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	<p>биелүүлснийг үндэслэн Монгол Улсад уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 103 жилийн ой, уурхайчдын баярын өдрийг тохиолдуулан үйлдвэрийн газрын ажилтан, үйлдвэрчний эвлэлийн гишүүд, тэтгэвэр тогтоолгосон ахмад, МШӨ-ий улмаас хөдөлмөрийн чадвар алдсан 10483 ажилчдад 8,076.9 сая төгрөг; - "Урамшуулал олгох тухай"Б/1255, 1308, 1922, 2165, 2194, 2206, 2216, 2243, 2256, 2257, 2270 тоот тушаалуудаар салбарын болон зарим ажил мэргэжлийн, ажилчдын өдрийг тэмдэглэхээр 204 ажилтанд 166.3 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. - Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан ажилчдад үр дүнгийн урамшууллаас гадна Б/2208 тушаалаар байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх байгууллагын комиссын бүрэлдэхүүн болох 53 ажилтанд 75.5 сая төгрөг, А/736 тушаалаар ногоон хөгжлийн төслийн нэгжийн ажилчдыг мод тарьж ургуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажилласныг урамшуулж 8 ажилтанд 8.0 сая төгрөг, Б/2176 тушаалаар хамтын гэрээг дүгнэх, шинээр мөрдөх хамтын гэрээг байгуулах ажлын хэсгийн 13 ажилтанд 106.6 сая төгрөг, нийт 190.1 сая төгрөгийн урамшуулал олгосон.</p>											
25	<p>"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй хүргэх ажлыг гүйцэтгүүлэхээр МҮОНРТ-тэй 200.0 сая төгрөгийн гэрээ байгуулан тайлант онд 100.0 сая төгрөг, хэвлэл мэдээлэл, сонин, сайтын үйл ажиллагаа эрхэлдэг 20 байгууллагад 183.1 сая төгрөг, үйл ажиллагааны чиглэл өөр 4 байгууллагад 79.6 сая төгрөг, нийт 362.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.</p>	1	362.7			1	362.7					
26	<p>"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-т шаардлагатай ажил, мэргэжлийн жагсаалтад заагдаагүй бизнесийн эрхзүй-хуульч мэргэжлээр Австри улсад суралцах 1 ажилтны сургалтын тэтгэлэгт 2023-2025 онуудад 15,000.00 ам.доллар буюу 52.3 сая төгрөгийг олгосон байна.</p>	1	52.3					1	52.3			

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

27	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 15-ны өдөр буюу хуулийн хугацаанд ирүүлээгүй байна.	1	-						1	-		
28	Санхүүгийн тайланд шинж чанарын хувьд материаллаг нөлөөтэй, хэрэглэгчдийн санхүүгийн тайлангийн талаарх ойлголтод ач холбогдолтой, хууль, хяналтын байгууллага шилжүүлсэн Үндэсний хөрөнгө оруулалтын банктэй холбоотой 42,358.7 сая төгрөгийн бусад авлага, Стандарт банктэй холбоотой 107,264.4 сая төгрөгийн урт хугацаат авлагыг санхүүгийн тайланд дэлгэрэнгүй тодруулаагүй	1	-			1	-					
29	Санхүүгийн тайланд 110,677.6 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл байгаагаас 48.8 хувь буюу 53,970.3 сая төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга үүссэн байна. Үүнээс 2004-2021 оны хооронд 98 бэлтгэн нийлүүлэгчийн гэрээт ажлын урьдчилгаанд төлсөн 21,142.7 сая төгрөгийн ажлын гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас 94 бэлтгэн нийлүүлэгчийн 20,259.0 сая төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга үүссэн бөгөөд авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.	1	21,142.7			1	21,142.7					
30	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Өргөө хаан констракшн" ХХК 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын эзэмшлийн газар дээр 600 айлын орон сууцны барилгыг 100 хувь өөрийн хөрөнгөөр барьж, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын байр худалдан авах хүсэлтэй ажилчдад орон сууц худалдах, худалдан авах гэрээ байгуулан хүлээлгэн өгөх харилцааг зохицуулах "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ажилчдыг орон сууцжуулах барилгын ажлын гэрээ" байгуулсан. Харин үйлдвэрийн ажилтнууд "Өргөө хаан констракшн" ХХК-тай "Орон сууц захиалгаар бариулах гэрээ" байгуулж, гэрээний дагуу орон сууцны урьдчилгаа төлбөр төлсөн боловч 2021 оноос барилгын ажил зогссон байна. Хохирол, төлбөр барагдуулах тухай 2023 оны гэрээгээр "Уурхайчин-2" орон сууцны хороололд байр	1	-					1	-			

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	захиалж хохирсон үйлдвэрийн газрын ажилтан, ахмад настны "Өргөө хаан констракшн" ХХК-д төлсөн орон сууцны төлбөрийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь энэхүү гэрээнд заасан нөхцөлөөр үйлдвэрийн ажилтан, ахмад настанд төлөх, мөнгөн хөрөнгийг буцаан төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Гэвч санхүүгийн тайланд Өргөө хаан констракшн" ХХК-аас 9,766.3 сая төгрөгийн авлага авахаар бүртгэлд тусгаж, тайлагнасан байна.											
31	Санхүүгийн тайланд Стандарт банктэй холбоотой нийт 140,979.7 сая төгрөгийн урт хугацаат авлага бүртгэлтэй байгаагаас 107,264.4 сая төгрөгийн авлагыг Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2022 онд эцэслэн шийдвэрлэгдсэн боловч авлага өнөөг хүртэл барагдаагүй байна. Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Стандарт банктэй холбоотой 33,715.4 сая төгрөгийн бусад зардлыг иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэх эрхтэй болохыг дурдсан боловч үйлдвэрийн газар нь иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаагүй.	1	33,715.4			1	33,715.4					
32	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг биелүүлж ажиллаагүй байна. Үүнд: 1."Эрдэнэс ус, ДТС" ОНӨХК-ийн 6,438.5 сая төгрөг, "Ачит-Ихт" ХХК-ийн 2,708.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй; 2. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр Эрдэнэс монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий захиралд даалгасан асуудал шийдэгдээгүй, "Ачит ихт" ХХК ногдол ашиг нөхөж төлөөгүй, байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөрийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй, үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа нь "Ачит ихт" ХХК Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн	1	9,147.4					1	9,147.4			

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	хуралдааны 16 дугаар тэмдэглэлийг хууль бус захиргааны акт тул хүчингүй болгох тухай нэхэмжлэхийг шүүхэд гаргаж, байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагыг өөрийн эзэмшлийн талбайд нэвтрүүлээгүй мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/197 тоот албан бичгээр "Ачит ихт ХХК-ийн катодын зэс боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоосноос байгаль орчны болон технологийн ноцтой эрсдэл үүсэж буй тул эрсдэлийг бууруулах шаардлагын үүднээс үйлдвэрлэлийн ус, цахилгаан, зам ашиглалтын хязгаарлалтыг зогсоож, үйл ажиллагааг 2024 оны 08 дугаар сарын 21-ны өдрөөс эхлэн эрсдэл бүрэн арилгах хүртэл хэвийн явуулах" тухай чиглэл хүргүүлсэн зэргээс шалтгаалсан байна.											
33	Бараа материалын данстай холбоотой нийт 9,919.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд: 1. Нэг жил хүртэлх жилийн насжилттай 308.1 сая төгрөг, нэгээс гурав хүртэлх жилийн насжилттай 3,337.5 сая төгрөг, гурваас дээш жилийн насжилттай 6,146.1 сая төгрөг, нийт 34 нэр төрлийн 9,791.7 сая төгрөгийн бараа материалыг удаан хугацаанд нөөцөлсөн нь цаашид ашиглалтын шаардлага хангах, ашиглах эсэх нь тодорхойгүй; 2. Нийт 127.3 сая төгрөгийн үнийн дүнтэй 21 нэр төрлийн хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг дансны ангилал зөрүүлэн бүртгэсэн;	1	9,919.0					1	9,919.0			
34	Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Хайгуул үнэлгээний хөрөнгийг хэрхэн бүртгэлд тусгах талаар байгууллагын онцлогт тохируулан, стандартад заасан аргуудаас оновчтой аргыг сонгон бүртгэлд тусгах талаар нарийвчлан тодорхойлоогүй, хэт ерөнхий байдлаар тусгасан байна.	1	-					1	-			
35	Стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн овоо ордыг ашиглах явцад үүссэн, одоогоор ашиглагдахгүй байгаа бага агуулгатай	1	-					1	-			

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	хүдрийн овоолгыг ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулах чадавх бүхий хөрөнгө оруулагчийг хууль тогтоомжид нийцүүлэн нээлттэй, ил тод байх зарчмаар сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулахыг даалгасан Засгийн газрын 2025 оны 210 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.											
36	Эрдэнэт ТӨҮГ нь үйлдвэрлэлийн өртөг тооцохдоо зардлыг хуримтлуулан бүртгэж, өртөг тооцох тусгай бодлогыг оновчтой тодорхойлсон боловч бодит практикт энэхүү бодлого уялдахгүй байна. Тус үйлдвэр нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зардлыг "Дуусаагүй үйлдвэрлэл" дансанд хуримтлуулахгүйгээр тайлант сар бүрийн эцэст "Зардлын дахин хуваарилалт", "Дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлт", "Бэлэн бүтээгдэхүүний өөрчлөлт" зэрэг данстуудыг ашиглан "Борлуулсан бүтээгдэхүүний өртөг" данс руу зардлыг шууд хуримтлуулан бүртгэж.	1	-				1	-				
37	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний урсгал хөдөлгөөний дагуу зардал хуримтлуулан бүртгэж, өртөг тооцох процесс MS-Excel программд тулгуурлан гар аргаар боловсруулж байна. Тус байгууллагын санхүү бүртгэлийн ERA программын хязгаарлагдмал байдлаас шалтгаалан /өртөг тооцоолон бүртгэх цэс байхгүй/ зөвхөн "Зардлын дахин хуваарилалт", "Дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлт", "Бэлэн бүтээгдэхүүний өөрчлөлт" гэсэн данстуудаар дамжиж үүссэн хэлбэлзлийг тохируулах бичилт хийн бүртгэж, тайлагнаж байна.	1	-				1	-				
38	Нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалтыг холбогдох заавар журамд нийцүүлэн боловсруулж, мөрдөн ажиллах, зарим журнал, санхүүгийн баримтыг монгол хэлээр нийтэд ойлгомжтой хөтлөөгүй байна.	1	-				1	-				
39	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь 2014 онд "Номун Гранд" ХХК-тай өр барагдуулах гэрээ байгуулж, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 7 дугаар багийн Дэнжийн 49 дүгээр байрны нийт 28 айлын 919.9 мкв талбай бүхий 1-2 өрөө орон сууцыг хүлээн авсан ба уг орон сууцтай	1	1,287.9			1	1,287.9					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	<p>холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд: 1.Тус орон сууцуудыг НББОУС 40-ын дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө дансанд бүртгэсэн боловч ТӨБЗГ-ын төрийн өмчийн бүртгэлийн системд бүртгүүлээгүй; 2. Нийт 28 ажилтан, ахмад настантай "Орон сууц зээлээр худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулснаас 13 ажилтан нь хуваарийн дагуу орон сууцны төлбөрийг бүрэн төлж, өөрийн өмчлөлд шилжүүлэн авах эрх үүссэн ба үндсэн хөрөнгийг данснаас хасах эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад ТӨБЗГ-ын 2025 оны А-2/1993 дугаар "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгээр Орхон аймгийн орон сууц хувьчлах товчоонд өмчлөх асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн байна.</p>											
40	<p>"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын 2025 оны жилийн эцсийн тооллогоор нийт 197.9 сая төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй байна. Үүнд: 1. Бараа материалын дансанд бүртгэлтэй 97.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ширхэг МПЭ-350-9006У2 маркийн цахилгаан хөдөлгүүр эд хөрөнгийн тооллогоор дутагдсан ба холбогдох хууль хяналтын байгууллагад хандсан боловч шийдвэрлүүлэх явц удаашралтай; 2. Үндсэн хөрөнгийн дансанд Аж ахуй, үйлчилгээний цехэд бүртгэлтэй 24.7 сая төгрөгийн анхны өртөгтэй, 27 ширхэг тавилга, эд хогшил дутагдсан; 3. Аж ахуй, үйлчилгээний цехийн орон сууцны хэсэгт бүртгэлтэй 75.5 сая төгрөгийн анхны өртөгтэй, 64 ширхэг тавилга, эд хогшил биетээр тоологдоогүй.</p>	1	197.9			1	197.9					
41	<p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын данс бүртгэлд тусгаагүй эзэмших, ашиглах эрхтэй газар, орон сууцтай холбоотой нийт 27,112.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ</p>	1	27,112.6			1	27,112.6					
42	<p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын барилга байгууламжийн данстай холбоотой нийт 10,314.7 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд: 1. Тус ТӨҮГ нь 2021 онд нэр бүхий 2</p>	1	10,314.7			1	10,314.7					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	<p>компанитай Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4-р баг, Хүрэнбулаг Цагаанчулуутын ам 0 тоот газарт "Уурхайчин-1" хороололд орон сууцны фонд бүрдүүлэхээр Худалдах худалдан авах гэрээг байгуулж, 6,448.2 сая төгрөгийн анхны өртөгтэй 27 орон сууцыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн боловч орон сууцны өмчлөх эрхийн гэрчилгээг одоог хүртэл "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын нэр дээр гаргуулаагүй;</p> <p>2. Эко хороололд нийт 2,107.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, тус бүр 116 мкв талбайтай, 2 давхар 4 ширхэг хаус, нийт 1,759.2 сая төгрөгийн анхны өртөгтэй тус бүр 50-64 мкв талбайтай 3 өрөө 6 ширхэг амины орон сууц бүртгэлтэй бөгөөд тухайн хороололд ямар албан тушаалтан ямар нөхцөлөөр амьдардаг нь тодорхойгүй;</p>											
43	<p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2025 оны А/351, А/352 дугаар Бээжин дэх худалдааны төлөөлөгчийн газар, Москва дахь худалдааны төлөөлөгчийн газруудыг татан буулгах тухай тушаал гаргасан ч нийт 9,554.7 сая төгрөгийн хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах талаар тушаал, шийдвэр гараагүй, хөрөнгийн асуудлыг шийдээгүй байна. Үүнд:</p> <p>1. Бээжин дэх худалдааны төлөөлөгчийн газарт бүртгэлтэй нийт 3,058.1 сая төгрөгийн төлөөлөгчийн газрын оффис, 3 өрөө байр, "Mercedes Benz V260" маркийн автомашин болон тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүд;</p> <p>2. Москва дахь худалдааны төлөөлөгчийн газарт бүртгэлтэй нийт 6,496.6 сая төгрөгийн 4 орон сууц, "Volkswagen Caravelle" маркийн микроавтобус, ALPHARD, LAND GRUSER 150 PRADA автомашин, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүд;</p>	1	9,554.7			1	9,554.7					
44	<p>Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 89-89УБ улсын дугаартай "Pisten bully.600" маркийн, 653.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн Трактор авто тээврийн хэрэгслийг 2009 онд</p>	1	653.3					1	653.3			

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	"Шинэ Фермер" ХХК-ийн өмчлөлд бүртгэсэн, одоог хүртэл өмчлөгчийн мэдээллийг шилжүүлээгүй байна.											
45	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь 2020 онд Хятадын засгийн газарт зориулж 278.0 сая төгрөг, ОХУ-д 128.2 сая төгрөгийн "Ковид-19"-ийн хандив, 2024 онд Малчдад 142.7 сая төгрөгийн хандив цуглуулах зорилгоор үйлдвэрийн ажилчдын цалингаас 30.0-50.0 мянган төгрөгийг суутган авч Хятадын засгийн газарт 288 сая төгрөг, ОХУ хандив авахаас татгалзсан тул цуглуулсан хандиваас 80.0 сая төгрөгийг Орхон, Булган аймгийн Онцгой байдлын ерөнхий газрууд руу тус тус шилжүүлсэн боловч, нийт суутган авсан хандивыг бүрэн шилжүүлэлгүйгээр тайлант оны эцэст цалингаас суутгасан бусад өглөг 180.9 сая төгрөгийн өр төлбөртэй байна.	1	119.9			1	119.9					
46	Тус ТӨҮГ-ын бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний 1.3-т заасны дагуу +/-5 хувийн тоо хэмжээний хэлбэлзэлтэй уялдуулан гэрээний үнийн дүнг нийт 2,551.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд: 1. Сан петролиум ХХК-тай байгуулсан "Өвлийн дизель түлш евро 5"-г нийлүүлэх 2025/07-Н-0093 дугаартай гэрээнд заасны дагуу 6,536.0 мянган килограммыг 7-50 хоногийн дотор богино хугацаанд нийлүүлсэн боловч гэрээний 1.3-т заасныг үндэслэн +/-5 хувийн тоо хэмжээний хэлбэлзлийг тооцож 307.2 килограмм буюу 980.0 сая төгрөгөөр; 2. Jinan Libao Mine Accessories Co.,ltd компанитай 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 2025/10-11-0085 дугаартай, 1,410,750.00 ам.доллараар ган бөөрөнцөг ф125 /багц 1,2/-ыг худалдан авах гэрээг, 282,975.00 ам.долларын нэмэлт гэрээг, нийт 1,693,725.00 ам.долларын гэрээг байгуулж, гүйцэтгэлээр нийт 1,477,924.80 ам.долларыг олгож, +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож 78,769.35 ам.доллар буюу 275.8 сая төгрөгөөр; 3. Шинэгангиг ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр 2025/11-38-0048 дугаартай "Баяжмалын уутны бэлдэц Багц 1"-ийг	1	2,551.6			1	2,551.6					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	<p>худалдан авах гэрээг, 5,783.5 сая төгрөгийн гэрээг байгуулж, гүйцэтгэлээр нийт 6,044.4 сая төгрөгийг олгож, +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож 261.0 сая төгрөгөөр;</p> <p>4. Yiwu Hongtai Import and Export Co Ltd компанитай 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр 2025/07-11-0001 дугаартай, 1,440,000.00 ам.доллаароор 2000 тонн хүхэрт натрийг худалдан авах гэрээ байгуулж, гүйцэтгэлээр +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож, 85.8 тонн 61,798.32 ам.доллар буюу 246.7 сая төгрөгөөр;</p> <p>5. Yiwu Hongtai Import and Export Co.,Ltd компанитай 2025/05-11-0140 дугаартай гэрээнд 2000 тонн хүхэрт натрийг 1,300,00.00 ам.доллаароор худалдан авахаар тусгаж, гүйцэтгэлээр +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож 78.0 тонн 50,710.40 ам.доллар буюу 189.4 сая төгрөгөөр;</p> <p>6. Мөн нээлттэй тендер шалгаруулалтын аргаар шалгаруулж, үр дүн гарсан 19 ажлын гэрээний үнийн дүнг нийт 598.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.</p>											
47	<p>Тайлант онд Хүнд механизм худалдан авах ЭҮТӨҮГ/202402681 дугаартай тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасныг зөрчин Майнс ап ХХК-аас 2023 онд үйлдвэрлэсэн 3,699.0 сая төгрөгийн өртөгтэй "Гинжит бульдозер Liebherr PR 776"-г Чанарын хяналтын хэлтсийн актаар хүлээн авсан;</p>	1	3,699.0			1	3,699.0					
48	<p>Тус ТӨҮГ-ын бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний 2,921.7 сая төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна. Үүнд:</p> <p>1. Yiwu Hongtai Import and Export Co Ltd компанитай 2025.01.14-ний өдөр 2025/07-11-0001 дугаартай, 1,440,000.00 ам.доллаароор 2000 тонн хүхэрт натрийг худалдан авах гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нэмэлт гэрээ байгуулалгүйгээр +/-5%-ийн хэлбэлзлийг тооцож олгосноос гадна гэрээний үнийн дүнг 107.0 тонн 77,018.24 ам.доллар буюу 275.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж худалдан авалт хийсэн;</p> <p>2. Шарын гол ХК-тай 2024 онд байгуулсан</p>	1	2,921.7			1	2,921.7					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	"Эрчим хүчний нүүрс"-ний 29,007.0 сая төгрөгийн гэрээг -/+5 хувийн нөхцөлтэйгөөр худалдан авсан бөгөөд гүйцэтгэлээр 33,104.0 сая төгрөгийн бараа материал авсан нь гэрээнд заасан нийлүүлэлтээс 2,646.6 сая төгрөгөөр давсан байна.											
49	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй нэг эх үүсвэрээс худалдан авалт хийхдээ албан ёсны эрхийг төлөөлж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулсан туршлага, тендер шалгаруулалтад оролцсон, гүйцэтгэсэн ажлын үр дүн, эрхээ хязгаарлуулсан эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан эсвэл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд эсэхийг магадалж, цаашид нийлүүлэгчээс шалтгаалсан үйлдвэрт учирч болзошгүй эрсдэлийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээг үйл ажиллагаанд ашиглах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, НЭҮХА аргаар Беллинк ХХК-тай "Хүнд даацын өөрөө буулгагч автомашины сэлбэг"-ийг 22,944.8 сая төгрөгөөр худалдан авах №2025/03-20-0227 дугаар гэрээг 2025.07.04-ны өдөр байгуулсан ба 2025.12.18-нд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрээний хугацааг 2025.12.31-ны өдрийг дуустал сунгасан боловч 2025 оны жилийн эцсийн байдлаар бараа материалыг дутуу нийлүүлсэн, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.	1	22,944.8			1	22,944.8					
50	Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тодотгол хийгээгүй дараах ажлууд байна. Үүнд: 1. "Хүдэр бэлтгэх нэгдүгээр шатны бутлуурын шинэчлэлийн ажил Багц-2+"-ын ЭҮТӨҮГ/202501011408 дугаартай худалдан авах ажиллагаанд Барилга хөгжлийн төвийн магадлалыг үндэслэн зураг төслийн ажлын зохиогчийн хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээг 1,276.7 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан; 2. Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авахаар Өмгөөллийн Онч Нүүдэл ХХН-тэй 2025.05.06-нд Ачит Ихт ХХК-ийн 2024.05.24-ны 1/179 дугаар албан бичгээр	1	1,456.7			1	1,456.7					

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Захиргааны хэргийн давж заалдах анхан шатны шүүхэд Засгийн газрын 2024 оны 16 дугаар тэмдэглэлийн 26.5-ийн 1,2 дугаар хэсэгт заасан шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасантай холбоотой ТӨБЗГ-ын даргын 2024 оны А-1/1588 дугаар албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу ГШБА-аар 180.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.											
51	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс 18,804.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий 45 гэрээ байгуулсан 31 аж ахуйн нэгж байгууллага нь гэрээнд заасан хугацаанд бараа материалыг бүрэн нийлүүлэхгүй, гэрээний үүргээ биелүүлэхгүй байгаа нь үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа доголдох эрсдэлийг дагуулж байна.	1	18,804.7			1	18,804.7					
52	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2 төрлийн нийт 992.7 сая төгрөгийн үйлчилгээг худалдан авах ажиллагааны цахим системээр зарлаагүй байна. Үүнд: 1. Оюутын талбайн археологийн хайгуул, судалгааны ажил хийлгэхээр 45.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр харьцуулалтын аргаар шалгаруулахаар төлөвлөгөөнд тусгасан ч худалдан авах ажиллагааны цахим системээр зарлаагүй МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэнтэй 44.7 сая төгрөгийн гэрээг шууд байгуулсан; 2. Санхүүгийн тайланд олон улсын хөндлөнгийн аудит хийлгэх 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулахаар төлөвлөгөөнд тусгасан боловч худалдан авах ажиллагааны цахим системд нийтлээгүй, Кэй Пи Эм Жи Аудит ХХК-тай 948.0 сая төгрөгийн гэрээг шууд байгуулсан.	1	992.7			1	992.7					
53	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий захирлын 2023 оны А/495 дугаар тушаалаар баталсан "Тус үйлдвэрт гэрээ байгуулах, бүртгэх, албан хэрэгцээнд ашиглах дүгнэх журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.3-т "Гэрээний нэр төрөл тус бүрээр +/-5%-ийн тоо хэмжээний хэлбэлзэл зөвшөөрөгдөх бөгөөд үүнтэй	1	-					1		-		

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	уялдуулан гэрээний үнийн дүнд +/-5%-ийн өөрчлөлт орохыг зөвшөөрөв" гэж заасан. Барааны шинж чанар, хэмжих нэгжээс хамаарч уг заалтыг гэрээнд тусгаж мөрдөхөөр байгаа боловч бараа бүтээгдэхүүний нарийвчлан гаргасан жагсаалт байхгүй байна.												
54	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бодитой төлөвлөж, нэмэлтээр шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаас өмнө хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тушаалд нэмэлт өөрчлөлт ажиллаагүйгээс шалтгаалан "Хүнд даацын өөрөө буулгагч автомашин"-ны 8 авто тээврийн хэрэгслийн 2 удаагийн нээлттэй тендер шалгаруулалтад Трансвест Монголиа ХХК шалгарч Уурхайн хүнд даацын өөрөө буулгагч автомашин Komatsu HD1500-8 маркийн тээврийн хэрэгслийг худалдан авсан ч нийлүүлж зарлаагүй тендерийн үр дүнд нэгж тээврийн хэрэгслээс 584.5 сая төгрөг, нийт 2,338.0 сая төгрөгийн алдагдалтай гэрээ байгуулсан байна. Үүнд: 1. Komatsu HD1500-8 уурхайн хүнд даацын өөрөө буулгагч 4 автомашиныг 2025.06.18-ны өдрийн 2025/03-20-0211 тоот гэрээгээр нэгж тээврийн хэрэгслийг 9,334.3 сая төгрөгөөр нийт 37,337.4 сая төгрөгөөр; 2. Komatsu HD1500-8 уурхайн хүнд даацын өөрөө буулгагч 4 автомашиныг 2025.11.10-ны өдрийн 2025/10-20-0460 тоот гэрээгээр нэгж тээврийн хэрэгслийг 8,749.8 сая төгрөгөөр нийт 34,999.4 сая төгрөгөөр тус тус гэрээ байгуулсан байна.	1	2,338.0			1	2,338.0						
55	Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ЭҮТӨҮГ/20250102007 тендер шалгаруулалтын дугаартай 36,122.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Өвлийн дизель түлш I"-ийг Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн ч тус тендер шалгаруулалттай холбоотой нийт 9,886.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн.	1	9,886.2			1	9,886.2						
	Дүн	55	262,898.7	1	18.2	37	225,841.8	14	27,683.8	3	9,354.9	1	4,811.8

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6.2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д.д	Зерчлийн товч утга	Нийт зерчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зерчил									
1	Шилэн дансны мэдээллийн системд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5,051,802.5 сая төгрөгийн 2072 орлогын, 4,533,706.6 сая төгрөгийн 3594 зарлагын гүйлгээ мэдээлэхээс 78,946.9 сая төгрөгийн 249 ажил гүйлгээг хугацаа хоцроож тайлагнасан.	1	-					1	-
	Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зерчил									
1	Засгийн газрын тогтоол, дээд шатны байгууллагаас төсвийн жилийн дундуур, гэнэтийн шийдвэрүүдээр ирсэн чиглэлийн дагуу үйлдвэрийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй 33,582.7 сая төгрөгийн санхүүжилт, дэмжлэг олгосон байгаа нь төрийн өмчит компаниудад ирэх төсвийн дарамтыг нэмэгдүүлж, үйлдвэрийн урт хугацааны төлөвлөлтийг удаашруулах, төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын ажлуудыг гацааж, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.	1	33,582.7			1	33,582.7		
2	Засгийн газрын 2025 оны 94, 135 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын А/138 дугаар тушаалаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын ажлуудыг царцаах, үйл ажиллагааны зардлыг бууруулах замаар нэгдлийн компаниудад улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлого, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх үүрэг даалгавар, чиглэл ирсний дагуу үйлдвэрийн захирлын зөвлөлийн хурлын 2025/04 дүгээр шийдвэрээр сүүлийн хагас жилийн бизнес төлөвлөгөөнд улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг нэмэгдүүлэх, зарим хөрөнгө оруулалтын ажлыг бууруулан төлөвлөж дээд газарт хүргүүлсэн байна. Гүйцэтгэлээр жилийн эцэст 2026 оны 1 дүгээр сарын экспортын орлого буюу 235,748.2 сая төгрөгийг харилцагч 6 аж ахуйн нэгжээс урьдчилж авч улсын төсвийн татварын урьдчилгаанд 177,385.0 сая төгрөг, Эрдэнэс Монголын менежментийн төлбөрт 20,000.0 сая төгрөг, ОНХС-нд 5,000.0 сая төгрөг, Засгийн газрын 127 дугаар тогтоолоор Сангийн яаманд 754.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон бол Хаан банкнаас оны эцэст 141,943.4 сая төгрөгийн /40.0 мянган ам.доллар/ хүүтэй зээл авч үндсэн үйл ажиллагааны зардлыг төлж /25.0 мянган ам.долларыг 12 сарын 30,31-нд буцааж төлсөн/, мөн тодотголоор тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсвийг 58,600.0 сая төгрөгөөр бууруулан, зарим хөрөнгө оруулалтын ажлуудыг хойшлуулсан нь ирээдүйд үйлдвэрийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, санхүүгийн сахилга бат алдагдах, хүүгийн дарамтад орох, санхүүгийн чадавхыг бууруулах, дараа дараагийн шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах боломжийг бууруулах эрсдэлтэй байна	1	377,691.8			1	377,691.8		
3	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын худалдан авах ажиллагаанд оролцож буй байгууллагуудын өмнөх шалгарсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл болон олон гэрээг давхардуулан авч буй эсэхийг үнэлгээний хороо үнэлдэггүйгээс 7 багцтай тендер шалгаруулалтын 5	1	19,358.1			1	19,358.1		

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	багцад нэр бүхий 2 компани шалгарч нийт 19,358,082,000.00 /Арван есөн тэрбум гурван зуун тавин найман сая наян хоёр мянга/ төгрөгийн гэрээг байгуулсан нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлтийг хангахгүй, гэрээнд заасан хугацаанд барааг нийлүүлэхгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байх эрсдэлтэй.								
4	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд байгуулсан үндсэн гэрээнд тусгагдаагүй сургалтын зардал, онгоцны тийз, гадаадад байрлах зардлыг бэлтгэн нийлүүлэгч компаниар даалгаж, үйлдвэрийн газрын ажилчдыг гадаадад томилолтоор ажиллуулсан байна. Тухайлбал, 1.Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий захирлын 2025 оны А/70 дугаар тушаалаар тайлант оны 3 дугаар сард Австрали улсын Перт хотод сургалтад хамрагдах үйлдвэрийн газрын 8 ажилтны гадаад томилолтын зардлыг Майнтек технологи ХХК-иар даалгаж, Майнтек технологи ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд байгуулсан "Ил уурхайн программ хангамжийн лиценз" нийлүүлэх 2024/09-10-0369 тоот үндсэн гэрээнд 2025 оны 4 дүгээр сард нөхөн нэмэлт өөрчлөлт оруулсан; 2.Ай эм трейдинг ХХК Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай 2024 онд байгуулсан "Бутлан тээвэрлэх хэсгийн туузан дамжуулгын хөтлүүр" нийлүүлэх 2024/02-11-0684 тоот үндсэн гэрээнд тусгагдаагүй үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах, уулзалт хийх зардлыг бэлтгэн нийлүүлэгч талаар даалгаж, ерөнхий захирлын 2025 оны А/329 дүгээр тушаалаар үйлдвэрийн газрын 2 ажилтныг БНХАУ-ын Тяньжинь хотод гадаад томилолтоор ажиллуулсан байна.	1	-			1	-		
5	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 4.2.6-д "Цалин хөлс, урамшууллын системийг боловсронгуй болгох, цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх, цалин хөлсийг сард 2 удаа буюу сар бүрийн 05, 15-ны өдрүүдэд олгох"-оор тусгасан боловч дээрх өдрүүдээс гадна долоо хоног бүрийн 2, 4 дэх өдөр бүр 7 банкны дансаар цалингийн гүйлгээ хийж байгаа нь цалингийн тооцоолол, цалин олголтод тавих хяналтыг сулруулж байна.	1	-					1	
	МУЗГ-ын 2022 оны 171 дугаар тогтоолоор Уул уурхай- металлурги- химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт байрлах "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын эзэмшилд бүртгэлтэй 117,269.8 сая төгрөгийн анхны өртөгтэй, 4,690,790 кв талбайн хэмжээтэй, 6102101619 нэгж талбарын дугаартай газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай тогтоол гарсан боловч 2025 оны жилийн эцсийн тайлангаар тус газар нь байгууллагын данс бүртгэлд бүртгэлтэй хэвээр байна.	1	117,269.8					1	117,269.8
	Дүн	6	547,902.4	-	-	4	430,632.6	2	117,269.8
	Нийт дүн	7	547,902.4	-	-	4	430,632.6	3	117,269.8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 196/АД160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Монгол Улсын Шадар сайдын 2024 оны "Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" 10 дугаар тушаалаар хүчингүй болсон Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 22 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-г үндэслэн Ерөнхий захирлын "Ажилтнуудыг урамшуулах тухай" 2025 оны Б/85, А/751 дүгээр тушаалуудаар 912 ажилтанд 18,240,000.00 /Арван найман сая хоёр зуун дөчин мянган/ төгрөгийн урамшууллыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Монгол Улсын Шадар сайдын 2024 оны "Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" 10 дугаар тушаалын 4-р хавсралт "Баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн," гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилтнуудад олгосон урамшууллыг хүчингүй болсон тушаалаар тооцож, илүү олгосон, тушаалын төсөлд хяналт тавьж ажиллаагүй 18,240,000.00 /Арван найман сая хоёр зуун дөчин мянган/ төгрөгийг олгосон буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц. Наранчимэг
П. Чанцалдулам
Ж. Нямцэцэг
Т. Баасанцэнд

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 982/АД160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд шинж чанарын хувьд материаллаг нөлөөтэй, хэрэглэгчдийн санхүүгийн тайлангийн талаарх ойлголтод ач холбогдолтой, хууль, хяналтын байгууллага шилжүүлсэн Үндэсний хөрөнгө оруулалтын банктэй холбоотой 42,358,713,714.12 /Дөчин хоёр тэрбум гурван зуун тавин найман сая долоон зуун арван гурван мянга долоон зуун арван дөрвөн төгрөг арван хоёр мөнгө/ төгрөгийн бусад авлага, Стандарт банктэй холбоотой 107,264,369,523.17 /Нэг зуун долоон тэрбум хоёр зуун жаран дөрвөн сая гурван зуун жаран есөн мянга таван зуун хорин гурван төгрөг арван долоон мөнгө/ төгрөгийн урт хугацаат авлагыг санхүүгийн тайланд дэлгэрэнгүй тодруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", СТОУС-7 Санхүүгийн хэрэглүүр-Тодруулга 31-д "Санхүүгийн хэрэглүүрээс үүсэн бөгөөд тухайн тайлант үеийн эцэст аж ахуйн нэгжид учрах эрсдэлийн шинж төрөл ба хэмээг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн олгох мэдээллийг уг аж ахуйн нэгж нь тодруулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой, стандартаар заагдсан мэдээллийг тайланд тодруулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-364230

9006109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-76.Docx

1526181745



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 983/А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2025 оны 94, 135 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын А/138 дугаар тушаалаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын ажлуудыг царцаах, үйл ажиллагааны зардлыг бууруулах замаар нэгдлийн компаниудад улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлого, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх үүрэг даалгавар, чиглэл ирсний дагуу үйлдвэрийн захирлын зөвлөлийн хурлын 2025/04 дүгээр шийдвэрээр сүүлийн хагас жилийн бизнес төлөвлөгөөнд улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг нэмэгдүүлэх, зарим хөрөнгө оруулалтын ажлыг бууруулан төлөвлөж дээд газарт хүргүүлсэн байна.

Гүйцэтгэлээр жилийн эцэст 2026 оны 1 дүгээр сарын экспортын орлого буюу 235,748,186,399.31 /Хоёр зуун гучин таван тэрбум долоон зуун дөчин найман сая нэг зуун наян зургаан мянга гурван зуун ерэн есөн төгрөг гучин нэгэн мөнгө/ төгрөгийг харилцагч 6 аж ахуйн нэгжээс урьдчилан авч улсын төсвийн татварын урьдчилгаанд 177,385,004,919.94 /Нэг зуун далан долоо тэрбум гурван зуун наян таван сая дөрвөн мянган есөн зуун арван есөн төгрөг ерэн дөрвөн мөнгө/ төгрөг, Эрдэнэс Монголын менежментийн төлбөрт 20,000,000,000.00 /Хорин тэрбум/ төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд 5,000,000,000.0 /Таван тэрбум/ төгрөг, Засгийн газрын 127 дугаар тогтоолоор Сангийн яаманд 754,245,462.00 /Долоон зуун тавин дөрвөн сая хоёр зуун дөчин таван мянга дөрвөн зуун жаран хоёр/ төгрөгийн санхүүжилт олгосон бол Хаан банкнаас оны эцэст 141,943,600,000.00 /Нэг зуун дөчин нэгэн тэрбум есөн зуун дөчин гурван сая зургаан зуун мянган/ төгрөгийн /40.0 мянган ам.доллар/ 8.88 хувийн хүүтэй зээл авч үндсэн үйл ажиллагааны зардлыг төлж /25.0 мянган ам.долларыг 12 дугаар сарын 30, 31-нд буцааж төлсөн/, мөн тодотголоор тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсвийг 58,535,164,810.76 /Тавин найман тэрбум таван зуун гучин таван сая нэг зуун жаран дөрвөн мянга найман зуун арван төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгөөр бууруулан, зарим хөрөнгө оруулалтын ажлуудыг хойшлуулсан нь ирээдүйд үйлдвэрийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, санхүүгийн сахилга бат алдагдах, хүүгийн дарамтад орох, санхүүгийн чадавхийг бууруулах, дараа дараагийн шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах боломжийг бууруулах эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т "Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0316\SAГ-76.Docx

1526181752

харилцааг зохицуулахад оршино.", 6 дугаар зүйлийн 6.4.6-д "хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх", 23 дугаар зүйлийн 23.3-т "Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 3 дугаар зүйлд "Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно." 6 дугаар зүйл. "Төрийн өмчид эд хөрөнгө олж авах" 2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйлдвэрийн газрын ирээдүйд орох орлогыг барьцаалж харилцагч байгууллагуудаас урьдчилан санхүүжилт татаж, улсын төсвийн хөрөнгийн дутагдлыг нөхсөн зөрчлийг таслан зогсоож, Төрийн өмчит үйлдвэрийн газарт санхүүгийн дарамт үүсгэж, зээл, зээлийн хүүгийн зардал төлүүлж, компанийн ашигт ажиллагааг бууруулахгүйгээр удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга (Ц.Одхүү)-д нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

В. Р.
М. Нямцэцэг

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ

9006109
ATA16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 984/А0160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр, бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхээр нийт 10687 ажилтанд 8,433,268,893.00 /Найман тэрбум дөрвөн зуун гучин гурван сая хоёр зуун жаран найман мянга найман зуун ерэн гурван/ төгрөгийн урамшуулал олгосон байна. Үүнд:

- Ерөнхий захирлын 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/797 тоот тушаалаар үйлдвэрийн газрын хамт олонд 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөөг 106 хувиар биелүүлж, цэвэр ашгийн төлөвлөгөөг 123 хувиар давуулан биелүүлснийг үндэслэн Монгол Улсад уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 103 жилийн ой, уурхайчдын баярын өдрийг тохиолдуулан үйлдвэрийн газрын ажилтан, үйлдвэрчний эвлэлийн гишүүд, тэтгэвэр тогтоолгосон ахмад, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан 10483 ажилчдад 8,076,900,000.00 /Найман тэрбум далан зургаан сая есөн зуун мянган/ төгрөг;
- "Урамшуулал олгох тухай" Б/1255, 1308, 1922, 2165, 2194, 2206, 2216, 2243, 2256, 2257, 2270 тоот тушаалуудаар салбарын болон зарим ажил мэргэжлийн, ажилчдын өдрийг тэмдэглэхээр 204 ажилтанд олгосон урамшуулалд 166,300,000.00 /Нэг зуун жаран зургаан сая гурван зуун мянган/ төгрөг;
- Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан ажилчдад үр дүнгийн урамшууллаас гадна Б/2208 тушаалаар байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх байгууллагын комиссын бүрэлдэхүүн болох 53 ажилтанд 75,500,000.00 /Далан таван сая таван зуун мянган/ төгрөг, А/736 тушаалаар ногоон хөгжлийн төслийн нэгжийн ажилчдыг мод тарьж ургуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажилласныг урамшуулж 8 ажилтанд 8,000,000.00 /Найман сая/ төгрөг, Б/2176 тушаалаар хамтын гэрээг дүгнэх, шинээр мөрдөх хамтын гэрээг байгуулах ажлын хэсгийн 13 ажилтанд 106,568,893.00 /Нэг зуун зургаан сая таван зуун жаран найман мянга найман зуун ерэн гурван/ төгрөг, нийт 190,068,893.00 /Нэг зуун ерэн сая жаран найман мянга найман зуун ерэн гурван/ төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно.", Төрийн

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shoardlaga\2026\0316 SA(G)-76.Docx

1526181739

хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын цалин хөлсний талаар баримтлах бодлого" А/1147 тоот тушаалын 2-р хавсралт "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын цалин хөлсний тухай журам"-ын 4. Урамшуулал. 4.1. Үйлдвэрийн газрын болон тухайн бүтцийн нэгжийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамт олон, ажилтны оруулж буй хувь нэмэр, ажлын гүйцэтгэл, үр дүн, идэвхи зүтгэлийг бодитоор үнэлж, ажилтнуудыг идэвхижүүлэх зорилгоор сар бүрийн ажлын үр дүнгийн урамшуулал, жилийн ажлын үр дүнгийн урамшуулал олгоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, ажилчдад үр дүнгийн урамшууллаас гадна нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр, бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 985/АД160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Бизнес төлөвлөгөөнд үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар тэргүүлэх чиглэлд тусгасан боловч урлаг, спорт, баярын арга хэмжээний зардлын төсвийн 94.8 хувь буюу 3,326,228,958.04 /Гурван тэрбум гурван зуун хорин зургаан сая хоёр зуун хорин найман мянга есөн зуун тавин найман төгрөг дөрвөн мөнгө/ төгрөгийн гүйлгээг "батлагдсан төсвийн дагуу, төсөв" гэсэн утгатай хувь хүний данс руу 663 гүйлгээ гарсан байгаа нь төсвийн зарцуулалтын ил тод байдал, мөнгөн хөрөнгийн зарцуулалтын удирдлагын хяналт алдагдах эрсдэлтэй байна. Тухайлбал тус зардлаас спортын арга хэмжээнд 548,782,800.00 /Таван зуун дөчин найман сая долоон зуун наян хоёр мянга найман зуун/ төгрөг, олон нийтээр тэмдэглэлт өдрүүдийн зардалд 1,029,451,560.84 /Нэг тэрбум хорин есөн сая дөрвөн зуун тавин нэгэн мянга таван зуун жаран төгрөг наян дөрвөн мөнгө/ төгрөг, байгууллагын уралдаан тэмцээний зардалд 242,445,887.20 /Хоёр зуун дөчин хоёр сая дөрвөн зуун дөчин таван мянган найман зуун наян долоон төгрөг хорин мөнгө/ төгрөг, мэргэжлийн баяр, цехүүдийн арга хэмжээнд 209,548,710.00 /Хоёр зуун есөн сая таван зуун дөчин найман мянга долоон зуун арван/ төгрөгийг тус тус зарцуулж, байгууллагын албан хаагчдын дансаар дамжуулан гүйлгээ хийж байгаа нь худалдан авалтын төлөвлөгөөнөөс гадуурх гэрээ хэлцэлгүй, хяналтгүй, шууд худалдан авалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-т "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-76.Docx

1526181715

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 -т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урлаг, спорт, соёлын арга хэмжээтэй холбоотой худалдан авах ажиллагааг харилцагч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлээгүй, хувь хүний дансаар дамжуулан зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, гүйлгээний мэдээллийг ойлгомжтой, ил тод бүртгэж байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 986/А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аж ахуйн нэгжээс гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа материалын нийлүүлэлтийг хугацаа хоцроож нийлүүлсэн боловч гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй, гэрээг цуцлаагүй, нийт дүнгээр санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Erlan Jin Tai Co., Ltd-тай 1000 тонн хүхэрт натрис 2,501,050,999.97 /Хоёр тэрбум таван зуун нэг сая тавин мянга есөн ерэн есөн мянга ерэн төгрөг ерэн долоон мөнгө/ төгрөгөөр худалдаж авахаар 2024.08.14-ний дотор нийлүүлж дуусах гэрээ байгуулсан боловч гүйцэтгэлээр 2024.08.30-2025.05.09-ны хооронд хугацаа хоцроож нийлүүлсэн хоног тутамд гэрээнд заасны дагуу 0.1 хувийн буюу 250,105,100.00 /Хоёр зуун тавин сая нэг зуун тавин мянга нэг зуун/ төгрөгийн алданги тооцоогүй;
- Сархиа бүрд ХХК "Фанер, модон материал" 2023 онд худалдан авахаар 788,396,000.00 /Долоон зуун наян найман сая гурван зуун ерэн зургаан мянган/ төгрөгийн гэрээ байгуулж, 2024.09.17-ны өдөр нийлүүлэх хуваарьтай байсан боловч 2025.01.31-нд нийлүүлсэн гэрээнд заасны дагуу хоног тутамд 0.1 хувийн буюу 78,839,600.00 /Далан найман сая найман зуун гучин есөн мянга зургаан зуун/ төгрөгийн алданги тооцоогүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-76.Docx

1526181725

1. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заагдаагүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй аливаа хэлцлийг гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулалгүйгээр шийдвэрлэсэн, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаагүй хугацааны алдангийг тооцож суутгаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 987/АД160075

Улаанбаатар хот

САГ - 2026 /101/ИА -СТА -ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн сайдын 2024 оны "Дотоод албан томилолтын зардлыг хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаалыг мөрдөлгүй, алба, хэлтсийн дарга, ерөнхий инженер зэрэг удирдах түвшний албан хаагчдад 160.0-250.0 мянган төгрөгийн зочид буудлын төлбөр олгосноос дотоод албан томилолтын зардлын нормыг нийт 156,480,000.00 /Нэг зуун тавин зургаан сая дөрвөн зуун наян мянган/ төгрөгөөр хэтрүүлсэн байна. Мөн томилолтын төсвийг боловсруулсан боловч холбоотой этгээдүүдийн гарын үсгээр огт баталгаажуулаагүй гүйлгээг гаргаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.9-д "улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох", 1.10-т "эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах", Сангийн сайдын 2024 оны "Дотоод албан томилолтын зардлыг хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна:", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө",

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban.Shaardlaga\2026\0316 SAG-76.Docx


1526181719

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод томилолтын төсвийг тооцож, олгохдоо эрх бүхий байгууллагын баталсан нормыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 988/А0160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын арилжааны банкны дансдуудаар орлогын 9,682,647,491,292.11 /Есөн их наяд зургаан зуун наян хоёр тэрбум зургаан зуун дөчин долоон сая дөрвөн зуун ерөн нэгэн мянга хоёр зуун ерэн хоёр төгрөг арван нэгэн мөнгө/ төгрөгийн 10371, зарлагын 9,627,560,342,853.05 /Есөн их наяд зургаан зуун хорин долоон тэрбум таван зуун жаран сая гурван зуун дөчин хоёр мянга найман зуун тавин гурван төгрөг таван мөнгө/ төгрөгийн 13442 гүйлгээ бүртгэгдсэн байна. Үүнээс харилцахын гүйлгээнээс архивын баримт руу хөөн шалгахад дансдуудыг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн хуваарилаагүйгээс нийт бэлэн мөнгөний касс 11, арилжааны 28 банкны дансаар нийгмийн цехүүдийн болон үндсэн үйл ажиллагааны орлого, зарлагын гүйлгээ гарч байгаа нь мөнгөн хөрөнгийн зүй зохистой удирдлага, хяналт алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийнх 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д "ерөнхий нягтлан бодогч" гэж нягтлан бодох бүртгэл хөтлөх, удирдан зохион байгуулах, хариуцлага хүлээхээр аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагаас томилогдсон мэргэжлийн нягтлан бодогчийг; 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Мөнгөн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, харьяа цехүүдийн мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг нэг данснаас гаргадаг болгож, үндсэн данснаас салгаж бүртгэх, дотоод хяналтыг сайжруулах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 989 /АД160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд зорилтод түвшний 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн ГЁ-131-12/4160 дугаар албан бичгээр баталсан Худалдан авах ажиллагааны тодотголд Улаанбаатар төмөр зам ХНН 2025 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 03/2797 тоот албан бичиг, Засгийн газрын тогтоолын дагуу 2 сарын вагон түрээсийн үйлчилгээнд 6,000,000,000.00 /Зургаан тэрбум/ төгрөгийг төсөвлөж, баталсан. Техникийн тодорхойлолтод зөвхөн шаардлагын буюу ОХУ-ын 12-132 загварын хагас вагон эсвэл түүнтэй дүйцэхүйц гэсэн төрлөөр 350 вагоныг үндэслэлгүйгээр 19-50 ширхэгээр хуваан 10 багцалсан, тендер шалгаруулалтын баримт бичигт ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх шаардлагыг огт оруулалгүй хасаж нийт 2 сарын хугацаанд ажиллуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нийт 9 багцын 300 вагоны түрээсийн тендерт Төмөр замын зураг, төслийн институт ХХК шалгарч 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 5/289-2025 тоот гэрээгээр 4,811,820,002.00 /Дөрвөн тэрбум найман зуун арван нэгэн сая найман зуун хорин мянга хоёр/ төгрөг, 1 багцад 50 вагон түрээслэхээр Дулаанвинг ХХХ шалгарч 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 5/019-2026 тоот гэрээгээр 850.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2026 оноос үйлчилгээнд явж эхлэхээр байгаа нь тодотголоор 2025 онд зайлшгүй шаардлагатай бус төсвийг баталсан, мөн тус үйлдвэрт эрх бүхий албан тушаал эрхэлж байсан хүний компани тус тендерийн 9 багцад шалгарсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", 10 дугаар зүйлийн 10.5-т "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно.", 52 дугаар зүйлийн 52.1-д "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх үүргийг хүлээнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”, 4.2.1.11 -т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын эрсдэлийг удирдах, ерөнхий нөхцөл магадлагаас зайлсхийж тендерийн шаардлагыг бууруулсан, тендерт өрсөлдөж байгаа аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгч, хамаарал бүхий этгээдийг тогтоож, ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөвөөр мэдүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 990/АД160075

Улаанбаатар хот

САГ -2026/101/КА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн 96 дугаар тогтоолоор Оросын Холбооны Улсын Москва хот дахь худалдааны төлөөлөгчийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хот дахь төлөөлөгчийн газруудын санхүүжилтийг 2025 оны эхний хагас жилд олгохоор баталсан, Ерөнхий захирлын 2025 оны 69 дүгээр тушаалаар тус газруудыг татан буулгасан боловч Эрдэнэс Монгол ХХК-д харьяалалд шилжсэн бөгөөд албан бичгийн дагуу 70,723,758.64 /Далан сая долоон зуун хорин гурван мянга долоон зуун тавин найман төгрөг жаран дөрвөн мөнгө/ төгрөгийн санхүүжилт олгож, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татан буугдаж, Эрдэнэс монгол ХХК-ийн харьяанд шилжсэн байнгын төлөөлөгчийн газруудад санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 9-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

7006109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0316_SAG-76.Docx

1526181727



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 991/А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:




Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх Хамтын гэрээнд үйлдвэрийн газарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмадуудад ахмадын өдөр, Монголын цагаан сараар нэг удаа тэтгэмж олгохоор тусгасан. Ерөнхий захирлын Б/508, Б/514 тушаалуудаар сар шинийн баярыг тохиолдуулан нийт 464 ахмадад тэтгэмж олгосон боловч үүнээс 13 ахмадад нийт 46,510,000.00 /Дөчин зургаан сая таван зуун арван мянган/ төгрөгийн тэтгэмжийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна: 3.1.3-т "банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын захиргаа болон үйлдвэрчний эвлэлийн хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх Хамтын гэрээний 7.16-д "Үйлдвэрийн газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмадад Ахмадын өдөр, Монголын цагаан сараар тус тус нэг удаа батлагдсан журмын дагуу тэтгэмжийг олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хамтын гэрээний заалтыг зөрчиж, тэтгэмж давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		П.ЧАНЦАЛДУЛАМ
АХЛАХ АУДИТОР		Ж.НЯМЦЭЦЭГ
АУДИТОР		Т.БААСАНЦЭНД

9006109
ATA16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 992/А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ерөнхий захирлын 2025 оны "2024 оны жилийн үр дүнгийн урамшуулал олгох тухай" Б/473 тоот тушаалаар үйлдвэрийн газрын бүтцийн нэгжүүдийн 2024 оны жилийн ажлын үр дүнг үнэлж урамшуулал олгосон ч 2025 оны Бизнес төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдаагүй хагас жилийн үр дүнгийн урамшуулалд нийт 10,702,300,000.00 /Арван тэрбум долоон зуун хоёр сая гурван зуун мянган/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын цалин хөлсний талээр баримтлах бодлого" А/1147 тоот тушаалын 2-р хавсралт "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын цалин хөлсний тухай журам"-ын 4. Урамшуулал. 4.1. Үйлдвэрийн газрын болон тухайн бүтцийн нэгжийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамт олон, ажилтны оруулж буй хувь нэмэр, ажлын гүйцэтгэл, үр дүн, идэвхи зүтгэлийг бодитоор үнэлж, ажилтнуудыг идэвхижүүлэх зорилгоор сар бүрийн ажлын үр дүнгийн урамшуулал, жилийн ажлын үр дүнгийн урамшуулал олгоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бизнес төлөвлөгөөнд тусгаж, батлуулаагүй аливаа зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

5005109
ATA16037
9325081411

Z:\Alban Shaaardlaga\2026\0316_SAG-76.Docx

1526181737



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 99 З/АД160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СГА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, дараах шаардлагагүй арга хэмжээг санхүүжүүлж нийт 3,689,133,360.05 /Гурван тэрбум зургаан зуун наян есөн сая нэг зуун гучин гурван мянга гурван зуун жаран төгрөг таван мөнгө/ төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна. Үүнд:

- Фитнессийн тоног төхөөрөмж худалдан авахад Их танил ХХК-аас 261,269,000.00 /Хоёр зуун жаран нэгэн сая хоёр зуун жаран есөн мянган/ төгрөг;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын батлагдсан төсвөөс ажилтнуудын эрүүл мэнд асаргаа сувилгааны хөнгөлөлтөд 2,898,038,918.00 /Хоёр тэрбум найман зуун ерэн найман сая гучин найман мянга есөн зуун арван найман/ төгрөг, хамтын гэрээгээр олгож буй сургалтын зардалд 53,068,722.00 /Тавин гурван сая жаран найман мянга долоон зуун хорин хоёр/ төгрөг, ажил мэргэжлийн уралдааны зардалд 1,372,878.00 /Нэг сая гурван зуун далан хоёр мянга найман зуун далан найман/ төгрөг, нийт хэтрүүлэн зарцуулсан 2,952,480,518.00 /Хоёр тэрбум есөн зуун тавин хоёр сая дөрвөн зуун наян мянга таван зуун арван найман/ төгрөг;
- Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар нь өөрийн байртай боловч барилгын зураг төсөв боловсруулах ажил гүйцэтгүүлэхэд 242,700,000.00 /Хоёр зуун дөчин хоёр сая долоон зуун мянган/ төгрөг;
- “Уурхайчдын спортын их наадам-2025” тэмцээнийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Монголын Уул уурхайн Үндэсний ассоциатай хамтран Би саунд продакшн ХХК-д 60,000,000.00 /Жаран сая/ төгрөг, тамирчдын хувцас худалдан авахад 22,108,000.00 /Хорин хоёр сая нэг зуун найман мянган/ төгрөг, нийт 82,108,000.00 /Наян хоёр сая нэг зуун найман мянган/ төгрөг;
- Дарьганга гоёл ХХК-аас бэлэг дурсгалын зүйл авахад 75,730,192.05 /Далан таван сая долоон зуун гучин мянга нэг зуун ерэн хоёр төгрөг таван мөнгө/ төгрөг;
- Нью жуулчин турс ХХК-аас аялалын багцад шилжүүлсэн 72,010,000.00 /Далан хоёр сая арван мянган/ төгрөг;
- Үйлдвэрийн бүтцэд 21 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй хуулийн хэлтэстэй боловч Өмгөөллийн онч нүүдэл ХХК-аас өмгөөллийн үйлчилгээнд 72,000,000.00 /Далан хоёр сая/ төгрөг;
- Наурызын баярын арга хэмжээнд 20,396,000.00 /Хорин сая гурван зуун ерэн зургаан мянган/ төгрөг;

- Улсын бүртгэл дээрх үйл ажиллагааны чиглэл таарахгүй Дүдү зоне ХХК-аас сургалтын зардал гэж 16,999,050.00 /Арван зургаан сая есөн зуун ерэн есөн мянга тавин/ төгрөг;
- Зочин төлөөлөгч хүлээн авах, хурлын танхим цэцэгжүүлэхэд 14,210,600.00 /Арван дөрвөн сая хоёр зуун арван мянга зургаан зуун/ төгрөг;
- Харбин 2025 Азийн өвлийн наадам үзэхэд 1 албан хаагчид олгосон 5,594,000.00 /Таван сая таван зуун ерэн дөрвөн мянган/ төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна:", 3.1.3-т "банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан," 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 4.2.9-т "энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох," 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулаагүй, хуулиар хязгаарласан үйл ажиллагаанд үр ашиггүй зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. Р. В.*
 АУДИТЫН МЕНЕЖЕР *М. Н. Н.*
 АХЛАХ АУДИТОР *Т. А. А.*
 АУДИТОР *М. М.*
 АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
 П.ЧАНЦАЛДУЛАМ
 Ж.НЯМЦЭЦЭГ
 Т.БААСАНЦЭНД
 Г.ТЭЛМҮҮН
 Б.ТЭГШСҮРЭН

9006109
 АТА16087
 9025081411

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-76.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 994/АД160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2020 онд Хятадын Засгийн газарт зориулж 277,961,773.00 /Хоёр зуун далан долоон сая есөн зуун жаран нэгэн мянга долоон зуун далан гурван/ төгрөг, Оросын Холбооны Улсад 128,170,414.00 /Нэг зуун хорин найман сая нэг зуун далан мянга дөрвөн зуун арван дөрвөн/ төгрөгийн "Ковид-19"-ийн хандив, 2024 онд Малчдад 142,739,837.00 /Нэг зуун дөчин хоёр сая долоон зуун гучин есөн мянга найман зуун гучин долоон/ төгрөгийн хандив цуглуулах зорилгоор үйлдвэрийн ажилчдын цалингаас 30.0-50.0 мянган төгрөгийг суутган авч Хятадын засгийн газарт 288,000,888.00/Хоёр зуун наян найман сая найман зуун наян найман/ төгрөг, Оросын Холбооны Улс хандив авахаас татгалзсан тул цуглуулсан хандиваас 80,000,000.00 /наян сая/ төгрөгийг Орхон, Булган аймгийн Онцгой байдлын ерөнхий газрууд руу тус тус шилжүүлсэн боловч, нийт суутган авсан хандивыг бүрэн шилжүүлэлгүйгээр тайлант оны эцэст цалингаас суутгасан бусад өглөг дансны үлдэгдэлд 180,871,136.00 /Нэг зуун наян сая найман зуун далан нэгэн мянга нэг зуун гучин зургаан/ төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно", 119.1.1-д "ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг ажилтнаар нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан", 119.1.2-т "шүүхийн, эсхүл хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсон", 119.1.3-т "ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан", 119.1.4-т "хууль тогтоомжид заасан бусад тохиолдол", Төсвийн тухай хуулийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3-т "Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 -т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуульд зааснаас өөрөөр ажилтнуудын цалингаас хандивын мөнгө суутган авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 995/А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд байгуулсан үндсэн гэрээнд тусгагдаагүй сургалтын зардал, онгоцны тийз, гадаадад байрлах зардлыг бэлтгэн нийлүүлэгч компаниар даалгаж, үйлдвэрийн газрын ажилчдыг гадаадад томилолтоор ажиллуулсан байна. Тухайлбал:

- Ерөнхий захирлын 2025 оны А/70 дугаар тушаалаар 3 дугаар сард Австрали улсын Перт хотод сургалтад хамрагдах үйлдвэрийн газрын 8 ажилтны гадаад томилолтын зардлыг Майнтек технологи ХХК-иар даалгаж, Майнтек технологи ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд байгуулсан "Ил уурхайн программ хангамжийн лиценз" нийлүүлэх 2024/09-10-0369 тоот үндсэн гэрээнд 2025 оны 4 дүгээр сард нөхөн нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Ерөнхий захирлын 2025 оны А/329 дүгээр тушаалаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжинь хотод үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай танилцах, уулзалтад оролцуулахаар 2 ажилтны гадаад томилолтын зардлыг Ай эм трейдинг ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд байгуулсан "Бутлан тээвэрлэх хэсгийн туузан дамжуулгын хөтлүүр" нийлүүлэх 2024/02-11-0684 тоот үндсэн гэрээнд тусгагдаагүй байхад бэлтгэн нийлүүлэгч талаар даалгаж, ажиллуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно" 40.2.1-т "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах", Иргэний хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хууль буюу гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-76.Docx

1526181754

1. Үндсэн гэрээнд тусгагдаагүй зардлыг бэлтгэн нийлүүлэгч компаниар даалгасан зөрчлийг таслан зогсоож, харилцагч байгууллагатай байгуулсан гэрээнд худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт тусгагдаагүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй нөхцөлөөр нэмэлт өөрчлөлт оруулахгүй байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 996/АД160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй дараах зөрчлүүдийг давтан гаргаж, нийт 86,580,000.00 /Наян зургаан сая таван зуун наян мянган/ төгрөгийн урамшуулал олгосон байна. Үүнд:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны Бизнес төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдаагүй хагас жилийн үр дүнгийн урамшууллыг ерөнхий захирлын 2025 оны "Үйлдвэрийн газрын 2025 оны эхний хагас жилийн ажлын үр дүнгээр ажилтнуудыг урамшуулах тухай" Б/1624 дүгээр тушаалаар үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй Эрдэнэт медиал ХХК-ийн албан хаагчдад олгосон 81,300,000.00 /Наян нэгэн сая гурван зуун мянган/ төгрөг,
- Эрдэнэт хотын бүтээн байгуулалтад оролцож байсан Монгол ажилчдын нэгдсэн захиргааны барилгачдын эрх ашгийг хамгаалах "Баатар" холбооны гишүүд болон Эрдэнэт үйлдвэрийн орон сууцны удирдах газарт ажиллаж байсан анхдагчдад олгосон 5,280,000.00 /Таван сая хоёр зуун наян мянган/ төгрөг.


Энэ нь Төсвийн тухай хуулийн-25 дугаар зүйлийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл "Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг:", 3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах:", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй арга хэмжээнд дэмжлэг, хандив, тусламжийн шинжтэй зардлыг санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 997/А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй хүргэх ажлыг гүйцэтгүүлэхээр Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй 200,000,000.00 /Хоёр зуун сая/ төгрөгийн гэрээ байгуулан тайлант онд 100,000,000.00 /Нэг зуун сая/ төгрөг, хэвлэл мэдээлэл, сонин, сайтын үйл ажиллагаа эрхэлдэг 20 байгууллагад 183,050,000.00 /Нэг зуун наян гурван сая тавин мянган/ төгрөг, үйл ажиллагааны чиглэл өөр 4 байгууллагад 79,600,000.00 /Далан есөн сая зургаан зуун мянган/ төгрөг, нийт 362,650,000.00 /Гурван зуун жаран хоёр сая зургаан зуун тавин мянган/ төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.


Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлсэн, нотлох баримтын шаардлага хангаагүй, үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудад санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0316\SAG-76.Docx

1526181741



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 998/АД160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс монгол ХХК-ийн 2024 оны А/95 тушаалаар баталгаажуулсан Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшинд аймгийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчийн Хуралтай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд олгох нийт 30,523,653,035.00 /Гучин тэрбум таван зуун хорин гурван сая зургаан зуун тавин гурван мянга гучин таван/ төгрөгийн хандив, дэмжлэгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны зардалд төлөвлөж, бизнес төлөвлөгөөнд тусгасан нь үйлдвэрийн ашигт ажиллагааг бууруулахад нөлөөлж байна. Үүнд:

- Орхон аймгийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан 5/152-24 дүгээр хамтран ажиллах гэрээний дагуу Эрдэнэт хот доторх зам засварын ажлын гүйцэтгэлд 26,229,506,887.00 /Хорин зургаан тэрбум хоёр зуун хорин есөн сая таван зуун зургаан мянга найман зуун наян долоон/ төгрөг, 2025 оны хамтран ажиллах 5/159-25 дугаар гэрээний дагуу 2,768,820,376.00 /Хоёр тэрбум долоон зуун жаран найман сая найман зуун хорин мянга гурван зуун далан зургаан/ төгрөг, нийт 28,998,327,263.00 /Хорин найман тэрбум есөн зуун ерэн найман сая гурван зуун хорин долоон мянга хоёр зуун жаран гурван/ төгрөг;
- Булган аймгийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан 5/068-25 дугаар хамтран ажиллах гэрээний дагуу олгосон 1,021,063,105.00 /Нэг тэрбум хорин нэгэн сая жаран гурван мянга нэг зуун таван/ төгрөг;
- Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчийн хуралтай байгуулсан 5/098-24 дүгээр хамтран ажиллах гэрээний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд санхүүжүүлсэн 304,262,667.00 /Гурван зуун дөрвөн сая хоёр зуун жаран хоёр мянга зургаан зуун жаран долоо/ төгрөг;
- Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан 5/105-25 дугаар хамтран ажиллах гэрээний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд санхүүжүүлсэн 200,000,000.00 /Хоёр зуун сая/ төгрөг тус тус байна.


Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлд "Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.", Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-т "Төрийн болон орон

нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ашигт малтмалын тухай хуулиар хүлээн үүргийн хүрээнд хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгахдаа Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчийн хуралтай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд олгох хандив, дэмжлэгийг өөрийн байгууллагын төсөвт төсөвлөж батлуулсан зөрчлийг арилгаж, ногдол ашгийн нэгэн адилаар цэвэр ашгаас хуваарилдаг байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 999/А0160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/ИА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа шалгаруулж байгаа аж ахуйн нэгжийн санхүүгийн чадавхийг үнэлж байгаа боловч гэрээг байгуулахдаа 30 хүртэлх хувийн урьдчилгаа олгодог, мөн тендерт ажлыг хугацаандаа хэрэгжүүлэхээр шаардлага хангаж шалгарсан компаниуд ажлаа хугацаандаа хэрэгжүүлдэггүй байдлуудаас валютын ханшийн эрсдэл, үнийн өсөлтөөс шалтгаалсан зардал нэмэгдэх, урьдчилгаа төлбөрийн гүйцэтгэл хангагдахгүй байх, тайлант оны төсөвт ачаалал үүсгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. 2025 оны гэрээгээр гүйцэтгэсэн ажлуудыг түүвэрлэн шалгахад 78,153,754,104.00 /Далан найман тэрбум нэг зуун тавин гурван сая долоон зуун тавин дөрвөн мянга нэг зуун дөрвөн/ төгрөгийн 14 гэрээнд урьдчилгаа төлбөрийг 30 хүртэл хувиар олгохоор тооцсон, гүйцэтгэлээр 3 гэрээний урьдчилгаа төлбөрт нийт 10,858,069,952.80 /Арван тэрбум найман зуун тавин найман сая жаран есөн мянган есөн зуун тавин хоёр төгрөг наян мөнгө/ төгрөг олгосон, 3 гэрээний хугацааг сунгасан, 1 гэрээний төсөвт өртгийг нэмэгдүүлж гэрээ байгуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 20 дугаар зүйлийн 1.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", 67 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0316\SAG-76.Docx


1526181720

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”, 4.2.1.11 -т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгө оруулалтын ажилд урьдчилгаа олгосон зөрчлийг таслан зогсоож, урьд жилүүдэд үүссэн эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгож байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1000 /А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026 /101/ИА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар, угсралтын ажил" гүйцэтгүүлэхээр Засагт алтай ХХК-тай Нунтаглан баяжуулах хэсэгт 261,289,800.00 /Хоёр зуун жаран нэгэн сая хоёр зуун наян есөн мянган найман зуун/ төгрөг, Техмонтаж ХХК-тай Бутлан тээвэрлэх хэсэгт 255,840,000.00 /Хоёр зуун тавин таван сая найман зуун дөчин мянган/ төгрөгийн дүнгээр гэрээ байгуулсан бөгөөд гэрээний 3.2 дахь заалтад 2026-2027 онд үргэлжлүүлэн жил бүр гэрээний үнийн дүнтэй тэнцүү хэмжээний мөнгөн дүнг төлөхөөр баталгаажуулсан байгаа нь тендер зарлахдаа оролцогчдод үнийг дутуу мэдээлсэн, дараагийн 2 жилд дээрх аж ахуйн нэгжүүдээс сонгон шалгаруулалтгүйгээр ажил гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн дээрх нөхцөлтэй ижил заалтыг гэрээнд тусгасан Авралын эрэлд ХХК Буга сэлгэн нутагшуулах ажилд 51,964,000.00 /Тавин нэгэн сая есөн зуун жаран дөрвөн мянган/ төгрөгийн 3 жилийн хугацаатай гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно." гэж заасантай нийцэхгүй байна." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа оролцогчдыг тэгш өрсөлдөх боломжоор хангаагүй, тендер шалгаруулалтын баримт бичигт нийт төсөвт өртөг, гэрээний хугацааг зөрүүтэй тусгасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1001/АД160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд гэрээт байгууллагуудтай холбоотой 802,480,900.00 /Найман зуун хоёр сая дөрвөн зуун наян мянга есөн зуун/ төгрөгийн зөрчил илэрсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй. Үүнд:

- Гэрээт цагдаа, дотоодын цэргийн өндөр насны тэтгэвэрт гарахад олгох 776,411,900.00 /Долоон зуун далан зургаан сая дөрвөн зуун арван нэгэн мянга есөн зуун/ төгрөгийн тэтгэмжийн санхүүжилтийг Орхон аймаг дахь Цагдаагийн газар, Дотоодын цэргийн 816 дугаар ангийн дансанд төвлөрүүлэлгүй, хаан банкны дундын депозит дансанд шилжүүлсэн;
- Гэрээт цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдын томилолтын зардалд 7,569,000.00 /Долоон сая таван зуун жаран есөн мянган/ төгрөг, Дотоодын цэргийн марш тактикийн тэмцээний төсөвт 18,500,000.00 /Арван найман сая таван зуун мянган/ төгрөгийг тус тус олгосон.


Энэ нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоох, олгох байгууллага", "Цэргийн алба хаагчийн тэтгэврийг тогтоох, олгох ажлыг тухайн тэтгэвэр авагчийн алба хааж байсан зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага буюу тэдгээрээс гэрээ байгуулсан этгээд эрхлэн гүйцэтгэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагатай байгуулсан гэрээг үндэслэн өндөр насны тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн тэтгэмжийг байгууллагын дансанд шилжүүлэхгүй, хувь хүний дансанд шилжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, цагдаа, дотоодын цэргийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу олгох санхүүжилтийг тус байгууллагууд улсын төсөвт суулгаагүй, давхардаагүй талаар баримтжуулж ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1002/АД160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Эрдэнэс Монгол ХХК-тай менежментийн гэрээ байгуулж менежментийн үйлчилгээний төлбөрт 20,000,000,000.00 /Хорин тэрбум/ төгрөг төлсөн боловч дээд газрын шийдвэрээр бизнес төлөвлөгөөнд тусгуулах замаар нэгдлийн харьяа охин компаниудын алдагдлыг нөхөх, хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 13,575,206,589.16 /Арван гурван тэрбум таван зуун далан таван сая хоёр зуун зургаан мянга таван зуун наян есөн төгрөг арван зургаан мөнгө/ төгрөгийг санхүүжүүлсэн байгаа нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, эдийн засгийг өрсөлдөөний зарчмаар ажиллах нөхцөлийг бууруулж байна. Үүнд:

- Цемент шохой ХХК-тай 2024 оны 12 дугаар сард "Технологийн шохой" худалдан авах 1 жилийн хугацаатай 8,867,600,000.00 /Найман тэрбум найман зуун жаран долоон сая зургаан зуун мянган/ төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд тус гэрээний 2025.02.24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр үндсэн гэрээний "барааг худалдан авагчид нийлүүлж акт үйлдсэний дараа нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ" гэж заасныг зөрчиж нийлүүлэгч компанийн үйлдвэрлэлийн хүндрэлтэй байдлыг даван туулах дэмжлэгт урьдчилан 4,000,000,000.00 /Дөрвөн тэрбум/ төгрөгийг олгохоор нэмэлт гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 2,000,000,000.00 /Хоёр тэрбум/ төгрөгийг олгосон;
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК-ээс 40 мм, 80 мм-тэй ган бөөрөнцгийн бэлдэц худалдаж авахдаа нийт 3 гэрээний гүйцэтгэлээр 27,990.7 тонныг зах зээлийн үнээс тонн тутамд 587,675.60 /Таван зуун наян долоон мянга зургаан зуун далан таван төгрөг жаран мөнгө/ төгрөгөөр илүү тооцож, 16,449,452,298.56 /Арван зургаан тэрбум дөрвөн зуун дөчин есөн сая дөрвөн зуун тавин хоёр мянга хоёр зуун ерэн найман төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгөөр, байгууллагаас ирүүлсэн үнийн саналаас тонн тутамд 337,091.78 /Гурван зуун гучин долоон мянга ерэн нэгэн төгрөг далан найман мөнгө/ төгрөгөөр илүү тооцож гүйцэтгэлээр 9,435,435,392.16 /Есөн тэрбум дөрвөн зуун гучин таван сая дөрвөн дөчин таван мянга гурван зуун ерэн хоёр төгрөг арван зургаан мөнгө/ төгрөгөөр өндөр үнээр авсан;
- Засгийн газрын 2025.03.26-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2024 оны 185 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж Зэс боловсруулах цогцолбор ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ байсныг Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани болгон өөрчлөн баталсан боловч тус компанийн ажилтны цалин хөлс, тогтмол зардалд 2,139,771,197.00 /Хоёр тэрбум нэг зуун гучин есөн сая долоон зуун далан нэгэн мянга нэг зуун ерэн долоон/ төгрөг олгосон байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-364230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-76.Docx

1526181756

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д "12.8.Энэ хуулийн 12.4, 12.6-д заасан хуулийн этгээд нь дүрэмд заасан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэхийг хориглоно.", Засгийн газрын 2025 оны "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 154 дүгээр тогтоолын 1."Бүтээн байгуулалтын төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 185 дугаар тогтоолын 1 дэх заалтын "Зэс боловсруулах цогцолбор" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг" гэсний дараа ""Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компани хэлбэрээр" гэж нэмж, мөн тогтоолын 3 дахь заалтын "дүрэм, бүтэц, орон тооны хязгаар, төсвийг баталж," гэснийг "дүрмийг баталж," гэж өөрчилсүгэй." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйлдвэрийн газрын зах зээлийн зарчмаар ажиллах боломжийг бууруулсан, бусад аж ахуйн нэгжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын эрх үүрэгт заагдаагүй аливаа зардлыг санхүүжүүлэх чиглэл өгсөн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга (Ц.Одхүү)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1003/АД160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дараа тайлангийн тооцоогоор гадаад албан томилолтын тийзийн төлбөрийг агаарын тээврийн компаниудын арилжааны банкны дансанд шилжүүлсэн боловч харилцах дансны журналаар албан хаагчийн нэр дээр бүртгэсэн байна. Үүнд: 59 албан хаагч 182,912,482.00 /Нэг зуун наян хоёр сая есөн зуун арван хоёр мянга дөрвөн зуун наян хоёр/ төгрөгийг Эйртранс ХХК-руу, 13 албан хаагчийн 36,391,840.00 Гучин зургаан сая гурван зуун ерэн нэгэн мянга найман зуун дөчин/ төгрөгийг Ай трип эйр ХХК-руу, 12 албан хаагчийн 27,703,900.00 /Хорин долоон сая долоон зуун гурван мянга есөн зуун/ төгрөгийг Нандинвэй ХХК-руу, 8 албан хаагчийн 19,031,400.00 /Арван есөн сая гучин нэгэн мянга дөрвөн зуун/ төгрөгийг Эйрлинк ХХК-руу, 2 албан хаагчийн 3,255,400.00 /Гурван сая хоёр зуун тавин таван мянга дөрвөн зуун/ төгрөгийг Аэрмаркет ХХК-руу, 1 албан хаагчийн 7,880,400.00 /Долоон сая найман зуун наян сая дөрвөн зуун/ төгрөгийг Эйр тикет ХХК-руу тус тус шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д "ерөнхий нягтлан бодогч" гэж нягтлан бодох бүртгэл хөтлөх, удирдан зохион байгуулах, хариуцлага хүлээхээр аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагаас томилогдсон мэргэжлийн нягтлан бодогчийг; 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх";, 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дараа тайлангийн тооцооны хяналтыг хэрэгжүүлэхдээ мөнгөн хөрөнгийн журналын хөтлөлтийн үнэн зөв байдлыг алдагдуулахгүйгээр анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1004 /А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай" хууль болон Засгийн газрын 2017 оны "Журам батлах тухай" 340 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд хүүхэд асрах чөлөөтэй эхчүүдэд олгодог мөнгөн тэтгэмжтэй давхцуулж Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх хамтын гэрээнд 0-3 хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй эхчүүдэд сар бүр 500,000.00 /Таван зуун мянган/ төгрөг олгохоор тусгаж, тэтгэмжийн зардалд 1,263,746,208.00 /Нэг тэрбум хоёр зуун жаран гурван сая долоон зуун дөчин зургаан мянга хоёр зуун найман/ төгрөг, Үйлдвэрчний эвлэлийн 2 гишүүнд 3,000,000.00 /Гурван сая/ төгрөг нийт 1,266,746,208.00 /Нэг тэрбум хоёр зуун жаран зургаан сая долоон зуун дөчин зургаан мянга хоёр зуун найман/ төгрөг олгосон байна.


Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна:" 3.1.3-т "банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан;" 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал дэмжлэг олгох;" Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дугаар зүйлийн 139.1-т "Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.", Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж;" 7 дугаар зүйлийн 7.1-т "Энэ хуулийн 5.1.1, 5.1.2, 5.1.3-т заасан тэтгэмжийн хэмжээг Засгийн газар тогтооно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дүгээр зүйл. Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг: "10/ эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах;" Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "Журам батлах тухай" 340 дүгээр тогтоолын 2.-т "Жирэмсэн эхийн тэтгэмжийн хэмжээг сард 40.000 (дөчин мянган) төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг сард 50.000 (тавин мянган) төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 1.000.000 (нэг сая) төгрөг, 3 болон түүнээс дээш ихэр хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 3.000.000 (гурван сая) төгрөг байхаар тус тус тогтоосугай." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 -т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгалийн баялгийн хуваарилалтыг тэгш хүртэх, нийтийн эрх ашгийг хөндсөн зөрчлийг арилгаж, Хамтын гэрээний заалтыг холбогдох хууль тогтоомжийн заалттай нийцүүлэн боловсруулах биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1005/А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын тогтоол, дээд шатны байгууллагаас төсвийн жилийн дундуур, гэнэтийн шийдвэрүүдээр ирсэн чиглэлийн дагуу үйлдвэрийн үндсэн чиг үүрэгт хамааралгүй 33,582,725,694.40 /Гучин гурван тэрбум таван зуун наян хоёр сая долоон зуун хорин таван мянга зургаан зуун ерэн дөрвөн төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн санхүүжилт, дэмжлэг олгосон байгаа нь төрийн өмчит компаниудад ирэх төсвийн дарамтыг нэмэгдүүлж, үйлдвэрийн урт хугацааны төлөвлөлтийг удаашруулах, төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын ажлуудыг гацааж, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 127 дугаар тогтоолоор "Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нүхэн жорлонг орчин үеийн стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл"-д 17.54 сая ам.доллар буюу 59,628,984,000,000 /Тавин есөн тэрбум зургаан зуун хорин найман сая есөн зуун наян дөрвөн мянган/ төгрөг төлөвлөж, Сангийн яаманд шилжүүлсэн 24,179,434,715.40 /Хорин дөрвөн тэрбум нэг зуун далан есөн сая дөрвөн зуун гучин дөрвөн мянга долоон зуун арван таван төгрөг дөчин мөнгө/ төгрөг;
- Засгийн газрын 2025 оны 191 дүгээр тогтоолоор "Төрийн тахилгат Бурхан Халдун хайрханд хүндэтгэлийн цогцолбор барих ажил"-д 0.29 сая ам.доллар буюу 1,000,000,000.00 /Нэг тэрбум/ төгрөг төлөвлөж, тодотголоор 500,000,000.00 /Таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний жанжин штабт олгосон 1,500,000,000.00 /Нэг тэрбум таван зуун сая/ төгрөг;
- Засгийн газрын 2024 оны 221 дүгээр тогтоолоор Шинэ Хархорум хотын төв цэг, төв талбайн тохижилтын ажлын санхүүжилтэд Зэвсэгт хүчний 256 дугаар ангид 222,839,780.00 /Хоёр зуун хорин хоёр сая найман зуун гучин есөн мянга долоон зуун наян/ төгрөг, нэмэлт гэрээгээр 36,529,180.00 /Гучин зургаан сая таван зуун хорин есөн мянга нэг зуун наян/ төгрөг, бусад 109,587,540.00 /Нэг зуун есөн сая таван зуун наян долоон мянга таван зуун дөчин/ төгрөг, нийт 368,956,500.00 /Гурван зуун жаран найман сая есөн зуун тавин зургаан мянга таван зуун/ төгрөг, хотын төлөвлөлтөд тусгагдсан ногоон байгууламж, нарс мод тарих арчлах ажилд Бугантнандин ХХК-д урьдчилгаа төлбөрт олгосон 1,396,433,762.00 /Нэг тэрбум гурван зуун ерэн зургаан сая дөрвөн зуун гучин гурван мянга долоон зуун жаран хоёр/ төгрөг;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2024 оны ТГ/694 дүгээр албан бичиг, Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, Эрүүл Монгол Хүн үндэсний хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэс

медикал эмнэлгийн үйл ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд Улсын хоёрдугаар эмнэлэгтэй 2025 онд байгуулсан 25/32 дугаар хамтран ажиллах гэрээгээр "Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг хөгжүүлэх төсөл"-д 4,500,000,000.00 /Дөрвөн тэрбум таван зуун сая/ төгрөгийг төлөвлөж, дэмжлэг олгосон 4,490,969,794.00 /Дөрвөн тэрбум дөрвөн зуун ерэн сая есөн зуун жаран есөн мянга долоон зуун ерэн дөрвөн/ төгрөг;

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 02 тоот тэрбум мод үндэсний хөдөлгөөний албан бичгийн хүрээнд Говийн бүсэд мод үржүүлгийн газар байгуулах Техник эдийн засгийн үндэслэл хийх ажилд /Дундговь аймаг/-т олгосон 39,800,000.00 /Гучин есөн сая найман зуун мянган/ төгрөг;
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2025 оны ХЭГ/356 тоот, Эрдэнэс монгол ХХК-ийн 01/1319 тоот албан бичгээр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т 5 менежерийн орон тоог нэмэгдүүлснээр төлөвлөгдөөгүй зардлын гүйцэтгэл 1,607,130,923.00 /Нэг тэрбум зургаан зуун долоон сая нэг зуун гучин мянга есөн зуун хорин гурван/ төгрөг, Тухайлбал, дээрх томилгоотой холбоотойгоор 5 менежер, 2 нарийн бичиг, 1 жолоочийн цалин хөлсний зардалд 1,192,912,673.00 /Нэг тэрбум нэг зуун ерэн хоёр сая есөн зуун арван хоёр мянга зургаан зуун далан гурван/ төгрөг, тээвэр шатахууны зардалд 254,118,250.00 /Хоёр зуун тавин дөрвөн сая нэг зуун арван найман мянга хоёр зуун тавин/ төгрөг, тавилга эд хогшил, цахилгаан хэрэгсэлд 160,100,000.00 /Нэг зуун жаран сая нэг зуун мянган/ төгрөг.
- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг санхүүжүүлэхээр 12.08 сая ам.доллар буюу 41,079,376,000.00 /Дөчин нэгэн тэрбум далан есөн сая гурван зуун далан зургаан мянган/ төгрөг төлөвлөсөн, гүйцэтгэл гараагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна", 3.1.3-т "банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан," 4.1.34-т "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг", 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим", 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх," 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.", 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 зүйлийн 3-т "Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно.", 20 дугаар зүйл. "Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг", 3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах," Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Эрдэнэт үйлдвэр" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулах тухай" 102 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм"-ийн 4.1-т "Үйлдвэрийн газар


нь эд хөрөнгийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.”, Баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д “Энэ хуулийн 12.4, 12.6-д заасан хуулийн этгээд нь дүрэмд заасан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэхийг хориглоно.”, Улсын Их Хурлын 2024 оны “Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 09 дүгээр тогтоолын 3-т “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК болон төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдээс цаашид төсвийн шинжтэй, компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох арга хэмжээг авах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын захиргаа, үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний 3.16-д “Жилийн үр дүнгийн урамшууллыг (13 дахь сарын цалин) жилд нэг удаа дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр тооцож, журмын дагуу олгоно.”, Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын “Цалин хөлсний тухай журам”-ын 4.1-д “Үйлдвэрийн газрын болон тухайн бүтцийн нэгжийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд хамт олон, ажилтны оруулж буй хувь нэмэр, ажлын гүйцэтгэл, үр дүн, идэвх зүтгэлийг бодитоор үнэлж, ажилтнуудыг идэвхжүүлэх зорилгоор сар бүрийн ажлын үр дүнгийн урамшуулал, жилийн ажлын үр дүнгийн урамшууллыг олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”, 4.2.1.11 -т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйлдвэрийн газрын чиг үүрэгт хамааралгүй, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын болон урсгал зардал, нийгмийн шинжтэй зардлуудыг хууль тогтоомж зөрчиж, бизнес төлөвлөгөө, зорилтот түвшинд тусгуулан баталж, компанийн ашигт ажиллагааг бууруулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга (Ц.Одхүү)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1006/АД160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд Стандарт банктай холбоотой нийт 140,979,729,849.70 /Нэг зуун дөчин тэрбум есөн зуун далан есөн сая долоон зуун хорин есөн мянга найман зуун дөчин есөн төгрөг далан мөнгө/ төгрөгийн урт хугацаат авлага бүртгэлтэй байгаагаас 107,264,369,523.17 /Нэг зуун долоон тэрбум хоёр зуун жаран дөрвөн сая гурван зуун жаран есөн мянга таван зуун хорин гурван төгрөг арван долоон мөнгө/ төгрөгийн авлагыг Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2022 онд эцэслэн шийдвэрлэгдсэн боловч авлага өнөөг хүртэл барагдаагүй байна. Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Стандарт банктай холбоотой 33,715,360,326.53 /Гучин гурван тэрбум долоон зуун арван таван сая гурван зуун жаран мянга гурван зуун хорин зургаан төгрөг тавин гурван мөнгө/ төгрөгийн бусад зардлыг иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэх эрхтэй болохыг дурдсан боловч үйлдвэрийн газар нь иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл

холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”, 4.2.1.11 -т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр эцэслэн шийдвэрлэгдсэн авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, боломжит түргэн хугацаанд авлага барагдуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1007/АД160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд 110,677,597,285.35 /Нэг зуун арван тэрбум зургаан зуун далан долоон сая таван зуун ерэн долоон мянга хоёр зуун наян таван төгрөг гучин таван/ төгрөгийн урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл байгаагаас 48.8 хувь буюу 53,970,283,476.71 /Тавин гурван тэрбум есөн зуун далан сая хоёр зуун наян гурван мянга дөрвөн зуун далан зургаан төгрөг далан нэгэн мөнгө/ төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга үүссэн байна. Үүнээс 2004-2021 оны хооронд 98 бэлтгэн нийлүүлэгчийн гэрээт ажлын урьдчилгаанд төлсөн 21,142,745,835.55 /Хорин нэгэн тэрбум нэг зуун дөчин хоёр сая долоон зуун дөчин таван мянга найман зуун гучин таван төгрөг тавин таван мөнгө/ төгрөгийн ажлын гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас 94 бэлтгэн нийлүүлэгчийн 20,259,007,024.17 /Хорин тэрбум хоёр зуун тавин есөн сая долоон мянга хорин дөрвөн төгрөг арван долоон мөнгө/ төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга үүссэн бөгөөд авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11 -т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-76.Docx


1526181746

холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”, 4.2.1.11 -т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Найдваргүй авлагын хасагдуулгад тооцож бүртгэсэн он удаан жил болсон авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, 30-с доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1008/A0160075

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА - СТА - ТӨҮГ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад оронд болох хурал, зөвлөгөөн, уулзалт яармагт оролцох, гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан томилолтын зам хоног, зочид буудлын зардлын хэмжээ"-г мөрдөлгүй үйлдвэрийн ажилтнуудын гадаад томилолт, сургалтын зардлын хэмжээг албан тушаалын ангилал тус бүрээр харилцан адилгүй тогтоож олгосон байна. Тайлант хугацаанд аудитын түүвэрт хамрагдсан 35 гадаад томилолтын зардлыг тулган баталгаажуулахад Сангийн сайдын баталсан гадаад албан томилолтын зардлын хэмжээг 207,533,351.29 /Хоёр зуун долоон сая таван зуун гучин гурван мянга гурван зуун тавин нэгэн төгрөг хорин есөн мөнгө/ төгрөгөөр хэтрүүлэн олгож, өмнөх аудитаар хүргүүлсэн 681/A0170064/СНАГ-2025/098/НА-СТА-ТӨҮГ албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9-д "улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох", 20.1.10-д "эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Сангийн сайдын 2018 оны "Гадаад томилолтын зардлын хэмжээг батлах тухай" 188 дугаар тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажилтныг албан томилолтоор ажиллуулах тухай журмыг эрх бүхий байгууллагын баталсан "Гадаад томилолтын зардлын хэмжээг батлах тухай" журамтай нийцүүлэн боловсруулах, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ерөнхий захирал (Г.Ёндон)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1009/А0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА -СТА -ТӨҮГ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдөр ирүүлж, хуулийн хугацааг хоцроосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", 70 дугаар зүйлийн 70.1-д "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайланг хуульд заагдсан хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлээгүй албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ерөнхий захирал (Г.Ёндон)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1010/A0160075

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА-СТА - ТӨҮГ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн 676/A0170064/СНАГ-2025/098/НА-СТА-ТӨҮГ болон 682/A0170064/СНАГ-2025/098/НА-СТА-ТӨҮГ албан шаардлагын хэрэгжилтийг биелүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Эрдэнэс ус ДТС ОНӨХК-ийн 6,438,514,068.55 /Зургаан тэрбум дөрвөн зуун гучин найман сая таван зуун арван дөрвөн мянга жаран найман төгрөг тавин таван мөнгө/ төгрөг, Ачит-Ихт ХХК-ийн 2,708,891,843.47 /Хоёр тэрбум долоон зуун найман сая найман зуун ерэн нэгэн мянга найман зуун дөчин гурван төгрөг дөчин долоон мөнгө/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий захиралд даалгасан асуудал шийдэгдээгүй, Ачит ихт ХХК ногдол ашиг нөхөж төлөөгүй, байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөрийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй, үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа нь Ачит ихт ХХК Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлийг хууль бус захиргааны акт тул хүчингүй болгох тухай нэхэмжлэхийг шүүхэд гаргаж, байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагыг өөрийн эзэмшлийн талбайд нэвтрүүлээгүй мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/197 тоот албан бичгээр "Ачит ихт ХХК-ийн катодын зэс боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоосноос байгаль орчны болон технологийн ноцтой эрсдэл үүсэж буй тул эрсдэлийг бууруулах шаардлагын үүднээс үйлдвэрлэлийн ус, цахилгаан, зам ашиглалтын хязгаарлалтыг зогсоож, үйл ажиллагааг 2024 оны 08 дугаар сарын 21-ны өдрөөс эхлэн эрсдэл бүрэн арилгах хүртэл хэвийн явуулах" тухай чиглэл хүргүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\03\6 SAГ-76.Docx

1526181792

болно.", Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т "Баялгийн сангийн хөрөнгө нь нийт ард түмний мэдэлд байх", 5.1.2-т "газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх", 11 дүгээр зүйлийн 11.1.2-т "...уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашгийг", Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл, Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т "Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй буруутай албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ерөнхий захирал (Г.Ёндон)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР АУДИТЫН МЕНЕЖЕР АХЛАХ АУДИТОР АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ П.ЧАНЦАЛДУЛАМ Ж.НЯМЦЭЦЭГ Г.ТЭЛМҮҮН
--	--	--



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1011/АД160066

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний 1.3-т заасны дагуу +/-5 хувийн тоо хэмжээний хэлбэлзэлтэй уялдуулан гэрээний үнийн дүнг нийт 2,551,571,530.17 /Хоёр тэрбум таван зуун тавин нэгэн сая таван зуун далан нэгэн мянга таван зуун гучин төгрөг арван долоон мөнгө/-өөр нэмэгдүүлсэн байна. Үүнд:

- Сан петролиум ХХК-тай байгуулсан "Өвлийн дизель түлш евро 5"-г нийлүүлэх 2025/07-Н-0093 дугаартай гэрээнд заасны дагуу 6,536.0 мянган килограммыг 7-50 хоногийн дотор богино хугацаанд нийлүүлсэн боловч гэрээний 1.3-т заасныг үндэслэн +/-5 хувийн тоо хэмжээний хэлбэлзлийг тооцож 307.2 килограмм буюу 980,012,660.10 /Есөн зуун наян сая арван хоёр мянга зургаан зуун жаран төгрөг арван мөнгө/;
- Jinan Libao Mine Accessories Co.,Ltd компанитай 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 2025/10-11-0085 дугаартай, 1,410,750.00 ам.доллаароор ган бөөрөнцөг ф125 /багц 1,2/-ыг худалдан авах гэрээг, 282,975.00 ам.долларын нэмэлт гэрээг, нийт 1,693,725.00 ам.долларын гэрээг байгуулж, гүйцэтгэлээр 1,477,924.80 ам.долларыг олгож, +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож 78,769.35 ам.доллар буюу 275,836,872.91 /Хоёр зуун далан таван сая найман зуун гучин зургаан мянга найман зуун далан хоёр төгрөг ерэн нэгэн мөнгө/ ;
- Шинэгантиг ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр 2025/11-38-0048 дугаартай "Баяжмалын уутны бэлдэц Багц 1"-ийг худалдан авах 5,783,461,200.00 /Таван тэрбум долоон зуун наян гурван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга хоёр зуун/ төгрөгийн гэрээг байгуулж, гүйцэтгэлээр 6,044,350,740.00 /Зургаан тэрбум дөчин дөрвөн сая гурван зуун тавин мянга долоон зуун дөчин /төгрөгийг олгож, +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож 260,889,540.00 /Хоёр зуун жаран сая найман зуун наян есөн мянга таван зуун дөч/ төгрөг;
- Yiwu Hongtai Import and Export Co Ltd компанитай 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр 2025/07-11-0001 дугаартай, 1,440,000.00 ам.доллаароор 2000 тонн хүхэрт натрийг худалдан авах гэрээ байгуулж, гүйцэтгэлээр +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож, 85.8 тонн 61,798.32 ам.доллар буюу 246,749,040.00 /Хоёр зуун дөчин зургаан сая долоон зуун дөчин есөн мянга дөчин/ төгрөг;
- Yiwu Hongtai Import and Export Co.,Ltd компанитай 2025/05-11-0140 дугаартай гэрээнд 2000 тонн хүхэрт натрийг 1,300,000.00 ам.доллаароор худалдан авахаар тусгаж, гүйцэтгэлээр +/-5 хувийн хэлбэлзлийг тооцож 78.0 тонн 50,710.40 ам.доллар

буюу 189,355,984.96 /Нэг зуун наян есөн сая гурван зуун тавин таван мянга есөн зуун наян дөрвөн төгрөг ерэн зургаан мөнгө/ төгрөг;

- Мөн нээлттэй тендер шалгаруулалтын аргаар шалгаруулж, үр дүн гарсан 19 ажлын гэрээний үнийн дүнг нийт 598,727,432.20 /Таван зуун ерэн найман сая долоон зуун хорин долоон мянга дөрвөн зуун гучин хоёр төгрөг хорин мөнгө/-өөр тус тус нэмэгдүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 36 дугаар зүйлийн 36.1-т "Захиалагч дараах нөхцөлд нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж болно", 36.1.3-т "нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол", 36.1.4-т "нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан ажлын нэмэлт ажлын өртөг анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрэхгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол", 39 дүгээр зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно", 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:" 39.3.1-д "гэрээний үнэ", 39.3.8-д "гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал", 40 дугаар зүйлийн 40.1.2-т "энэ хуулийн 11.11-д заасан нөхцөл, аргачлалын дагуу гэрээний үнийг тохируулах" гэж заасантай тус тус нийцэхгүй, Баяжмалын уутны бэлдэц I худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичгийн II бүлэг. Өгөгдлийн хүснэгт: ТШЗ 21.5-д "Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: "Тохируулахгүй тогтмол байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу нэмэлт гэрээ байгуулалгүйгээр, гэрээний заалтад тусгаж, төсөвт өртгийг хэтрүүлэн худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1012/АД160066

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Хүнд механизм худалдан авах ЭҮТӨҮГ/202402681 дугаартай тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасныг зөрчин "Майнс ап" ХХК-аас 2023 онд үйлдвэрлэсэн 3,699,000,000.00 /Гурван тэрбум зургаан зуун ерэн есөн сая/ төгрөгийн өртөгтэй "Гинжит бульдозер Liebherr PR 776"-г Чанарын хяналтын хэлтсийн актаар хүлээн авсан байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно", 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:", 39.3.1-д "гэрээний үнэ", 39.3.8-д "гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал", 40 дүгээр зүйлийн 40.1.1-д "захуалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах", 40.1.2-т "энэ хуулийн 11.11-д заасан нөхцөл, аргачлалын дагуу гэрээний үнийг тохируулах" гэж заасныг мөрдөөгүй, мөн Хүнд механизм худалдан авах ЭҮТӨҮГ/202402681 дугаартай тендерийн баримт бичиг, Ү24/10-8290 техникийн тодорхойлолтын 7-д "Үйлдвэрлэсэн огноо: шинэ, 2024 ба 2025 онд үйлдвэрлэсэн байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заагдаагүй хөрөнгө худалдан авч, зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Ч.МӨНХБУЛГАН

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0316\SAG-76.Docx

1526181770



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1013/А0160066

Улаанбаатар хот

САГ - 2026/101/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний дүнгээс 2,921,720,474.51 /Хоёр тэрбум есөн зуун хорин нэгэн сая долоон зуун хорин мянга дөрвөн зуун далан дөрвөн төгрөг тавин нэгэн мөнгө/ төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна. Үүнд:

- Yiwu Hongtai Import and Export Co.Ltd компанитай 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр 2025/07-11-0001 дугаартай, 1,440,000.00 ам.доллаар 2000 тонн хүхэрт натрийг худалдан авах гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нэмэлт гэрээ байгуулаагүй, +/-5%-ийн хэлбэлзлийг тооцож олгосноос гадна гэрээний үнийн дүнг 107.0 тонн 77,018.24 ам.доллар буюу 275,099,911.09 /Хоёр зуун далан таван сая ерэн есөн мянга есөн зуун арван нэгэн төгрөг есөн мөнгө/-өөр нэмэгдүүлж худалдан авалт хийсэн;
- Шарын гол ХК-тай 2024 онд байгуулсан "Эрчим хүчний нүүрс"-ний 29,007,000,000.00 /Хорин есөн тэрбум долоон сая/ төгрөгийн гэрээг -/+5 хувийн нөхцөлтэйгээр худалдан авсан бөгөөд гүйцэтгэлээр 33,103,970,563.42.00 /Гучин гурван тэрбум нэг зуун гурван сая есөн зуун далан мянга таван зуун жаран гурван төгрөг дөчин хоёр мөнгө/ төгрөгийн бараа материал авсан нь гэрээнд заасан нийлүүлэлтээс 2,646,620,563.42 /Хоёр тэрбум зургаан зуун дөчин зургаан сая зургаан зуун хорин мянга таван зуун жаран гурван төгрөг дөчин хоёр мөнгө/-өөр давсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 39 дүгээр зүйлийн 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно", 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:", 39.3.1-д "гэрээний үнэ", 39.3.8-д "гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал", 40 дугаар зүйлийн 40.1.2-т "энэ хуулийн 11.11-д заасан нөхцөл, аргачлалын дагуу гэрээний үнийг тохируулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцагчтай байгуулсан гэрээний үнийн дүнгээс хэтрүүлсэн, нэмэлт гэрээ байгуулаагүй, төлөвлөгдөөгүй худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1014/А0160066

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй, нэг эх үүсвэрээс худалдан авалт хийхдээ албан ёсны эрхийг төлөөлж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулсан туршлага, тендер шалгаруулалтад оролцсон, гүйцэтгэсэн ажлын үр дүн, эрхээ хязгаарлуулсан эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан эсвэл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд эсэхийг магадалж, цаашид нийлүүлэгчээс шалтгаалсан үйлдвэрт учирч болзошгүй эрсдэлийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээг үйл ажиллагаанд ашиглах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Беллинк ХХК-тай "Хүнд даацын өөрөө буулгагч автомашины сэлбэг"-ийг 22,944,795,367.50 /Хорин хоёр тэрбум есөн зуун дөчин дөрвөн сая долоон зуун ерэн таван мянга гурван зуун жаран долоон төгрөг тавин мөнгө/-өөр худалдан авах №2025/03-20-0227 дугаар гэрээг 2025 оны 7 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан ба 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрээний хугацааг он дуустал сунгасан боловч 2025 оны жилийн эцсийн байдлаар бараа материалыг дутуу нийлүүлсэн, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ", 7.1.9-д "энэ хуулийн 56.5.3, 56.5.4, 56.5.5-д заасан үндэслэлээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд" гэж заасантай тус тус нийцээгүй, Худалдах худалдан авах №2025/03-20-0227 дугаар гэрээний 10.2-т "Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал энэ тухайгаа уг нөхцөл байдал үүссэнээс хойш бараа нийлүүлэх хугацаанд багтаж 10 хоногийн дотор нөгөө талд бичиг (албан ёсны цахим шуудан болон цаасаар)-ээр мэдэгдэнэ. Уг мэдэгдэл нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим эсхүл эрх бүхий байгууллагаар баталгаажсан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй аж ахуйн нэгжийн урьдчилгаа төлбөрийн баталгааг арилжааны банкнаас үл маргах журмаар гаргуулах, гэрээг дүгнэж алданги тооцох, эсхүл гэрээг цуцлах, байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1015/А0160066

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тодотгол хийгээгүй нийт 1,456,673,038.00 /Нэг тэрбум дөрвөн зуун тавин зургаан сая зургаан зуун далан гурван мянга гучин найм/ төгрөгийн дараах ажлууд байна. Үүнд:

- "Хүдэр бэлтгэх нэгдүгээр шатны бутлуурын шинэчлэлийн ажил Багц-2+"-ын ЭҮТӨҮГ/202501011408 дугаартай худалдан авах ажиллагаанд Барилга хөгжлийн төвийн магадлалыг үндэслэн зураг төслийн ажлын зохиогчийн хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээг 1,276,673,038.00 /Нэг тэрбум хоёр зуун далан зургаан сая зургаан зуун далан гурван мянга гучин найман/ төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан;
- Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авахаар Өмгөөллийн Онч Нүүдэл ХХН-тэй 2025.05.06-нд Ачит Ихт ХХК-ийн 2024.05.24-ний 1/179 дугаар албан бичгээр Захиргааны хэргийн давж заалдах анхан шатны шүүхэд Засгийн газрын 2024 оны 16 дугаар тэмдэглэлийн 26.5-ийн 1.2 дугаар хэсэгт заасан шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасантай холбоотой Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2024 оны А-1/1588 дугаар албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу гэрээ шууд байгуулах аргаар 180,000,000.00 /Нэг зуун наян сая/ төгрөгийн гэрээ байгуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-76.Docx


1526181776

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй, төсөвт төлөвлөөгүй арга хэмжээг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1016/АД160066

Улаанбаатар хот

САГ-2026/101/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс 18,804,733,720.40 /Арван найман тэрбум найман зуун дөрвөн сая долоон зуун гучин гурван мянга долоон зуун хорин төгрөг дөчин мөнгө/-ийн үнийн дүн бүхий 45 гэрээ байгуулсан 31 аж ахуйн нэгж байгууллага нь гэрээнд заасан хугацаанд бараа материалыг бүрэн нийлүүлэхгүй, гэрээний үүргээ биелүүлэхгүй байгаа нь үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа доголдох эрсдэлийг дагуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина", 48 дугаар зүйлийн 48.2.7-д "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх", Худалдах, худалдан авах гэрээний 5 дугаар зүйлийн 5.2.1-д "Гэрээнд заасан чанар, стандартын шаардлагад нийцсэн, тоо хэмжээ, иж бүрдэл бүхий биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй барааг дагалдах баримт бичгийн хамт заасан хугацаанд нийлүүлэх мөн шинэ байх ба ашиглагдсанаас хойш баталгаат хугацаа 12 сар байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-д "Гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу барааг нийлүүлэхийг худалдагчаас шаардах", 9 дүгээр зүйлийн 9.1-д "Худалдагч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг худалдан авагчид төлөх ба алдангийн нийт дүн нийт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй бэх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-76.Docx

1526181778

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулахаас өмнө тендерийн баримт бичиг, оролцогчид тавих шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, шаардлагад нийцэж байгаа эсэхийг бүрэн нягтлаагүй, харилцагч талуудын гэрээний эрх, үүргийн заалт, хариуцлагын асуудлыг нэмэгдүүлж гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах гэрээний хэрэгжилтээс хамаарах аливаа эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1017/АД160066

Улаанбаатар хот

САГ-2026/101/ИА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2 төрлийн нийт 992,720,000.00 /Есөн зуун ерэн хоёр сая долоон зуун хорин мянга/ төгрөгийн үйлчилгээг худалдан авах ажиллагааны цахим системээр зарлаагүй байна. Үүнд:

- Оюутын талбайн археологийн хайгуул, судалгааны ажил хийлгэхээр харьцуулалтын аргаар шалгаруулахаар төлөвлөгөөнд тусгасан ч худалдан авах ажиллагааны цахим системээр зарлаагүй Монгол Улсын Их Сургуулийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэнтэй 44,720,000.00 /Дөчин дөрвөн сая долоон зуун хорин мянган/ төгрөгийн гэрээг шууд байгуулсан;
- Санхүүгийн тайланд олон улсын хөндлөнгийн аудит хийлгэх 1,000,000,000.00 /Нэг тэрбум/ төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулахаар төлөвлөгөөнд тусгасан боловч худалдан авах ажиллагааны цахим системд нийтлээгүй, Кэй Пи Эм Жи Аудит ХХК-тай 948,000,000.00 /Есөн зуун дөчин найман сая/ төгрөгийн гэрээг шууд байгуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана", 32 дугаар зүйлийн 32.1-д "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ", 32.2-т "Нээлттэй тендер шалгаруулалтын зарлалыг энэ хуулийн 18.1-д заасны дагуу нийтэлнэ", 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z:\Alban Shaardlaga\2026\0316 SACI-76.Docx

1526181780

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалт явуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1018/АД160066

Улаанбаатар хот

САГ - 2026/101/ИА-СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүйгээс шалтгаалан "Хүнд даацын өөрөө буулгагч автомашин" ижил төрлийн 8 авто тээврийн хэрэгслийг худалдан авахдаа 2 тусад нь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, Трансвест Монголиа ХХК 2 тендерт шалгарч, Уул уурхайн хүнд даацын өөрөө буулгагч автомашин Komatsu HD1500-8 маркийн тээврийн хэрэгслийн нэгжийн үнийн дүнг 584,505,452.30 /Таван зуун наян дөрвөн сая таван зуун таван мянга дөрвөн зуун тавин хоёр төгрөг гучин мөнгө/, нийт 2,338,021,809.20 /Хоёр тэрбум гурван зуун гучин найман сая хорин нэгэн мянга найман зуун есөн төгрөг хорин мөнгө/-ийн зөрүүтэй 2 гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Komatsu HD1500-8 уурхайн хүнд даацын өөрөө буулгагч 4 автомашиныг 2025.06.18-ны өдрийн 2025/03-20-0211 тоот гэрээгээр нэгж тээврийн хэрэгслийг 9,334,346,179.55 /Есөн тэрбум гурван зуун гучин дөрвөн сая гурван зуун дөчин зургаан мянга нэг зуун далан есөн төгрөг тавин таван мөнгө/-өөр нийт 37,337,384,719.00 /Гучин долоон тэрбум гурван зуун гучин долоон сая гурван зуун наян дөрвөн мянга долоон зуун арван ес/ төгрөгөөр;
- Komatsu HD1500-8 уурхайн хүнд даацын өөрөө буулгагч 4 автомашиныг 2025.11.10-ны өдрийн 2025/10-20-0460 тоот гэрээгээр нэгж тээврийн хэрэгслийг 8,749,840,727.25 /Найман тэрбум долоон зуун дөчин есөн сая найман зуун дөчин мянга долоон зуун хорин долоон төгрөг, хорин таван мөнгө/-өөр нийт 34,999,362,909.00 /Гучин дөрвөн тэрбум есөн зуун ерэн есөн сая гурван зуун жаран хоёр мянга есөн зуун ес/ төгрөгөөр тус тус гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-76.Docx


1526181782

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бодитой төлөвлөж, нэмэлтээр шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаас өмнө хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж ажиллаагүй, нэг бараа ажил үйлчилгээг нэг аж ахуйн нэгжээс, нэг тайлант хугацаанд, өөр үнээр худалдан авч илүү зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1019/АД 160066

Улаанбаатар хот

САГ - 2026/101/ИА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ЭҮТӨҮГ/20250102007 тендер шалгаруулалтын дугаартай 36,122,130,000.00 /Гучин зургаан тэрбум нэг зуун хорин хоёр сая нэг зуун гучин мянга/ төгрөгийн төсөвт өртөгтэй "Өвлийн дизель түлш I"-ийг Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авахаар төлөвлөсөн ч тус тендер шалгаруулалттай холбоотой нийт 9,886,181,400.00 /Есөн тэрбум найман зуун наян зургаан сая нэг зуун наян нэгэн мянга дөрвөн зуун/ төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Тус ажлын төсөвт өртгөөс технологийн нормчлогдсон материалын нөөц бүрдүүлж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангах зайлшгүй шаардлагаар "Сод Монгол групп" ХХК-тай 2024 онд "Зуны дизель түлш" нийлүүлэхээр байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан тус гэрээний техникийн тодорхойлолтод тусгагдаагүй өвлийн евро 5 дизель түлшийг худалдан авахаар 2025.02.07-нд нэмэлт гэрээ байгуулан 9,395,100,000.00 /Есөн тэрбум гурван зуун ерэн таван сая нэг зуун мянга/ төгрөгийн дизель түлшийг тухайн нийлүүлэх барааны зах зээлийн үнэлгээг үл харгалзан зуны дизель түлш худалдан авсан нэгжийн үнийн дүнгээр тооцоолон нэмэлт гэрээ байгуулсан;
- Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагддаг өвөл, зуны дизель түлшний худалдан авах гэрээнд бараа нийлүүлэх хуваарийг оновчтой тодорхойлоогүй, нөөц агуулах савны багтаамж хүрэлцээг тооцоогүй зэргээс гэрээний хугацааг сунгаж, нийлүүлэгч "Шунхлай групп" ХХК-д шатахуун хадгалалтын хөлсөнд 491,081,400.00 /Дөрвөн зуун ерэн нэгэн сая наян нэгэн мянга дөрвөн зуун/ төгрөг төлж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 41 дүгээр зүйлийн 41.1.1-д "энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө",

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй оүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAC-76.Docx

1526181784

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд тогтмол ашиглагддаг бараа материалын худалдан авалтыг үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангаж, хуулийн хүрээнд оновчтой төлөвлөж, зохион байгуулж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1020/АД160066

Улаанбаатар хот

САГ - 2026/101/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын худалдан авах ажиллагаанд оролцож буй байгууллагуудын өмнөх шалгарсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл болон олон гэрээг давхардуулан авч буй эсэхийг үнэлгээний хороо үнэлдэггүйгээс 7 багцтай тендер шалгаруулалтын 5 багцад нэр бүхий 2 компани шалгарч нийт 19,358,082,000.00 /Арван есөн тэрбум гурван зуун тавин найман сая наян хоёр мянган/ төгрөгийн гэрээг байгуулсан нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлтийг хангахгүй, гэрээнд заасан хугацаанд барааг нийлүүлэхгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байх эрсдэлтэй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 26 дугаар зүйлийн 26.9-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ", 27 дугаар зүйлийн 27.9-д "Багцтай тендер шалгаруулалтын багц тус бүрд үнэлгээ хийх ба оролцогч хоёр ба түүнээс дээш багцад хамгийн сайн тендер ирүүлсэн бол оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадавхыг магадална", 27.10-т "Хэд хэдэн багцад шалгарсан оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадавхыг магадлахад аль нэг багцад шаардлага хангахгүй бол түүний чадавхын шаардлага хангах багцуудаас гэрээний үнэ хамгийн өндөр байх нэг, эсхүл түүнээс дээш тооны багцад гэрээ байгуулах эрх олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны тендэрт оролцож байгаа аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхыг үнэлэхдээ тухайн аж ахуйн нэгжийн өмнө шалгарсан дуусаагүй ажлын төсөвт өртгийн нийлбэрээс тооцож бодитой үнэлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА
Ч.МӨНХБУЛГАН

9006 03
ATA 1987
902502411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1021/АДИ75042

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2014 онд Номун Гранд ХХК-тай өр барагдуулах гэрээ байгуулж, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 7 дугаар багийн Дэнжийн 49 дүгээр байрны нийт 28 айлын 919.9 мкв талбай бүхий 1-2 өрөө орон сууцыг хүлээн авсан ба 28 ажилтан, ахмад настантай "Орон сууц зээлээр худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулснаас 13 ажилтан нь хуваарийн дагуу орон сууцны төлбөрийг бүрэн төлж, өөрийн өмчлөлд шилжүүлэн авах эрх үүссэн ба үндсэн хөрөнгийг данснаас хасах эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байхад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны А-2/1993 дугаар "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгээр Орхон аймгийн орон сууц хувьчлах товчоонд өмчлөх асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-ын 2 дахь хэсэг "Төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө", 11 дүгээр зүйл "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх", 11.8 дахь хэсэгт "төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах", 16 дугаар зүйл 16.2-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн албаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр баталгаажаагүй хөрөнгийн асуудлыг дур мэдэн шийдвэрлэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1022/A0175042

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА-СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны жилийн эцсийн тооллогоор нийт 197,915,042.50 /Нэг зуун ерэн долоон сая есөн зуун арван таван мянга дөчин хоёр төгрөг, тавин мөнгө/ төгрөгийн хөрөнгө тоологдоогүй биетээр оршин байхгүй байна. Үүнд:

- Бараа материалын дансанд бүртгэлтэй 97,742,610.00 /Ерэн долоон сая долоон зуун дөчин хоёр мянга зургаан зуун арав/ төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ширхэг МПЭ-350-9006У2 маркийн цахилгаан хөдөлгүүр эд хөрөнгийн тооллогоор дутагдсан ба холбогдох хууль хяналтын байгууллагад хандсан боловч шийдвэрлүүлэх явц удаашралтай;
- Үндсэн хөрөнгийн дансанд Аж ахуй, үйлчилгээний цехэд бүртгэлтэй 24,721,576.00 /Хорин дөрвөн сая долоон зуун хорин нэгэн мянга таван зуун далан зургаа/ төгрөгийн анхны өртөгтэй, 27 ширхэг тавилга, эд хогшил дутагдсан;
- Аж ахуй, үйлчилгээний цехийн орон сууцны хэсэгт бүртгэлтэй 75,450,856.50 /Далан таван сая дөрвөн зуун тавин мянга найман зуун тавин зургаан төгрөг тавин мөнгө/ төгрөгийн анхны өртөгтэй, 64 ширхэг тавилга, эд хогшил биетээр тоологдоогүй.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгийн тооллогоор дутагдсан хөрөнгийг тухайн хөрөнгийг ашиглахаар бүртгэлд тусгасан албан хаагчдаар нөхөн төлүүлээгүй, үйлдвэрийн газрын хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1023/А0175042

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын данс бүртгэлд тусгаагүй эзэмших, ашиглах эрхтэй газар, орон сууцтай холбоотой нийт 27,112,590,000.00 /Хорин долоон тэрбум нэг зуун арван хоёр сая таван зуун ерэн мянган/ төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Орхон аймгийн Баян-Өндөр сумын Зэст багийн нутаг, Цагаанчулуутын аманд байрлах Уурхайчин-2, Уурхайчин-3 хорооллын 26,288,250,000.00 /Хорин зургаан тэрбум хоёр зуун наян найман сая хоёр зуун тавин мянга/ төгрөгийн үнэлгээтэй 4 өмчлөх эрхийн 72.63 га газрын өмчлөх эрхийн хугацаа 2021 онд дууссан бөгөөд 2022 онд Орхон аймгийн Засаг даргын захирамжаар тус газраас нийтийн эзэмшлийн шугам сүлжээ, зам талбайг хасаж, газрын хэмжээг 56.05 га болгон 5 газрын гэрчилгээ олгосон боловч шинэчлэн олгосон газрын үнэлгээг хийлгэж, үндсэн хөрөнгөд бүртгээгүй;
- Үндсэн хөрөнгийн дансанд уул уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламж, зуслан, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаас бусад, худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор, амралтын газар зэрэг үйл ажиллагааны зориулалтаар 2019-2025 онуудад газар эзэмших эрхийн гэрчилгээг олгосон нийт 11,394.8 га талбайн хэмжээтэй 22 газрыг балансад бүртгээгүй;
- Амины орон сууцны зориулалттай, 6104143421 нэгж талбарын дугаартай, 1,546 мкв газрын эзэмших эрхийн хугацаа дууссан, тус газар хаана байрлалтай, газар эзэмших эрхийн хугацааг сунгасан эсэх талаар мэдээлэл тодорхойгүй;
- Неман констракшн ХХК-тай 2021 онд орон сууцны фонд бүрдүүлэхээр 2021/14/30/0698 дугаартай "Худалдах, худалдан авах" гэрээг байгуулсан. Тус гэрээний нөхцөлд заасан 4 өөр талбайн хэмжээтэй 18 орон сууцыг хүлээн авахаас гүйцэтгэлээр "Уурхайчин-1" хороололд 13 орон сууцыг хүлээн авч, 99.92 мкв талбайн хэмжээтэй 3 өрөө, нийт 824,340,000.00 /Найман зуун хорин дөрвөн сая гурван зуун дөчин мянга/ төгрөгийн анхны өртөгтэй 5 орон сууцыг хүлээн аваагүй, данс бүртгэлд тусгаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт", 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага";, 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах";, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн

16.1-ын 1 дэх хэсэгт "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйлдвэрийн газрын эзэмшилтэй боловч данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийг бүртгэлжүүлээгүй, хугацаа дууссан газрын эрхийг сунгуулаагүй, өмч хөрөнгөд тавих хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1024/А0175042

Улаанбаатар хот

САГ - 2026/101/ИА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын барилга байгууламжийн данстай холбоотой нийт 10,314,710,499.12 /Арван тэрбум гурван зуун арван дөрвөн сая долоон зуун арван мянга дөрвөн зуун ерэн есөн төгрөг арван хоёр мөнгө/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Тус ТӨҮГ нь 2021 онд нэр бүхий 2 компанитай Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4-р баг, Хүрэнбулаг Цагаанчулуутын ам 0 тоот газарт "Уурхайчин-1" хороололд орон сууцны фонд бүрдүүлэхээр Худалдах худалдан авах гэрээг байгуулж, 6,448,236,960.33 /Зургаан тэрбум дөрвөн зуун дөчин найман сая хоёр зуун гучин зургаан мянга есөн зуун жаран төгрөг гучин гурван мөнгө/-ийн анхны өртөгтэй 27 орон сууцыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн боловч орон сууцны өмчлөх эрхийн гэрчилгээг одоог хүртэл Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын нэр дээр гаргуулаагүй;
- Эко хороололд нийт 2,107,337,541.12 /Хоёр тэрбум нэг зуун долоон сая гурван зуун гучин долоон мянга таван зуун дөчин нэгэн төгрөг арван хоёр мөнгө/ төгрөгийн анхны өртөгтэй, тус бүр 116 мкв талбайтай, 2 давхар 4 ширхэг хаус, нийт 1,759,135,997.67 /Нэг тэрбум долоон зуун тавин есөн сая нэг зуун гучин таван мянга есөн зуун ерэн долоон төгрөг жаран долоон мөнгө/ төгрөгийн анхны өртөгтэй тус бүр 50-64 мкв талбайтай 3 өрөө 6 ширхэг амины орон сууц бүртгэлтэй бөгөөд тухайн хороололд ямар албан тушаалтан ямар нөхцөлөөр амьдардаг нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах.", 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна", 16 дугаар зүйлийн 16.1-ын 1 дэх хэсэгт "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмч харууцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-76.Docx

1526181764

тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйлдвэрийн газрын хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, орон сууц, түүнд оршин сууж байгаа этгээд тодорхойгүй, бүртгэлжүүлээгүй, мэдээллийн сан үүсгэж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 1025/А0175042

Улаанбаатар хот

САГ - 2026/101/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2025 оны А/351, А/352 дугаар Бээжин дэх худалдааны төлөөлөгчийн газар, Москва дах худалдааны төлөөлөгчийн газруудыг татан буулгах тухай тушаал гаргасан ч нийт 9,554,661,491.47 /Есөн тэрбум таван зуун тавин дөрвөн сая зургаан зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун ерэн нэгэн төгрөг дөчин долоон мөнгө/ төгрөгийн хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах талаар тушаал, шийдвэр гараагүй, хөрөнгийн асуудлыг шийдээгүй байна. Үүнд:

- Бээжин дэх худалдааны төлөөлөгчийн газарт бүртгэлтэй нийт 3,058,062,992.11 /Гурван тэрбум тавин найман сая жаран хоёр мянга есөн зуун ерэн хоёр төгрөг арван нэгэн мөнгө/ төгрөгийн төлөөлөгчийн газрын оффис, 3 өрөө байр, "Mercedes Benz V260" маркийн автомашин болон тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүд;
- Москва дахь худалдааны төлөөлөгчийн газарт бүртгэлтэй нийт 6,496,598,499.36 /Зургаан тэрбум дөрвөн зуун ерэн зургаан сая таван зуун ерэн найман мянга дөрвөн зуун ерэн есөн төгрөг гучин зургаан мөнгө/ төгрөгийн 4 орон сууц, "Volkswagen Caravelle" маркийн микроавтобус, TOYOTA ALPHARD, TOYOTA LAND CRUISER PRADO-150 автомашин, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүд.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ийн 1 дэх хэсэгт "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө",

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alhan Sh aardlaga\2026\0316 SAG-76.Docx

1526181766

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татан буугдсан төлөөлөгчийн газрын хөрөнгийг шаардлагатай алба хэлтэст шилжүүлээгүй, тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал (Г.Ёндон), Захиргаа, удирдлага, санхүүгийн газрын дарга (Д.Баярбат), Ерөнхий нягтлан бодогч (Т.Очирхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН